

Б.Ариунтунгалаг, Б.Гантулга, Д.Хишигжаргал

# МАТЕМАТИК

## II

Ерөнхий боловсролын сургуулийн  
2 дугаар ангийн сурах бичиг

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамны  
зөвшөөрлөөр хэвлэв.

Долоо дахь хэвлэл

СУРГУУЛИЙН НОМЫН САНД ОЛГОВ.  
БОРЛУУЛАХЫГ ХОРИГЛОНО.

Улаанбаатар хот  
2020 он

DDC  
371.32  
M-294

Математик II: Ерөнхий боловсролын сургуулийн 2 дугаар ангийн сурах бичиг.  
/Ариунтунгалаг Б., ба бус; Ред. Ганцэцэг Ч. - УБ.2014.-152х./

Энэхүү сурах бичиг нь "Монгол Улсын Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай" хуулиар хамгаалагдсан бөгөөд Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамнаас бичгээр авсан зөршөөрлөөс бусад тохиолдолд цахим болон хэвлэмэл хэлбэрээр, бүтнээр эсхүл хэсэгчлэн хувилах, хэвлэх аливаа хэлбэрээр мэдээллийн санд оруулахыг хориглоно.

Сурах бичгийн талаарх аливаа санал, хүсэлтээ [textbook@mecs.gov.mn](mailto:textbook@mecs.gov.mn) хаягаар ирүүлнэ үү.

© Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам

ISBN 978-99973-69-31-4

# ГАРЧИГ

Давтах.....	4
100 дотор нэмэх, хасах.....	12
Өнцөг ба дүрс.....	24
Үржүүлэх.....	30
Уртыг хэмжих.....	51
Хуваах.....	60
Хугацааг хэмжих .....	84
1000 хүртэлх тоог таних .....	90
1000 дотор нэмэх, хасах.....	98
Хоёр оронтой тоог 2 дахин ихэсгэх .....	122
Үлдэгдэлтэй хуваах.....	126
Бататгах .....	128


## ТАНИХ ТЭМДЭГ



Сорих



Сэтгэн бодох



Хийж бүтээх, тоглох




Цээжээр бодох

## ДАВТАХ

1 Хүүхдүүд зуны амралтаараа юу хийсэн талаар ярилцаарай.




2 Хэлхээтэй шүрийг ажиглан, даалгаврыг гүйцэтгээрэй.







- Шүрнүүд дээрх тоог гүйцээгээрэй.
- Үргэлжлүүлэн 60 хүртэл тоолоорой.
- Ягаан шүр ямар өнгийн шүрний баруун гар талд байна вэ?
- Улаан өнгийн шүрэн дээрх тоо ямар аравтад ойр байна вэ?
- Шар өнгийн шүрэн дээрх тооноос эхлэн арваар нэмэгдүүлэн тоолоорой.
- Ногоон өнгөтэй шүрэн дээрх тоонуудын нийлбэрийн утгыг олоорой.
- Шүрэн дээрх ямар хоёр тооны нийлбэр бүтэн аравттай тэнцэж байна вэ?
- Нэг нь нөгөөгөөсөө 3-аар бага байх тоонуудыг шүрэн дээрээс олоорой.




3 Хүүхдүүд ээ,  дүрсийн цаана байгаа тоонуудыг олоорой

1	2	3	4	5	6	7	8	9	10
11	12	13	14			17	18	19	20
21	22	23	24		26	27			30
		33	34	35	36	37	38		40
	42	43	44	45	46	47	48	49	50

4 Асуултын тэмдгийн оронд тохирох тоог бичээрэй.



5 Тоогоор бичээрэй.  
а.





- б. 1 а 7 н,      2 а 1 н,      6 а 5 н,      4 а 9 н,      7 а 2 н,  
в.  $10 + 4$ ,       $30 + 7$ ,       $40 + 5$ ,       $20 + 9$ ,       $70 + 6$ ,  
г. Хорин дөрөв, арван ес, жаран гурав, далан найм, наян зургаа

6 27, 64, 41, 52, 36 тоонууд өгөв.


- а. Аравт, нэгжээр задлан бичээрэй.  
б. Орны нэмэгдэхүүний нийлбэрт задлан бичээрэй.  
в. Үгээр бичээрэй.

7 Асуултын тэмдгийн оронд хэдэн гүзээлзгэнэ байх вэ?





8 Охин дэлгүүрээс 8 ширхэг алим, хүү 11 ширхэг алим худалдан авав. Тэд нийт хэдэн алим худалдан авсан бэ?

- 9** Хорин гурав, далан найм, гучин дөрөв, тавин тав, жаран гурав гэсэн тоонуудыг  
 а. Тоогоор бичээрэй.  
 б. Хуваарьтай хэрчим дээр тэмдэглээрэй.



- 10** Эхний ширээн дээр 3 ном, нөгөө ширээн дээр түүнээс 2-оор олон ном байв. Хоёр ширээн дээр нийт хэдэн ном байна вэ?



- а. Хуваарьтай хэрчим дээр цэгээр тэмдэглэсэн тоонуудыг бичээрэй.  
 б. Тэмдэглэсэн тоонуудын их ба бага хөрш тоонуудыг нэрлээрэй.  
 в. Тэмдэглэсэн тоонуудыг буурах эрэмбээр дэвтэртээ бичээрэй.

- 12** Илэрхийллийг бичээд, утгыг олоорой.  
 а. 46 ба 21-ийн нийлбэрийг 35-аар хорогдуулах.  
 б. 37 ба 14-ийн ялгаврыг 24-өөр нэмэгдүүлэх.  
 в. 67-г 12 ба 15-ын нийлбэрээр хорогдуулах.  
 г. 23-ыг 56 ба 32-ын ялгавараар нэмэгдүүлэх.

- 13** 17, 58, 67, 21, 45, 78, 28, 36, 41, 73 тоонуудыг ажиглаад:  
 а. 4 а 2 н тооноос их тоонуудыг нэрлээрэй.  
 б. 5 а 7 н тооноос бага тоонуудыг нэрлээрэй.  
 в. Тоонуудыг нөхөж бичээрэй.

$$- \boxed{\phantom{00}} - \boxed{\phantom{00}} - \boxed{\phantom{00}} - \boxed{\phantom{00}} - \boxed{80} - \boxed{90} - \boxed{\phantom{00}} -$$

- 14** Хүснэгт дэх тоонуудаас:

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
---	---	---	---	---	---	---	---	---	---	----

- а. Зөрөө нь 2 байх хос тоонуудыг олоорой.  
 б. Нийлбэр нь 10 байх хос тоонуудыг олоорой.  
 в. 4-ийн тооны их ба бага хөрш тоонуудын нийлбэрийн утгыг олоорой.

**15** Даалгаврыг гүйцэтгээрэй.

Болд	●	●	●	●	●	●	●										
Бат	●	●	●	●	●	●	●	●	●	●							
Саран	●	●	●	●	●	●	●	●	●	●	●	●	●	●	●	●	●
Гэрэл	●	●	●	●	●	●	●	●	●	●	●	●	●				

- а. Хүүхэд тус бүр хэдэн дугуй дүрстэй байна вэ?
- б. Нэг нь нөгөөгөөсөө 4-өөр олон дугуй дүрстэй сурагчид байна уу? Нэрлээрэй.
- в. Болд Сарангаас хэдээр цөөн дугуй дүрстэй байна вэ?
- г. Саран Гэрэлээс хэдээр олон дугуй дүрстэй байна вэ?

**16** Илэрхийллийн утгыг олоорой.

- а.  $14 + 10$
- б.  $37 - 20$
- в.  $52 + 20$
- г.  $78 - 40$
- д.  $56 + 21 + 12$
- е.  $25 + 32 - 13$
- ж.  $46 - 22 + 14$
- з.  $67 - 32 - 4$

**17** Галт тэрэгний бүх ачаан дээрх тоонуудын нийлбэр 14 байхаар өгөгдсөн тоонуудыг байрлуулаарай.



**18** а. Хүснэгт дэх тоонуудыг нөхөж бичээрэй.

56		58		
66		68		
76	77	78		
	87	88	89	90
				100

б. Мөр бүрийн эхний тоотой тэнцүү утгатай илэрхийллийг олоорой.

<b>20</b>	$13+7$	$24-4$	$19+2$
<b>30</b>	$12+18$	$40+30$	$22+9$
<b>40</b>	$60-20$	$15+25$	$25+25$
<b>50</b>	$100-50$	$17+37$	$26+17$
<b>60</b>	$30+30$	$46+14$	$70-15$

**19**  -д тохирох тоог бичээрэй.

а. 38, 41, 39, 40  
 >  >  >


в. 13, 24, 19, 37, 25  
 >  >  >  >

б. 21, 19, 22, 20  
 <  <  <

г. 85, 83, 86, 84  
 <  <  <



Уртыг сантиметр гэдэг нэгжээр хэмждэг гэдгийг санаарай. Нэгж хэрчмийн уртыг “1 **сантиметр**” гэж уншаад **1 см** гэж тэмдэглэдэг шүү найзууд аа.




**20** Зураг дээрх үйл явдлууд ямар улиралд болдог вэ? Ярилцаарай.



- 21** а. Шинэ жилийн баяр ямар улиралд болдог вэ? Шинэ жилийн баярын юу нь чамд таалагддаг вэ?  
 б. Ногоог хэзээ тарьж, хэзээ хураадаг вэ?  
 в. Бороо ямар улиралд ордог вэ? Бороо орох нь ямар ашигтай вэ?


**22** Ангийн сурагчдыг ямар улиралд төрснөөр нь диаграммд харуулжээ. Дараах асуултад хариулаарай.




- а. Улирал бүрд хэдэн сурагч төрсөн бэ?  
 б. Ямар улиралд хамгийн олон сурагч төрсөн бэ?  
 в. Хавар, намар төрсөн нийт сурагчийн тоо өвөл, зун төрсөн нийт сурагчийн тооноос хэдээр олон байна вэ?  
 г. Ангийнхаа сурагчдын төрсөн улирлыг хүснэгтэд бүртгээрэй.

**23** Асуултын тэмдгийн оронд тохирох тоог олоорой.

Зүй тогтол нь:  
 $20 + 14 + 1 = 35$   
 юм болов уу?




**24** Охины өдрийн дэглэмтэй танилцъя.




- а. Охин хэдэн цагт өглөөний цайгаа уудаг вэ?
- б. Охин хэдэн цагт сургуульдаа ирдэг вэ?
- в. Үдээс хойш 3 цагт охин юу хийж байна вэ?
- г. Өдрийн дэглэмийг хэрэглэн бодлого зохиож бодоорой.

**25** Цагийг уншаад, дэвтэртээ бичээрэй.

Жишээ нь:  Өдрийн 3 цаг болж байна.



**26** Зургийг ажиглаад, ярилцаарай.



**27** Эрийн гурван наадам болжээ.



Аль нь удаан үргэлжилсэн бэ? Баяр наадмын үйл ажиллагаа нийт хэдэн цаг үргэлжилсэн бэ? Багштайгаа хамтран тооцоолоорой.


**28** Есдүгээр сарын цаг агаарын байдлыг харуулав.

Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням
1	2	3	4	5	6	7
8	9	10	11	12	13	14
15	16	17	18	19	20	21
22	23	24	25	26	27	28
29	30					


- Нартай    - Үүлэрхэг    - Бороотой

- Есдүгээр сард хэдэн өдөр нартай байсан бэ? Бороотой өдөр, үүлэрхэг өдрийн аль нь олон бэ?
- Гурван өдөр дараалан нартай байсан өдрүүдийг нэрлээрэй. Эдгээр өдрүүд ямар гараг байсан бэ?
- Есдүгээр сард хэдэн удаа 2 өдөр дараалан бороо орсон бэ?
- Аравдугаар сарын цаг агаарын байдлыг ажиглан, тэмдэглэл хөтлөөрэй.


- 29** Хүүхэлдэйн кино эхлэх, дуусах хугацааг хүснэгтэд тэмдэглэжээ. Кино тус бүр хэдэн цаг гарах вэ? Аль кино удаан гарах вэ?

Киноны нэр	Эхлэх цаг	Дуусах цаг	Үргэлжлэх хугацаа
Сүүлэнхүү		2:00	?
Цасан гуа ба долоон одой	9:00		?


- 30** Хүү, охин хоёр гэрийн даалгавраа хийв.



Дараа нь тэд өөрсдийн тоглоомоор тоглов.



Хамгийн сүүлд тэд гэрээ цэвэрлэв.



- Хүү, охины хэн нь гэрийн даалгавраа хурдан хийсэн бэ?
- Хоёр сурагчийн хэн нь гэрээ удаан цэвэрлэсэн бэ?
- Даалгавраа хийх, гэрээ цэвэрлэх, тоглоход тэд тус бүр хэдэн цаг зарцуулсан бэ?




## 100 ДОТОР НЭМЭХ, ХАСАХ

**31** Зуны амралтаараа нэгдүгээр ангийнхан 37 ширхэг, хоёрдугаар ангийнхан тэднээс 8-аар илүү тооны ном уншжээ. Хоёрдугаар ангийнхан нийт хэдэн ном уншсан бэ?

илэрхийлэл  $37+8$

Нийлбэрийн утгыг олох юм байна.




$$37 + 8 = (37 + 3) + 5 = 40 + 5 = 45$$

Гуравдугаар ангийнхан 56 ширхэг, хоёрдугаар ангийнхан тэднээс 9-өөр бага ном уншсан. Хоёрдугаар ангийнхан нийт хэдэн ном уншсан бэ?


илэрхийлэл  $56-9$

Ялгаврын утгыг олох юм байна.



$$56 - 9 = 40 + (16 - 9) = 40 + 7 = 47$$

**32** а. 14 ба 8-ын нийлбэрийг хэрхэн олсныг ажиглаад, ярилцаарай.



$$\begin{array}{r} 14 + 8 \\ \swarrow \searrow \\ 6 \quad 2 \end{array} \quad 14 + 8 = (14 + 6) + 2 = 22$$

б. Нэмэх үйлдлийг гүйцэтгээрэй.



$$17 + \square = \square$$

**33** а. 24 ба 9-ийн ялгаврыг хэрхэн олсныг ажиглаад, ярилцаарай.



$$\begin{array}{r} 24 - 9 \\ \swarrow \searrow \\ 20 \quad 4 \end{array} \quad 24 - 9 = (20 - 9) + 4 = 15$$

б. Хасах үйлдлийг гүйцэтгээрэй.



$$36 - \square = \square$$



34 Загварыг ажиглан, □ -ний оронд байх тоог нөхөөрэй.

а.

Аравт (а)	Нэгж (н)

$46 + 7 = (46 + \square) + \square = \square$

б.

Аравт (а)	Нэгж (н)

$62 - 6 = 50 + (\square - \square) = \square$

35 Шоон загвараар дүрсэлсэн тоонуудын нийлбэрийг олоорой.

--	--

$\square + \square = \square$

--	--

$\square + \square = \square$

36 Хоёр туузын уртын хэмжээг хүү, охин хоёр олов. Хэрхэн олсныг тайлбарлаарай.

6 см	10 см
? см	? см
$10 \text{ см} + 6 \text{ см} = 16 \text{ см}$	$6 \text{ см} + 10 \text{ см} = 16 \text{ см}$



Нэмэгдэхүүний байрыг солиход нийлбэрийн утга өөрчлөгдөхгүй.

Бид хоёрын бодолтын хариу ижил байна.



37 Нийлбэрийн утгыг олоорой.

- |            |            |            |            |
|------------|------------|------------|------------|
| а. $17+5$  | б. $28+6$  | в. $73+8$  | г. $66+9$  |
| д. $38+30$ | е. $18+20$ | ж. $45+40$ | з. $30+68$ |

38 Ялгаврын утгыг олоорой.


- |            |            |            |            |
|------------|------------|------------|------------|
| а. $17-9$  | б. $33-6$  | в. $75-7$  | г. $41-5$  |
| д. $48-30$ | е. $37-20$ | ж. $75-40$ | з. $98-60$ |

**39** Хэрхэн бодсоныг тайлбарлаарай.


а. Худалдагч эхний өдөр 37 ширхэг, дараагийн өдөр 26 ширхэг үзэг худалдав. Хоёр өдөр нийт хэдэн ширхэг үзэг худалдсан бэ?

илэрхийлэл  $37+26$

Нийлбэрийн утгыг яаж олох вэ?




$$37 + 26 = (30 + 20) + (7 + 6) = 63$$




б. Дэлгүүрт байсан 56 ширхэг харандааны 37 ширхгийг худалдав. Хэдэн ширхэг харандаа үлдсэн бэ?

илэрхийлэл  $56-37$



Ялгаврын утгыг яаж олох вэ?



$$56 - 37 = (40 - 30) + (16 - 7) = 19$$



**40** Шоон загвараар дүрсэлсэн тоонуудын нийлбэрийг олоорой.



41 Нийлбэрийн утгыг олоорой.

- а.  $16 + 25$                       б.  $47 + 24$                       в.  $66 + 29$                       г.  $18 + 23$   
 д.  $52 - 6$                       е.  $74 - 15$                       ж.  $82 - 23$                       з.  $66 - 19$

42 Ялгаврын утгыг олоорой.

- а.  $16 + 25$                       б.  $47 + 24$                       в.  $66 + 29$                       г.  $18 + 23$   
 д.  $52 - 6$                       е.  $74 - 15$                       ж.  $82 - 23$                       з.  $66 - 19$

43 а. 100 хүртэлх тооны хүснэгт дээр үйлдлийг хэрхэн гүйцэтгэсэн талаар ярилцаарай.

1	2	3	4	5	6	7	8	9	10
11	12	13	14	15	16	17	18	19	20
21	22	23	24	25	26	27	28	29	30
31	32	33	34	35	36	37	38	39	40
41	42	43	44	45	46	47	48	49	50
51	52	53	54	55	56	57	58	59	60
61	62	63	64	65	66	67	68	69	70
71	72	73	74	75	76	77	78	79	80
81	82	83	84	85	86	87	88	89	90
91	92	93	94	95	96	97	98	99	100

$43 + 35 = ?$

$43 + 10 + 10 + 10 + 1 + 1 + 1 + 1 + 1 = 78$

$43 + 30 + 5 = 78$

$57 - 42 = ?$


$57 - 10 - 10 - 10 - 10 - 1 - 1 = 15$

$57 - 40 - 2 = 15$

б. Дээрх аргаар үйлдлийг гүйцэтгээрэй.

- $23 + 14$                        $36 + 22$                        $58 + 32$                        $56 + 36$   
 $56 - 20$                        $68 - 35$                        $47 - 26$                        $82 - 21$

44 Үйлдлийг гүйцэтгээрэй.



45 Галт тэргээр 56 том хүн, 27 хүүхэд зорчиж байв. Галт тэргээр нийт хэдэн хүн зорчиж байсан бэ?

**46**  $39 - (15 + 13)$  илэрхийллийн утгыг хүүхдүүд хэрхэн олсныг ажиглаарай.

Охин:  $39 - (15 + 13) = 37$   
1.  $39 - 15 = 24$   
2.  $24 + 13 = 37$

Хүү:  $39 - (15 + 13) = 11$   
1.  $15 + 13 = 28$   
2.  $39 - 28 = 11$

Хүү илэрхийллийн утгыг зөв олжээ.

Хаалт орсон илэрхийллийн утгыг олохдоо хаалтан доторх үйлдлийг эхэлж гүйцэтгэдэг.



**47** Тайлбарлаарай.

Зуслангийн Нарлаг бүлэг-21, Оч бүлэг-24, Золбоо бүлэг-23 хүүхэдтэй.

Дууны тэмцээнд:  
Нарлаг, Оч бүлгүүд  
нэг баг болж, Золбоо  
бүлэг дангаараа  
оролцов.

Бүжгийн тэмцээнд:  
Нарлаг, Золбоо  
бүлгүүд нэг баг болж,  
Оч бүлэг дангаараа  
оролцов.

Шүлгийн тэмцээнд:  
Оч, Золбоо бүлгүүд  
нэг баг болж, Нарлаг  
бүлэг дангаараа  
оролцов.

Тэмцээн бүрд нийт сурагч оролцсон бэ?

$$(21 + 24) + 23 = 45 + 23 = 68$$

$$(21 + 23) + 24 = 44 + 24 = 68$$

$$21 + (24 + 23) = 21 + 47 = 68$$

$21 + 24 + 23$  илэрхийллийн аль ч 2 гишүүнийг эхэлж нэмэхэд илэрхийллийн утга хэвээрээ байдаг юм байна.



**48**  $34 + 25 - 10$  илэрхийллийн утгыг олсон хүүхдүүдийн бодолтыг тайлбарлаарай.

Номин: 34 дээр 25-ыг нэмээд, 10-ыг хасаж үзье.

$$\underbrace{(34 + 25)}_{59} - 10 = 59 - 10 = 49$$

Тамир: 34-өөс 10-ыг хасаад, 25-ыг нэмж үзье.

$$\underbrace{(34 - 10)}_{24} + 25 = 24 + 25 = 49$$

Хулан: 25-аас 10-ыг хасаад, 34-ийг нэмж үзье.

$$\underbrace{(25 - 10)}_{15} + 34 = 15 + 34 = 49$$

Илэрхийллийн утга бүр ижил байна.



**49** Илэрхийллийг бичээд, утгыг олоорой.

а. 26 ба 13-ын нийлбэрийн утгыг 27-оор хорогдуулах

б. 71 ба 18-ын ялгаврын утгыг 35-аар нэмэгдүүлэх

в. 19 ба 28-ын нийлбэрийн утгыг 43-аар ихэсгэх

## ҮЙЛДЛИЙН ГИШҮҮД БА ҮР ДҮНГИЙН ХАМААРАЛ

**50** Үйлдлийн гишүүдийг хэрхэн нэрлэж байгааг ажиглаад, ярилцаарай.



**51** Улаан өнгөөр бичсэн тоо нь ямар гишүүн бэ?

а.  $27 + 15 = 42$ ;       $63 + 18 = 81$ ;       $42 + 29 = 71$ ;       $26 + 17 = 43$   
 б.  $34 - 16 = 18$ ;       $45 - 29 = 16$ ;       $61 - 27 = 34$ ;       $52 - 15 = 37$

**52** Өгсөн тоонуудаар тэнцэтгэл зохиогоорой. Эдгээр тэнцэтгэлд 58, 84, 26 нь ямар гишүүн болох вэ?

Жишээ нь.  $58; 84; 26$ :       $58 + 26 = 84$ ;       $84 - 26 = 58$   
     $26 + 58 = 84$ ;       $84 - 58 = 26$


а.  $34; 81; 47$       б.  $48; 25; 73$       в.  $92; 16; 76$       г.  $52; 39; 91$

**53**  $\boxed{24} + \boxed{18} = \boxed{42}$  ;     $\boxed{57} + \boxed{19} = \boxed{76}$  ;     $\boxed{63} + \boxed{28} = \boxed{91}$  ;     $\boxed{38} + \boxed{42} = \boxed{80}$   
 $\boxed{65} - \boxed{17} = \boxed{48}$  ;     $\boxed{86} - \boxed{28} = \boxed{58}$  ;     $\boxed{92} - \boxed{26} = \boxed{66}$  ;     $\boxed{51} - \boxed{19} = \boxed{32}$

Дээрх тэнцэтгэлийг дэвтэртээ бичээд:

- а. Нэгдүгээр нэмэгдэхүүнийг шар өнгөөр, хоёрдугаар нэмэгдэхүүнийг ногоон өнгөөр, нийлбэрийн утгыг цэнхэр өнгөөр,  
 б. Хасагдагчийг улаан өнгөөр, хасагчийг ягаан өнгөөр, ялгаврыг хөх өнгөөр тус тус будаарай.

**54** Үйлдлийн тэмдэгт тохирох үгсийг харгалзуулаарай.



**55** Илэрхийллүүдийг ажиглаад:


А.  $19 + 54$

Б.  $35 + 19$

В.  $54 + 35$

- а. 54 нь дээрх илэрхийлэлд ямар гишүүн болох вэ?  
 б. Үйлдлийг гүйцэтгэхгүйгээр А, Б илэрхийллүүдийн нийлбэрийн утгыг жишээд, учрыг тайлбарлаарай.  
 в. Үйлдлийг гүйцэтгэхгүйгээр Б, В илэрхийллүүдийн нийлбэрийн утгыг жишээд, учрыг тайлбарлаарай.

56 Зургийг ажиглаад, хэрхэн гүйцэтгэснийг ярилцаарай.



Жинлүүрийг тэнцүүлэхийн тулд зүүн гар талд хэдийг нэмэхэд тэнцэх вэ?

4 дээр хэдийг нэмбэл 10 гарах вэ гэдгийг тооцоолъё.

$$10 - 4 = 6 \text{ ширхэг (жүрж)}$$

Хайрцагт 6 ширхэг жүрж байна.

57 Үл мэдэгдэх гишүүнийг олж, хэрхэн олсноо тайлбарлаарай.

а.  $\boxed{31} + \boxed{?} = \boxed{78}$     б.  $\boxed{52} + \boxed{?} = \boxed{86}$     в.  $\boxed{29} + \boxed{?} = \boxed{53}$   
 г.  $\boxed{?} + \boxed{21} = \boxed{90}$     д.  $\boxed{?} + \boxed{46} = \boxed{72}$     е.  $\boxed{?} + \boxed{17} = \boxed{64}$

Хасах үйлдлийн мэдэгдэхгүй гишүүнийг яаж олох юм бол?



58  $\boxed{54} - \boxed{?} = \boxed{15}$

54-өөс хэдийг хасахад 15 гарах вэ?

Хасагч:  $54 - 15 = 39$

Шалгавал:  $54 - 39 = 15$

Хасагч, хасагдагчийг хэрхэн олсон талаар ярилцаарай.

$\boxed{?} - \boxed{39} = \boxed{15}$

Ямар тооноос 39-ийг хасахад 15 гарах вэ?

Хасагдагч:  $39 + 15 = 54$

Шалгавал:  $54 - 39 = 15$

59  **Илэрхийлэл зохиоё**

$\boxed{4}$   $\boxed{1}$   $\boxed{3}$   $\boxed{2}$   $\boxed{0}$  Тоон картуудыг ашиглан:

- а. Хоёр нэмэгдэхүүний нэг нь хоёр оронтой тэгш тоо нөгөө нь хоёр оронтой сондгой тоо байх илэрхийлэл зохиогоорой.
- б. Ялгаврын утга нь 20-оос бага байх илэрхийлэл зохиогоорой.
- в. Нийлбэрийн утга нь 50-аас бага байх илэрхийлэл зохиогоорой.

60 Үл мэдэгдэх гишүүнийг олоорой.

а.  $\boxed{38} + \boxed{?} = \boxed{67}$  б.  $\boxed{?} + \boxed{21} = \boxed{83}$  в.  $\boxed{42} + \boxed{?} = \boxed{97}$   
г.  $\boxed{?} + \boxed{27} = \boxed{54}$  д.  $\boxed{?} + \boxed{24} = \boxed{39}$  е.  $\boxed{18} + \boxed{?} = \boxed{73}$   
ж.  $\boxed{?} - \boxed{16} = \boxed{41}$  з.  $\boxed{?} - \boxed{19} = \boxed{37}$  и.  $\boxed{?} - \boxed{33} = \boxed{49}$   
к.  $\boxed{84} - \boxed{?} = \boxed{23}$  л.  $\boxed{72} - \boxed{?} = \boxed{45}$  м.  $\boxed{60} - \boxed{?} = \boxed{26}$

61 Гурван найзын санасан тоог олж, тоон шулуун дээр тэмдэглээрэй.

- Болорын санасан тоон дээр 13-ыг нэмбэл 57
- Нарангийн санасан тооноос 13-ыг хасвал 57
- Хүслэнгийн санасан тоон дээр Болорын санасан тоог нэмбэл 57 болно.

62 Хүснэгтийг хэрэглэн илэрхийлэл зохиож, үл мэдэгдэх гишүүнийг олоорой.

Нийлбэрийн утга	100	80	50	60	30
Нэмэгдэхүүн	?	?	18	?	13
Нэмэгдэхүүн	70	40	?	34	?

63 Математикийн уралдаан 2 өдөр үргэлжлэв. Хүү эхний өдөр 37 оноо авчээ. Тэр хоёр дахь өдрийн оноогоо харж чадаагүй. Хүү нийт 62 оноо авсан бол хоёр дахь өдөр хэдэн оноо авсан бэ?

64



### Хамтдаа тоглоё

Хэрэглэгдэхүүн:

10	10	10	10	10	10	10	10	10
1	1	1	1	1	1	1	1	1

- Тоон картуудыг доош харуулж тавьсан байна. Эхний сурагч картуудаас 4-ийг сугалж авна. Карт дээрх тоонуудын нийлбэрийг хэлнэ.
- Нөгөө сурагч мөн адил үйлдлийг гүйцэтгэнэ.
- Их нийлбэр бүхий тоон картуудыг сугалж авсан сурагч хожно.
- Цааш үргэлжлүүлэн тоглоно.

65 а. Зүй тогтлыг ажиглаад, дараагийн 3 тоог олоорой.

16, 19, 22, 25, □, □, □

27, 32, 37, 42, □, □, □

б. Зүй тогтлыг ажиглаад, өмнөх 3 тоог олоорой.

□, □, □, 20, 25, 30

□, □, □, 45, 52, 59, 66

66 Хүү 13 ном уншсан нь охины уншсан номоос 4-өөр цөөн. Охин хэдэн ном уншсан бэ?

67 Үйлдлийн гишүүнийг өөрчлөхөд үр дүн хэрхэн өөрчлөгдөж байгааг ширээний найзтайгаа ярилцаарай.


$80 - 30 = 50$	$80 - 30 = 50$	$80 - 30 = 50$	$80 - 30 = 50$
↓? ↓?	↓? ↓?	↓? ↓?	↓? ↓?
$80 - 20 = 60$	$70 - 30 = 40$	$90 - 30 = 60$	$80 - 40 = 40$

68  $45 + 30 = 75$  тэнцэтгэлийн:

- Нэмэгдэхүүнийг 10-аар нэмэгдүүлбэл нийлбэрийн утга хэрхэн өөрчлөгдөх вэ?
- Нийлбэрийн утгыг 20-оор нэмэгдүүлэхийн тулд аль нэмэгдэхүүнийг хэдээр нэмэгдүүлэх вэ? Хэдэн боломж байна вэ?
- Нийлбэрийн утгыг 5-аар багасгахын тулд аль нэмэгдэхүүнийг хэрхэн өөрчлөх вэ? Бүх боломжийг олж чадах уу? Хамтран ярилцаад, туршиж үзээрэй.

69 • Нийлбэр нь 100 байх хос дэлбээг ижил өнгөөр будаарай.

• Бүх дэлбээг будаж болох уу? Тайлбарлаарай.



70



**Үйлдлийн гишүүдийг олъя.**

А.  $26 - 23$

Б.  $68 - 42$

В.  $87 - 26$

Багш 26 хасах үйлдлийн ямар гишүүн болохыг сурагчдаас асуув.

Номин: хасагч,

Хүслэн: хасагдагч,

Тэмүүлэн: ялгавар гэж тус тус хариулжээ.

Тэдний хариултыг тохирох илэрхийлэлтэй нь харгалзуулаарай.



## ТООГ ОЙРОЛЦООГООР ХЭЛЭХ

- 71** Шугам дээр тэмдэглэсэн 20 ба 30-ийн хооронд орших тоонуудыг ажиглаарай  
Тэдгээр тоо 20 ба 30-ийн алинд нь ойр болохыг ярилцаарай.



21, 22, 23, 24 тоонууд  
20-д ойр байна.


26, 27, 28, 29 тоонууд  
30-д ойр байна.



Тоог түүнд хамгийн ойр байгаа бүтэн аравтаар сольж хэлэхийг аравтаар ойролцоолох гэж ойлголоо.



- 72** Илэрхийллийн утгыг олж, ямар аравтад ойр байгааг нэрлээрэй.
- а.  $24 + 13$       б.  $46 + 28$       в.  $51 - 17$       г.  $29 + 33$   
 д.  $(37 + 24) - 18$       е.  $73 - 28$       ж.  $62 - 35$       з.  $(43 - 14) + 25$



- а. Хуваарьтай хэрчим дээр 23, 67, 41, 18, 85, 72 тоонуудыг цэгээр тэмдэглээрэй.  
 б. Тэмдэглэсэн тоонууд ямар аравтад ойр байгааг нэрлээрэй.

- 74** Хоёрдугаар ангийн сурагчид явган аялалд гарав. Аялалд 2а бүлгээс 28, 2б бүлгээс 24 сурагч оролцсон бол явган аялалд ойролцоогоор хэдэн сурагч оролцсон бэ?



**75** **Ойролцоогоор хэлье**



**Хэрэглэгдэхүүн:**  $10 \times 10$  хэмжээтэй хүснэгт, шоо, өнгийн харандаа.

- а. Шоог хүснэгт дээр орхино.  
 б. Шоо буусан нүдэнд харгалзах 2 тооны нийлбэрийн утгыг хэлнэ.  
 в. Нийлбэрийн утга нь ямар 2 аравтын хооронд байгааг хэлж, тухайн шугамын өнгөөр хүснэгтийн нүдийг будна.  
 г. Нийлбэрийн утга нь аль аравтад ойр байгааг нэрлэнэ.

**Жишээ:**  $(50; 8) \Rightarrow 50 + 8 = 58$ ; 58 нь шар өнгийн шугам дээр байрлах ба 60-д ойр байна.




76 Зургийг ажиглаад, ярилцаарай.



Доод тавиур дээрх 48 номыг ойролцоогоор хэрхэн хэлэх вэ?

- а. 48 нь ямар аравтуудыг хооронд оршихыг олж.
- б. Аль аравтад илүү ойр байгааг тогтоо.




- 48 нь 40 ба 50-ын хооронд оршиж байна.
- $48 - 40 = 8$ ;  $50 - 48 = 2$ ;  $8 > 2$  учир 48 нь 50-д ойр байна.

48-ыг аль аравтад ойр байгаагаар нь сольж нэрлэхийг аравтаар тоймлох гэнэ.  
48 нь ойролцоогоор 50 болно.



77 Хэрэв доод тавиур дээрээс 3 ширхэг номыг авч, дээд тавиур дээр тавибал ойролцоогоор хэдэн ном үлдэх вэ?

$48 - 3 = 45$  ном үлдэнэ.



- а. 45 нь 40 ба 50-ын хооронд оршиж байна.
- б.  $45 - 40 = 5$ ;  $50 - 45 = 5$ ;  $5 = 5$  байна. Иймд 45-ыг 50 гэж тоймлоно.


2 аравтын дунд орших 5-аар төгссөн тоог тоймлохдоо их аравтаар нь сольж хэлдэг юм байна.



78 Тоог аравтаар тоймлоорой.

17, 32, 45, 24, 51, 86, 63, 75, 92


- 79 Хуваарьтай хэрчим дээр тэмдэглээрэй.  
 а. 60-аас бага 60-д ойр тоо гурвыг тэмдэглээрэй.  
 б. 60-аас их 60-д ойр тоо гурвыг тэмдэглээрэй.



- 80 Ямар тоонуудыг аравтаар тоймловол 60 гарах вэ? Ийм тоо хэд байна вэ? Тэдгээр тоонуудыг хуваарьтай хэрчим дээр тэмдэглээрэй.

- 81 Илэрхийллийн утгыг олж, аравтаар тоймлоорой.  
 а.  $23 + 16$       б.  $64 - 17$       в.  $48 + 25$       г.  $(91 - 23) + 15$   
 д.  $37 + 28$       е.  $71 - 14$       ж.  $84 - 23$       з.  $(65 + 13) - 29$

- 82 Хуваарьтай хэрчим дээр тэмдэглэсэн цэгүүд нь аль аравтад ойр байгаа талаар ярилцаарай.  
 Цэгээр тэмдэглэсэн тоог аравтаар тоймлоорой.



- 83 Хөхүүрт 68 литр айраг байв. Түүн дээр 20 литр саам нэмсний дараа 35 литрийг нь хэрэглэсэн бол хөхүүрт ойролцоогоор хэдэн литр айраг үлдсэн бэ?



- 84 Малчин Сүрэн гуайн хашаанд 30 гаруй хурга, 40 орчим ишиг, 20 гаруй тугал байна. Хашаанд ойролцоогоор хэдэн төл мал байгааг олоорой.

85



**Тоог таая**

**Заавар:**


Нэгж: Өөрийн картыг дээш харуулна. "6"  
 Аравт: Өөрийн сугалсан тоо (2)-г харуулахгүйгээр хоёр оронтой тоо үүсгээд, тоймлож хэлнэ "30".  
 Нэгж : Аравтын сугалсан тоог таана. "26"

ӨНЦӨГ






**Тэгш өнцөг хийцгээе.**

а. Дугуй хэлбэртэй цаас авч, зааврын дагуу нугалаарай.



б. Нугалсан дүрсийг дэвтэр дээрээ байрлуулан, шугамын дагуу зураарай.





 Үүссэн өнцгийг тэгш өнцөг гэнэ.  
 Тэгш өнцгийг  гэж тэмдэглэдэг.




**86** Тэгш өнцөгтэй дүрс байгаа эсэхийг шалгаарай. Хэрхэн шалгах вэ?  
 Жишээ нь:




Давхцаж буй  
 учир тэгш  
 өнцөгтэй  
 гурвалжин.



Өнцгийн  
 талуудтай  
 давхцахгүй тул  
 тэгш өнцөггүй.



а.



б.



в.




г.

87 Гурвалжин хэлбэртэй цаас авч, нэг оройг нь дагуулан шулуун зуръя.




Үүсэж буй хавтгайн хэсгийг өнцөг гэнэ.




Талууд хэр их нээлттэй байгаагаар өнцгийн хэмжээг харьцуулж болно. Зураг дээрх өнцөг 1-ийн хэмжээ өнцөг 2-ын хэмжээнээс их байна.


88 Геосамбар дээр тэгш өнцөгтэй дүрсүүд бүтээгээрэй. Жишээ нь:



89 Дүрсүүд дээр тэмдэглэсэн өнцгүүд тэгш өнцөг мөн эсэхийг шалгаарай.




90 Янз бүрийн хэлбэртэй цаасыг нугалж, тэгш өнцөг хийгээрэй. Жишээ нь:




91 Шугам хэрэглэн, дэвтэртээ тэгш өнцөгтэй дүрсүүд зураарай.

## ДҮРС

92 Геосамбар дээр цэгүүдийг холбож, тахир шугам зураарай.



93 Охин савхаар дүрс бүтээжээ. Ямар дүрс бүтээснийг ажиглаад, ярилцаарай.



1, 3 дугаартай дүрсүүдийг 3 савхаар бүтээсэн.


2, 4, 5 дугаартай дүрсүүдийг 4 савхаар бүтээсэн.



Гурван талтай, гурван оройтой дүрсийг гурвалжин гэнэ.

Дөрвөн талтай, дөрвөн оройтой дүрсийг дөрвөн өнцөгт гэнэ.

94 Ямар дүрсүүд байна вэ? Ажиглаарай.



**95** Өмнөх бодлогод өгсөн дүрсүүдийг өгсөн хүснэгтэд ангилж, харгалзах дугаарыг бичээрэй.

а. Хүснэгтийг гүйцээгээрэй.

Дөрвөн талтай	Гурван талтай
2, 4, ...	6, ...

Дөрвөн оройтой	Гурван оройтой
2, ...	9, ...


б. Хүснэгтэд бичсэн тоонуудаа ажиглаарай.

Дөрвөн талтай, дөрвөн оройтой дүрс хэд байна вэ?

в. Гурван тал, гурван оройтой дүрс хэд байна вэ?


г. Гурван тал, дөрвөн оройтой дүрс байна уу? Учрыг олж, ярилцаарай.

**96** Геосамбарт гурвалжин, дөрвөн өнцөгт бүтээгээрэй.



**97** Шугам, харандаа хэрэглэн гурвалжин, дөрвөн өнцөгт тус бүр гурвыг зураарай.

**98** а. Дүрс бүрийн орой ба талыг тоолж, өгсөн хүснэгтэд тэмдэглээрэй.



Дугаар	1	2	3	4	5	6	7	8
Тал								
Орой								







5 оройтой, 5 талтай дүрсийг таван өнцөгт гэнэ.


6 оройтой, 6 талтай дүрсийг зургаан өнцөгт гэнэ.




б. Хүснэгтийг дэвтэртээ зураад, гүйцээж бичээрэй.

			
.....	Дөрвөн өнцөгт	... өнцөгт	.....

**99** Дөрвөн өнцөгт болгон, дэвтэртээ гүйцээж зураарай.



**100** Байшингийн зургийг ажиглаарай.



а. Зурагт ямар дүрс, хэдэн удаа орсон байна вэ?

Нэрлэж бичээрэй.

*Жишээ нь: хаалга - дөрвөлжин.*


б. Хамгийн олон удаа давтагдсан нь аль дүрс вэ? Ярилцаарай.

**101**




**Хэн хамгийн олон амьтан бүтээх вэ?**

**Хэрэглэгдэхүүн:** Эв долоо, багшийн үзүүлсэн дүрсүүд



*Жишээ нь:*






## ТЭГШ ӨНЦӨГТ, КВАДРАТ

**102** Зааврын дагуу ажиллаарай.

а. Цаасыг зурагт үзүүлсэнтэй адилаар нугалж, дөрвөн өнцөгт хийгээрэй.



б. Хийсэн дөрвөн өнцөгтийнхөө орой бүрд ямар өнцөг үүссэнийг хэмжээрэй.




Дөрвөн өнцөг нь дөрвүүлээ тэгш байна.




Бүх өнцөг нь тэгш байх дөрвөн өнцөгтийг тэгш өнцөгт гэнэ.

**103** Тэгш өнцөгт хэлбэртэй цаасыг зурагт үзүүлсэнтэй адилаар нугалж, талуудын уртыг харьцуулаарай. Юу ажигласан бэ?



**104** Тэгш өнцөгт хэлбэртэй цаасыг зурагт үзүүлсэнтэй адилаар нугалж, дөрвөн өнцөгт хийгээрэй.


Дөрвөн өнцөгтийнхөө орой бүрд үүсэх өнцгийг хэмжээрэй.



**105** Хийсэн тэгш өнцөгтөө зурагт үзүүлсэнтэй адилаар нугалж, талуудын уртыг харьцуулаарай. Юу ажигласан бэ?



Бүх өнцөг нь тэгш байна.



Бүх тал нь тэнцүү байна.



Дөрвөн өнцөг нь тэгш, дөрвөн тал нь тэнцүү дөрвөн өнцөгтийг квадрат гэнэ.

ЮМСЫГ БАГЦЛАН ТООЛОХ

**106** Зул, Баяр, Номин нар шоо тоолов. Баяр хамгийн түрүүнд тоолж дуусчээ. Зул хамгийн удаан тоолсон. Хэн, хэрхэн тоолж байгааг ажиглаад, ярилцаарай.



Зул	Баяр	Номин
		

- Баяр яаж тоолсон бэ?
- Зул яагаад хамгийн удаан тоолсон бэ?
- Баяраас хурдан тоолохын тулд хэрхэн тоолох вэ? Хамтран ярилцаарай.

Олон юмсыг хэд хэдээр багцлан тоолох нь амархан юм байна.




**107** Харандааг 2, 2-оор багцлан тоолоод, □-д тохирох тоог бичээрэй.



**108** Дэлгүүрт 10, 10-аар савласан 7 хайрцаг жигнэмэг буулгажээ. Нийт хэдэн жигнэмэг буулгасан бэ? Жигнэмгийн тоог нэмэх үйлдлээр олоорой.

**109** Харандаануудыг хэдээр багцалсан байна вэ? Нийт хэдэн харандаа байна вэ?



**110** Товчнуудыг 2, 2-оор багцлаарай.




- Хэдэн багц болсон бэ?
- Нийт хэдэн товч байна вэ?

**111** Гүйцээж багцлаарай. Хэдэн багц болсон бэ?



**112** Хүүд шугамын хуваарийг бичихэд туслаарай.



**113** Дэвтэртээ 14 ширхэг дугуй дүрс зураарай. Зурсан дугуйгаа 2, 2-оор багцлан зураарай. Хэдэн багц болсон бэ?

**114** Нийлбэрийн утгыг олоорой.

а.  $2 + 2 + 2 + 2$

б.  $5 + 5 + 5$

в.  $10 + 10 + 10 + 10$

$2 + 2 + 2 + 2 + 2 + 2$

$5 + 5 + 5 + 5 + 5$

$10 + 10 + 10 + 10 + 10$

**115**



Машины дугаарыг гүйцээгээрэй.




Дээрх машинуудаас Насан, Дэлгэр нар нэг нэг машин сонгожээ. Тэдний машины дугаарын зөрөө 20.

Насан, Дэлгэр нар ямар дугаартай машин сонгосон байж болох вэ?

## ҮРЖҮҮЛЭХ ҮЙЛДЭЛ

116



Худалдагч 6 ширхгээр савласан 9 хайрцаг өндөг худалджээ. Хэдэн өндөг худалдсан бэ? Хэрхэн тэмдэглэх вэ?

Хүү: 6, 6-аар багцлан тоолно. 6, 12, 18,.....

Охин: бүгдийг нэмж болно.  $6 + 6 + 6 + \dots$



Олон удаа нэмж бичихэд хэцүү юм байна.

Хялбар бичих арга байгаа болов уу?



Худалдагч худалдсан өндөгний тоог " $9 \times 6 = 54$ " гэж тэмдэглэв. Тоо тус бүрээр юу, юуны тоог тэмдэглэснийг ярилцаарай.

117

Асуултад хариулаад,  -д тохирох тоог бичээрэй.



Үржүүлэх тэмдэг


- Хэдэн тахиа өндөг дарсан бэ?
- Тахиа тус бүр хэдэн өндөг дарсан бэ?
- Нийт хэдэн өндөг дарсан бэ?


$$\square \times \square = \square$$

118

Асуултад хариулаад,  -д тохирох тоог бичээрэй.



- Дэгдээхийг хэдэн үүрт хийсэн бэ?
- Нэг үүрт хэдэн дэгдээхий хийсэн бэ?
- Нийт хэдэн дэгдээхий байсан бэ?



$$\square \times \square = \square$$

Багцын тоо

Нэг багцад буй юмсын тоо

Нийт юмсын тоо

Хүүгийн хэлсэн зөв үү? Хамтран ярилцаарай.

119




- 118-119 дүгээр дасгалын багцын тоог илэрхийлэх зүйлсийг нэрлээрэй.
- 119 дүгээр дасгалд нэг үүрэнд буй дэгдээхийний тоог үржүүлэх тэмдгийн хаана бичсэн бэ? Тайлбарлаарай.
- 118 дугаар дасгалд тахианы тоо нийт юмсын тоо мөн үү? Яагаад вэ?

**120** Дүрсийг хэдээр багцалсныг ажиглаад, гүйцээгээрэй.




Хэдэн багц болсон бэ? Нэг багцад хэдэн од байна вэ? Нийт хэдэн од байгаа вэ?

$$\square \times \square = \square$$



9 × 2 үүнийг үржвэр гэнэ.



- Есөн хоёр нь арван найм.
- Есийг хоёроор үржүүлэхэд арван найм гарна.
- 9 ба 2-ын үржвэрийн утга 18.
- 2-ыг 9 дахин ихэсгэхэд 18 болно.
- 9-ийг үржүүлэх нь 2 тэнцүү 18 гэх мэтээр уншина.

**121** Жимсний нийт тоог олох үржвэрийг бичээрэй.



- Хэдэн багц гадил байна вэ?
- Нэг багцад хэдэн ширхэг гадил байна вэ?

$$\square \times \square$$



$$\square \times \square$$




$$\square \times \square$$





$$\square \times \square$$

**122** Цэцгийг 10, 10-аар багцлаарай. Багцалсан цэцгийн тоог үржвэр хэлбэрээр бичээрэй.



Цэцгийн багцалсан тоог хуваарьтай хэрчим дээр тэмдэглээрэй.

**123** Тоон хэрчим дээрх тэмдэглэгээг ажиглаарай. Тохирох тоон тэнцэтгэл бичээрэй.



124 Хүү, охин хоёр хүснэгтийн мөр баганын тоог яагаад өөрөөр хэлсэн бэ? Ярилцаарай.



125 Мөр бүрийг өөр өнгөөр будаарай.




- Хүснэгт бүрийн нийт нүдний тоог хэрхэн олж болох вэ? Ярилцаарай.
- Хүснэгт бүр хэдэн баганатай вэ? Багана бүр хэдэн нүдтэй вэ? Үржвэрээр бичээрэй.

126 Хүү дэвтэртээ ▲ дүрс зуржээ. Хүү хэдэн мөрөнд ▲ зурсан бэ?

▲	▲	▲	▲	▲
▲	▲	▲	▲	▲
▲	▲	▲	▲	▲
▲	▲	▲	▲	▲

- Түүнийг дуурайлган зураарай.
- Зурсан ▲-ыг баганын дагуу хүрээлээрэй.
- Нийт хэдэн ▲ байна вэ?
- Гурван багана дахь гурвалжны тоог олох үржвэр бичээрэй.
- Гурван мөр дэх гурвалжны тоог олох үржвэр бичээрэй.

127




12	13	14
15	16	17
18	19	20

- Хоёрдугаар мөр дэх тоонуудын нийлбэрийг олоорой.
- Гуравдугаар баганын тоонуудын нийлбэрийг олоорой.
- Нэгдүгээр мөр хоёрдугаар баганад ямар тоо байна вэ?

## БАЙРШИЛ, ХӨДӨЛГӨӨНИЙГ ТАНИХ

- 128** Дүрс аль нүдэнд байрлаж байгааг хэрхэн олох вэ?  
Хөх өнгөтэй дүрс аль нүдэнд байрлаж байгааг хэрхэн олсныг ажиглаад, ярилцаарай.




Хөх өнгөтэй дүрс Е дүгээр багана, 5 дугаар мөрөнд байна. Үүнийг Е5 нүдэнд байрлаж байна гэж уншина.



- Бусад дүрсийн байршлыг тогтоож, дэвтэртээ бичээрэй.
- $6 \times 6$  хүснэгтийн дурын нүдэнд цэгүүд тэмдэглээд, байршлыг тогтоогоорой.


- 129** Амьтдын байршлыг тодорхойлж, дэвтэртээ бичээрэй.  
*Жишээ нь:* нохой-Б2 гэх мэт.



- Баавгай туулай руу очихын тулд хэдэн нүдээр шилжих вэ?
- Шувуу нохой руу очихын тулд хэдэн нүдээр шилжих вэ?
- Хоорондоо хамгийн хол, ойр байгаа амьтдын байршлыг заагаарай.


- 130** Шатрын хөлөг дээр янз бүрийн дүрс байрлуулж, байршлыг нэрлээрэй.

131 Зааврын дагуу ажиллаарай.



- Дүрсүүдийн байршлыг дэвтэртээ бичээрэй.
- Хүснэгтийг дэвтэртээ зураад, нөхөөрэй.

Гурвалжин ба дөрвөн өнцөгт	A3, ...
Тав ба зургаан өнцөгт	B3, ...



132 A2 нүдэнд байгаа цэцгийг B3 нүд рүү хэрхэн шилжүүлэх вэ? Багштайгаа хамтран шилжүүлээрэй. Хэдэн янзаар шилжүүлж болох вэ?

133 Зүг чигийн талаар багштайгаа ярилцаарай.

Монгол улсын газрын зургийг ажиглаарай.

Завхан аймаг-Монгол улсын баруун хойд зүгт байрладаг.

Монгол улсын төв цэг Өвөрхангай аймагт оршдог.



- Танай аймаг Монгол улсын аль зүгт байгаа вэ? Заагаарай.
- Чиний очихыг хүсдэг аймаг хаана байрлаж байна вэ?



## ХОЁРООР ҮРЖҮҮЛЭХ

**134** Ширээ бүрд 2 сурагч суудаг. Таван ширээнд нийт хэдэн хүүхэд суусныг олъя.

Багцын тоо	Багц дахь юмсын тоо	Нийт юмсын тоо
1	2	2
2	2	4
3	2	6
4	2	
5	2	

**135** Үржвэрийн утгыг олоорой.

- $6 \times 2$
- $7 \times 2$
- $8 \times 2$
- $9 \times 2$
- $10 \times 2$


Би эдгээр үржвэрийн утгыг шууд олж чадна.



Яагаад гэвэл үржвэрийн утга ...-оор нэмэгдсэн байна.

**136** Асуултад хариулж, үржвэрийн утгыг олоорой. Анги 9 ширээтэй. Ширээ бүрд 2 хүүхэд суудаг.

- 5 ширээнд нийт хэдэн хүүхэд суух вэ?
- Ангийн бүх ширээнд хэдэн хүүхэд суух вэ?
- 6 ширээнд суусан нийт хүүхдийн тооноос 8 ширээнд суусан нийт хүүхдийн тоо хэдээр олон бэ?



**137** Хүрдээ гүйцээгээрэй. Үржвэрт харгалзах тоог хүснэгтэд будаарай.

- $1 \times 2 = 2$
- $2 \times 2 = 4$
- $3 \times 2 = 6$
- $4 \times 2 = \dots$
- $5 \times 2 = \dots$
- $6 \times 2 = \dots$
- $7 \times 2 = \dots$
- $8 \times 2 = \dots$
- $9 \times 2 = \dots$
- $10 \times 2 = \dots$

Нэг хоёр нь хоёр.  
Хоёр хоёр нь дөрөв.  
Гурван хоёр нь зургаа.  
Дөрвөн хоёр нь ...

1	2	3	4	5	6	7	8	9	10
11	12	13	14	15	16	17	18	19	20
21	22	23	24	25	26	27	28	29	30
31	32	33	34	35	36	37	38	39	40
41	42	43	44	45	46	47	48	49	50
51	52	53	54	55	56	57	58	59	60
61	62	63	64	65	66	67	68	69	70

138



### Хоёрыг үржүүлж, даалуу тоглоё.

**Хэрэглэгдэхүүн:** Даалуу


**Заавар:** Хосоор тоглоно.

а. Сурагч тус бүр 10 даалуу авна.

б. Эхний сурагч 1 даалуу гаргаж, ширээн дээр тавина.

в. Нөгөө нь нүдний тоо нь ижил байх даалууны талыг нийлүүлж өрнө.

*Жишээ нь:*



$$2 \times 3 = 6$$

г. Нийлүүлж өрсөн нүдний тоог олох үржвэр бичээд, утгыг олно.

Үйлдлийг давтан, даалуугаа дуустал үргэлжлүүлнэ. Буруу нүдээр нийлүүлсэн буюу буруу жишээ зохиосон хүүхэд өнжинө.

**139** Охинд 7 дэвтэр байв. Ахад нь түүнээс 2 дахин олон дэвтэр байв. Тэд нийт хэдэн дэвтэртэй вэ?

**140** Нэг ангийнхан зугаалгаар явахдаа 2 гэрт буудаллав.

- Эхлээд гэр бүрд 5 хүүхэд оров. Хоёр гэрт нийт хэдэн хүүхэд орсон бэ?


- Дараа нь гэр бүрд 3 хүүхэд нэмж оров. Нэг гэрт нийт хэдэн хүүхэд орсон бэ?

- Гэр тус бүр хэдэн хүүхэдтэй болсон бэ?


- Хоёр гэрт нийт хэдэн хүүхэд орсон бэ?

**141** Дүрсүүдийг мөр, мөрөөр багцлаарай.


Багцалсан дүрсээ үржвэр хэлбэрээр бичиж, утгыг олоорой.



$$\square \times \square = \square$$



$$\square \times \square = \square$$



$$\square \times \square = \square$$

**142** Хүүхдүүд эрвээхэй урлав. Нэг талын далавчийн толбыг тавив. Нэг эрвээхэйн 2 далавчийн толбоны тоо ижил бол эрвээхэй бүр хэдэн толботой вэ?



143 Хүү, охин харандааны тоог олжээ. Хэрхэн олсныг, ярилцаарай.



144 Зураглалд тохирох үржвэрийг бичээд, утгыг олоорой.



$$\square \times \square = \square$$

$$\square \times \square = \square$$

Тэнцэтгэлд ялгаа байна уу? Ижил тоо ижил утгыг илэрхийлсэн үү? Яагаад?

145 Гурван шилэн сав байв. Сав бүрд 2 загас байгаа бол нийт хэдэн загас байна вэ?




$$\square \times \square = \square$$

146 Хоёр шилэн сав байв. Сав бүрд 3 загас байгаа бол нийт хэдэн загас байна вэ?




$$\square \times \square = \square$$

147 Тоон хэрчим дээрх тэмдэглэгээг ажиглаарай. Тохирох тоон тэнцэтгэл бичээрэй.



$$\square \times \square = \square$$



$$\square \times \square = \square$$

148 Илэрхийллийн утгыг олоод, аравтаар тоймлоорой.

а.  $9 \times 2 - 11$

б.  $2 \times 10 - 3$

в.  $6 \times 2 + 39$

г.  $2 \times 7 + 48$

- 149** Хүүхдүүд мөр, баганын алиных нь тоог түрүүлж бичиж, үржүүлэх үйлдэл зохиосныг ярилцаарай.



	1	2		
1	●	●		
2	●	●		
3	●	●		
4	●	●		

$2 \times 4 = 8$

	1	2	3	4	
1	●	●	●	●	
2	●	●	●	●	

$4 \times 2 = 8$

Үржигдэхүүний байрыг солиход үржвэрийн утга өөрчлөгдөхгүй байна.

$2 \times 4 = 8$   
 $4 \times 2 = 8$

- 150** Хэсэг бүрд байгаа одны тоог үржвэр хэлбэрээр бичээд, бодоорой.

а.

б.


в.

г.

- 151** Үржвэрүүдийг зургаар илэрхийлээрэй.

$2 \times 7$                        $2 \times 8$                        $2 \times 10$                        $6 \times 2$

- 152** Тоон шугам дээрх тэмдэглэгээг ажиглаарай. Тохирох үржвэр бичээд, утгыг олж жишээрэй.



- 153** Хүснэгтэд байгаа тоонууд ямар тоонуудын үржвэр болохыг олоорой.

		1 дүгээр үржигдэхүүн									
		1	2	3	4	5	6	7	8	9	10
2 дугаар үржигдэхүүн	1										10
	2					10	12				
	3										
	4										
	5										
	6										
	7										
	8										
	9										
	10	10									

154



**Үржвэрийн утгыг олъя**

**Хэрэглэгдэхүүн:** Хүүхэд бүр зурагтай карт 1 багц, 2-ын үржвэртэй тоон карт 1 багц, 1-20 хүртэлх тоотой карт 1 багцыг тус тус авна.

**Заавар:** Хосоор тоглоно. Картыг ээлжлэн гаргаж тоглоно.

1. Зурагтай карт гаргана.
2. Карт дээрх зургийн тоотой тэнцүү үржвэр бүхий тоон карт гаргана.
3. Үржвэрийн утгад тохирох тоотой карт гаргана. Карт нь түрүүлж дууссан нь хожно.



155

Аль нь их вэ? Цээжээр бодоорой.

- а.  $2 \times 8 \dots 8 \times 2$ ;      б.  $4 \times 2 \dots 3 \times 2$       в.  $2 \times 9 \dots 2 \times 10$   
 г.  $7 \times 2 \dots 2 \times 7$       д.  $5 + 5 \dots 2 + 2 + 2 + 2 + 2$       е.  $3 + 2 \times 3 \dots 3 + 3 + 3$


156

Торхонд 35 литр айраг байв. Үүнээс 2 литрийн саваар 4 удаа авч хэрэглэв. Торхонд хэдэн литр айраг үлдсэн бэ?

157

Охин 4 онгоц зурав.

Хүү охиноос 2 дахин олон онгоц зурав.



Хүү хэдэн онгоц зурсан бэ?



2 дахин олон гэдэг нь 2-оор үржүүлэхтэй адил гэж ойлголоо.




158

Охин 7 дэвтэртэй. Ах нь түүнээс 2 дахин олон дэвтэртэй. Ах хэдэн дэвтэртэй вэ?



159

Тохирох тоог бичээрэй.




## ТАВААР ҮРЖҮҮЛЭХ

**160** Хүү элсэн дээр гараараа мөр гарган тогложээ. Элсэн дээр хэдэн удаа дарж, хэдэн хурууны мөр гаргасныг олъё.

**161** Чулууг 5, 5-аар багцлаарай. Нийт чулууны тоог олох үржвэрийг бичээд, утгыг олоорой.

×  =

**162** Асуултад хариулаарай.  -5 төгрөг

Амар	
Баярмаа	
Хэрлэн	
Тунгаа	

- Хүүхэд бүр хэдэн төгрөгтэй вэ?
- Хэн хамгийн их төгрөгтэй вэ?
- Баярмаа, Тунгаа хоёр нийлээд хэдэн төгрөгтэй вэ?
- Амар, Хэрлэнгээс хэдээр цөөн төгрөгтэй вэ?
- Амар анх байсан төгрөг дээрээ өдөр бүр 5 төгрөг нэмж хийдэг. Амар 7 хоногийн дараа хэдэн төгрөгтэй болох вэ?

**163**




Хулангийн байшингийн дугаар хоёр оронтой тоо. Байшингийн дугаарын цифрүүдийн нэг нь нөгөөгөөсөө 2 дахин их. Тэгвэл Хулангийн байшин ямар дугаартай байж болох вэ?






**164**  $5 \times 4$  бичлэгт тохирох зурагтай хэсэг аль нь вэ?



**165** Хүү хэдэн машинтай вэ?  
Машинуудын дугуй нийлээд хэд болох вэ?



**166** Хүүхдүүд төмөр утсаар дүрс бүтээв. Дүрс бүрийн талын урт ижил. Дүрс бүрд хэдэн сантиметр төмөр утас хэрэглэсэн бэ?



**167** Цээжээр бодоорой. Үржвэрт тохирох зураглал хийгээрэй.

а. 2 ба 5-ын үржвэр  
в. 5 ба 3-ын үржвэр

б. 4 ба 5-ын үржвэр  
г. 5 ба 5-ын үржвэр

**168**



- а. Таван мод байв. Мод бүр дээр 3 шувуу суужээ. Бүх модон дээр нийт хэдэн шувуу сууж байсан бэ?
- б. Мод тус бүрд 4 шувуу нэмж ирэн суув. Бүгд хэдэн шувуу нэмж ирсэн бэ?
- в. Бүх модонд шувуу нэмж суусны дараа нийт хэдэн шувуутай болсон бэ?
- г. Мод бүрээс 2, 2 шувуу нисэн одов. Нийт хэдэн шувуу ниссэн бэ?
- д. Модонд анх сууж байсан шувуунаас олон шувуу үлдсэн үү, цөөн шувуу үлдсэн үү?

## АРВААР ҮРЖҮҮЛЭХ

**169** Туяа мөнгөний гахайд өдөр бүр 10 төгрөг хийдэг. Арав хоногийн дараа хэдэн төгрөг хийсэн байх вэ?

1 дэх өдөр

2 дахь өдөр

3 дахь өдөр

4 дэх өдөр

5 дахь өдөр




$$\begin{array}{l}
 +1 \quad \boxed{1} \times \boxed{10} = \boxed{10} \\
 +1 \quad \boxed{2} \times \boxed{10} = \boxed{\phantom{00}} \\
 +1 \quad \boxed{3} \times \boxed{10} = \boxed{\phantom{00}} \\
 +1 \quad \boxed{4} \times \boxed{10} = \boxed{\phantom{00}} \\
 +1 \quad \boxed{5} \times \boxed{10} = \boxed{\phantom{00}}
 \end{array}$$

**170** Дугуйланд суралцдаг сурагчдын тоог дүрслэн үзүүлжээ.  $\boxtimes = 10$  сурагч

Дугуйлан	Сурагчийн тоо
Хөгжим	$\boxtimes$
Бүжиг	$\boxtimes \boxtimes \boxtimes \boxtimes \boxtimes \boxtimes \boxtimes \boxtimes \boxtimes$
Шатар	$\boxtimes \boxtimes \boxtimes \boxtimes \boxtimes$
Зураг	$\boxtimes \boxtimes \boxtimes$

- Дугуйлан бүрд хэдэн сурагч суралцдаг вэ?
- Ямар дугуйланд хамгийн олон сурагч суралцдаг вэ? Ямар дугуйлан хамгийн цөөн сурагчтай вэ?
- Бүжгийн дугуйлангийн сурагч, зургийн дугуйлангийн сурагчаас хэдээр олон бэ?
- Шатар, хөгжмийн дугуйланд нийт хэдэн сурагч суралцдаг вэ?

**171** Шугам дээрх тоог гүйцээгээрэй.



**172** Арваар үржүүлж, хүснэгтийг гүйцээгээрэй.

×	1	2	3	4	5	6	7	8	9	10
10	10	20			50					


Хүснэгтийн нэг баганад байгаа тоонуудыг харьцуулаарай. Юу ажиглагдсан бэ?



173



### Гаргасан хурууны тоог 10-аар үржүүлье



**Заавар:** Хосоор тоглоно.


1. Нэгэн зэрэг 1-5 хүртэл хуруу гаргана.
2. Эхний хүүхэд гаргасан хуруунуудын тоог нэмээд, нийлбэрийг хэлнэ.
3. Нөгөө хүүхэд түүний хэлсэн тоог 10-аар үржүүлж, үржвэрийг хэлнэ.
4. Дарааллаа сольж тоглоно.

**174** Дугуй дүрсийн тоог хэрхэн олох вэ?

	1	2	3	4	5	6
1	●	●	●	●	●	●
2	●	●	●	●	●	●
3	●	●	●	●	●	●
4	●	●	●	●	●	●
5	●	●	●	●	●	●
6	●	●	●	●	●	●
7	●	●	●	●	●	●
8	●	●	●	●	●	●
9	●	●	●	●	●	●
10	●	●	●	●	●	●



	1	2	3	4	5	6	7	8	9	10
1	●	●	●	●	●	●	●	●	●	●
2	●	●	●	●	●	●	●	●	●	●
3	●	●	●	●	●	●	●	●	●	●
4	●	●	●	●	●	●	●	●	●	●
5	●	●	●	●	●	●	●	●	●	●
6	●	●	●	●	●	●	●	●	●	●



**175** Илэрхийллийг бичээд, утгыг олоорой.

- 4 ба 10-ын үржвэрийг 5-аар ихэсгэх
- 5-ыг 2-оор нэмэгдүүлээд 10-аар үржүүлэх
- 3 ба 5-ын үржвэрийг 10-аар хорогдуулах

176




Шуудай төмс  $4 \times 10$ -аас их,  
 $10 \times 5$ -аас бага килограмм жинтэй.  
 Шуудай төмс хэдэн килограмм жинтэй байж болох вэ?  
 Тоон шулуун дээр тэмдэглээрэй.

**177** Саальчин 10 үнээ саав. Үнээ бүрээс 8 литр сүү саажээ. Түүний 35 литрээр нь тараг бүрсэн бол хэдэн литр сүү үлдэх вэ?

## НЭГ БА ТЭГЭЭР ҮРЖҮҮЛЭХ

**178** Мэндээ, Сэлэнгэ хоёр цагариг шидэж тоглов.



Мэндээ 5 цагариг шидээд түрүүлжээ. Сэлэнгэ 7 цагариг шидээд хожигдов. Яагаад ийм дүн гарсныг ярилцаарай.

Шонд орсонд 1 оноо өгөөд, шонд оруулаагүй цагаригт оноо өгөөгүй юм байна. Түүнийг яаж тэмдэглэдэг юм бол?



Мэндээ: Шонд хэдэн цагариг оруулсан бэ?

$$\square \times \square = \square$$

Шонд хэдэн цагариг оруулаагүй вэ?

$$\square \times 0 = \square$$

Сэлэнгийн цагаригийн оноог тооцоорой.

**179** Үржвэрийн утгыг олоорой.

$$\square \times \square = \square$$

$$\square \times \square = \square$$

$$\square \times 0 = \square \text{ харандаа}$$



Тоог 0-ээр үржүүлэхэд 0 гардаг юм байна.  $3 \times 0 = 0$

0-ийг тоогоор үржүүлэхэд 0 гарах болов уу.  $0 \times 3 = 0$



Үржигдэхүүний байр солиход утга өөрчлөгддөг эсэхийг санаарай.


**180** Дөрвөн найз “Хайч, чулуу, даавуу” тоглоом тоглов. Гурван найз “чулуу” гаргав. Тэд нийт хэдэн хуруу гаргасан бэ?

$$\square \times \square = \square$$

Нэг найз “хайч” гаргав. Хэдэн хуруу гаргасан бэ?

$$\square \times \square = \square$$

Дөрвөн найз нийт хэдэн хуруу гаргасан бэ?



**181** Илэрхийллийн утгыг олоорой.

$$1 \times 7,$$

$$8 \times 1,$$

$$1 \times 9,$$

$$10 \times 1,$$

$$0 \times 2$$

$$0 \times 3 + 17,$$


$$5 \times 1 + 24,$$

$$4 \times 1 - 4,$$


$$7 \times 0 + 49,$$

$$6 \times 0 + 31$$

**182** Шугам дээрх тэмдэглэгээг ажиглаарай. Тохирох тоон тэнцэтгэл бичээрэй.



$$\square \times \square = \square$$



$$\square \times \square = \square$$

Тоог нэгээр үржүүлэхэд тэр тоо өөрөө гардаг юм байна.



**183** Хүснэгтийн хоосон нүдэнд тохирох тоог бичээгээрэй.

×	1	2	3	4	5	6	7	8	9	10
1	1		3	4						

×	1	2	3	4	5	6	7	8	9	10
0	0	0			0					

Асуултын дагуу ярилцаарай.

- Хүснэгтийг нөхөж, хүрдийг гүйцээхэд хялбар байсан уу? Яагаад?

- Тоог нэгээр үржүүлэхэд ямар тоо гарсан бэ?

- Тоог тэгээр үржүүлэхэд ямар тоо гарсан бэ?

**184** Үржвэрийн утга нь бусдаас өөр гарах илэрхийллийг олоорой.

$7 \times 0$ ,  $0 \times 3$ ,  $8 \times 0$ ,  $1 \times 1$ ,  $0 \times 5$ ,  $10 \times 0$

**185**  $\square$  -д тохирох тоог бичээрэй.

$\square \times 5 = 5$ ,  $6 \times \square = 6$ ,  $1 \times \square = 7$ ,  $10 \times \square = 0$ ,  $0 \times \square = 0$   
 $8 \times \square = 8$ ,  $85 - \square = 85$ ,  $47 + \square = 47$ ,  $\square - 100 = 0$ ,  $0 + \square = 99$


**186** Жишээрэй.

а.  $12 + 0 \dots 12 \times 0$  б.  $35 - 0 \dots 35 \times 1$  в.  $8 + 1 \dots 1 \times 8$  г.  $27 \times 1 \dots 35 \times 0$

**187**



Хэн, хэдэн оноог авсныг олж.



	Хүдэр	Мөнгөн	Жаргал	Буянаа
0 оноо	2			
1 оноо	4			
Нийт оноо	4			

Хэн хамгийн их оноо авсан бэ?

Хэн хамгийн бага оноо авсан бэ?

188




Хэн нь зөв хэлсэн бэ? Ярилцаарай.  
 Охин самбарт 8 од зуржээ.  
 Хүү: Охин одыг 2 багана, 4 мөрөнд байрлуулж зурсан.  
 Охин: Үгүй, одыг 2 мөр, 4 баганад зурсан гэжээ.


189

Хүснэгтэд байгаа дугуй дүрсийн тоог олох үржвэрийг 2 янзаар бичиж болох уу? Яагаад? Жишээгээр батлаарай.


а.



б.




в.



190

3 хонь хургалжээ. Бүгд ихэр хурга гаргасан бол нийт хэдэн хургатай болсон бэ?






191

Цацралын байр 4 орцтой. Орц бүр 10 айлтай. Цацралын байр нийт хэдэн айлтай вэ? Цацралынх гуравдугаар орцны сүүлийн хаалга бол хэдэн тоотод амьдардаг вэ?

192

Цасан бөмбөг хийцгээе. Аль бөмбөг хамгийн том болох вэ?



193



Мөнгөний загвар ашиглан тооцоолоорой. Эмээ ач хүүд хэдэн ширхэг 5 төгрөг, 10 төгрөг өгчээ. Хүү бүх мөнгөө бүхэлдүүлж нэг ширхэг 50 төгрөгийн дэвсгэртэй болжээ.  
 Эмээ хүүд хэдэн ширхэг 5₮, 10₮ өгсөн байж болох вэ?

**194** Хүүгийн нэг өдрийн тэмдэглэлийн хэсгээс үржүүлэх үйлдлээ ашиглан уншицгаая. Хүү хэдэн цагт юу хийсэн бэ?



Сургуульдаа явав.

Хүүг хичээлдээ ирэхэд 9 ширээний сурагч ирсэн байв. Ширээ бүрд 2 сурагч суудаг. Ангид нийт хэдэн сурагч байсан бэ?



Номын санд суув.

Сургуулийн номын санд 3 цаг ном уншив. Би цагт 5 үлгэр уншсан. Нийт хэдэн үлгэр уншсан бэ?




Дараа нь 4 тавиурт ном өрөв. Нэг тавиурт 10 ном өрсөн. Нийт хэдэн ном өрсөн бэ?



Дэлгүүрт оров.

Сагстай алим асгарчээ. Худалдагч алимьг 5,5-аар нь уутанд хийв. Алимьг хэдэн уутанд хийсэн бэ?



Би 2 сагс өндөг авав. Сагс бүрд 6 ширхэг өндөг байв. Нийт хэдэн өндөг худалдаж авсан бэ?




Гэрийн ажилд туслав.

Манайх 5 ам бүлтэй. Би хүн бүрд 4 бууз таваглав. Нийт хэдэн бууз тавагласан бэ?



Дүүдээ гэрийн даалгавраа хийхэд нь туслав. Дугуйд тохирох тоог олоорой




## ӨӨРИЙГӨӨ СОРИОРОЙ










- 195** Илэрхийллийг бичээд, утгыг олоорой.  
 а. 81-ийг 62 ба 16-ийн ялгавраар багасгах  
 б. 29-ийг 47 ба 15-ын нийлбэрээр ихэсгэх
- 196** Дараах хүснэгтийг дэвтэртээ зураарай.  
 а. 2 мөр, 5 баганатай      б. 5 мөр, 2 баганатай
- 197** Цээжээр бодоорой.

53	53	53	53
60 - 38	38 + 18	38	38
27	27	27	27
46	46	82 - 46	46
25	25	25	25 + 24
59	59	59	59

- 198** Зурагт байгаа 20 ширхэг харандааг хэчнээн янзаар багцалж болох вэ? Багцалсан харандааны тоог үржвэр хэлбэрээр бичээрэй.




- 199** Дугуйланд 31 охин суралцдаг. Охидоос 4-өөр цөөн хөвгүүд суралцдаг бол дугуйланд хэчнээн хөвгүүн суралцдаг вэ?
- 200** Дүрсүүдийн байршлыг дэвтэртээ бичээрэй.

4					
3					
2					
1					
	А	Б	В	Г	Д


## УРТЫГ ХЭМЖИХ

**201** Гурван найз шугам хэрэглэн, номын уртыг хэмжив. Хэн нь зөв хэмжсэн бэ?




**Шугам хэрэглэн хэрчмийн уртыг хэмжихдээ анхаараарай.**

1. Шугамын 0 хуваарийг хэрчмийн эхлэлд тааруулж, шугамаа хэрчмийн дагуу байрлуулна.
2. Хэрчмийн төгсгөл шугамын ямар хуваарьд харгалзаж байгааг харна.



**202** Хэрчмүүдийн урт хэдэн сантиметр байна вэ?




**203** Хэрчмүүдийн уртыг шугамаар хэмжиж, хэмжээг дэвтэртээ бичээрэй.



**204** а. 6 см, б. 9 см, в. 11 см урттай хэрчмүүд дэвтэртээ зураарай.

Шугам хэрэглэн хэрчим зурахдаа:

1. Шугамаа дэвтэр дээр байрлуулаад, хэрчмийн эхлэл болон төгсгөлийн цэгийг тэмдэглэнэ.
2. Эхлэл болон төгсгөлийн цэгийг шулуунаар холбоно.





**205** Охин цавууныхаа уртыг хэмжжээ. Хэдий хэмжээний урттай байна вэ?




Цавууны уртын хэмжээ 8 см-ээс их. Гэхдээ 9 см-т хүрэхгүй байна.



Тохирсон нэгж байдаг болов уу?

1 сантиметр уртыг арван тэнцүү хэсэгт хувааж, нэг хэсгийн уртын хэмжээг 1 миллиметр гэж нэрлээд 1 мм гэж тэмдэглэдэг.



Цавууны урт 8 см 7 мм байх нь. Түүнийг 8 сантиметр 7 мм урт гэж хэлнэ.

1 сантиметр нь 10 миллиметртэй тэнцүү юм байна.  $1 \text{ см} = 10 \text{ мм}$




**206** Дараах туузуудын аль нь 4 см 6 мм урттай байна вэ?




**207** Та нар харандаа, үзэгнийхээ уртыг хэмжээрэй. Ямар урттай байна вэ?

**208** а. Хэрчмийн уртыг олоорой. Хариугаа см болон мм-ээр илэрхийлээрэй. Дараа нь зөвхөн мм-ээр илэрхийлээрэй.



Хэрчмийн урт 5 см 4 мм байна. 5 см 4 мм нь 54 мм-тэй тэнцүү.



б. Дараах хэрчмийн уртын хэмжээг см болон мм-ээр илэрхийлээрэй.



в. Дараах хэрчмийн уртын хэмжээг мм-ээр илэрхийлээрэй.









- 214** а. Хүү ширээн дээрээ гарынхаа хурууны үзүүрээс тохой хүртэлх зайг тэмдэглээд, хэмжжээ. Ямар урттай байна вэ? Ярилцаарай.

Тохойн урт 2 дм 3 см байна. 2 дм 3 см нь 23 см-тэй тэнцүү.

2 дм 3 см


20 см      3 см


- б. Хүү гарынхаа төөг хэмжжээ. -ын оронд байх тоог нөхөөрэй.

Хүүгийн гарын төө 14 см урттай. Иймд  дм  см гэж хэлж болно.

14 см =  дм  см




- 215** Дараах гурван хэрчмийн уртын хэмжээг бичээрэй. Их нэгжийг багаар нь илэрхийлж бичээрэй.



- 216** Ширээнийхээ тавцангийн өргөнийг хэмжээрэй. Хэмжээг дм ба см-ээр илэрхийлээрэй.

- 217** Дэвтэртээ 2 дм, 1 дм 2 см, 2 дм 4 см урттай хэрчмүүд зураарай.

а. Бодолтыг ажиглаж, тайлбарлаарай. Хулгана үүрнээсээ гарч тавгийн хажууд очив. Тэндээсээ бяслагийн хажууд очоод, буцаж үүрэндээ ирэхэд ямар хэмжээтэй зам туулсаныг тооцоолоорой.




$2 \text{ дм } 5 \text{ см} + 4 \text{ дм} = 6 \text{ дм } 5 \text{ см}$

Харин тавгаас бяслаг хүрэх зайг олъё.

$6 \text{ дм } 5 \text{ см} + 3 \text{ дм } 3 \text{ см} = 9 \text{ дм } 8 \text{ см}$

б. Хулгана үүрнээсээ таваг хүрэх эсвэл бяслаг хүрэх зайн аль нь богино вэ?



Ижил нэгжтэй тоонуудыг нэмнэ шүү дээ.



**218** Нөхөж бичээрэй.

а.  $7 \text{ дм } 9 \text{ см} = \square \text{ см}$

б.  $1 \text{ дм } 6 \text{ см} = \square \text{ см}$

в.  $80 \text{ см} = \square \text{ дм}$

г.  $28 \text{ см} = \square \text{ дм } \square \text{ см}$

д.  $4 \text{ дм} = \square \text{ см}$

е.  $34 \text{ см} = \square \text{ дм } \square \text{ см}$

**219** Бодоод, тайлбарлаарай.

а.  $7 \text{ дм } 3 \text{ см} + 8 \text{ дм}$

б.  $10 \text{ дм} + 3 \text{ дм } 5 \text{ см}$


в.  $5 \text{ дм} + 6 \text{ дм } 2 \text{ см}$

г.  $6 \text{ дм } 8 \text{ см} - 5 \text{ см}$


д.  $22 \text{ дм } 9 \text{ см} - 9 \text{ см}$

е.  $10 \text{ дм } 7 \text{ см} - 4 \text{ дм } 3 \text{ см}$

**220** Хүү гараа алдлан тууз хайчилж авчээ. Туузынхаа уртын хэмжээг шугамаар хэмжжээ.



100 сантиметртэй тэнцүү уртыг 1 метр гэж нэрлэдэг бөгөөд 1 м гэж тэмдэглэдэг. Метр бол уртыг хэмжих үндсэн нэгж юм.



Миний хэмжсэн туузын урт 1 м юм байна.  $100 \text{ см} = 1 \text{ м}$

**221** Та нар уртыг хэмждэг ямар багажнуудыг мэдэх вэ? Зурагт үзүүлсэн багажуудыг нэрлээрэй.




Туузан метр



Эвхдэг метр



Шугам



Гурвалжин шугам

**222**  **Уртыг хэмжье.**

1. Математикийн дэвтрийнхээ өргөнийг шугамаар хэмжээд, тэмдэглээрэй.
2. Ангийнхаа шалны өргөнийг туузан метрээр хэмжээд, тэмдэглээрэй.
3. Дэвтрийнхээ өргөн, ангийн шалны өргөн тус бүрийг ямар нэгжээр илэрхийлсэн бэ? Ярилцаарай

- 223 Ангид байгаа ширээний тавцан, самбарын уртыг 10 дм-ийн урттай утсаар хэмжээрэй.



10 дм-тэй тэнцүү урттай хэмжээ 1 метр (1 м) болно.

Уртыг хэмжих хамгийн бага нэгж бол миллиметр (мм)

$$1 \text{ см} = 10 \text{ мм}$$

$$1 \text{ дм} = 10 \text{ см}$$

$$1 \text{ м} = 10 \text{ дм}$$

- 224 Нөхөж бичээрэй.

а.  $9 \text{ см} = \square \text{ мм}$

б.  $1 \text{ м} = \square \text{ дм}$

в.  $85 \text{ см} = \square \text{ дм } \square \text{ см}$

г.  $78 \text{ см} = \square \text{ дм } \square \text{ см}$

д.  $10 \text{ дм} = \square \text{ м}$

е.  $38 \text{ мм} = \square \text{ см } \square \text{ мм}$

- 225 Бодоод, тайлбарлаарай.

а.  $7 \text{ м } 3 \text{ см} + 3 \text{ м}$

б.  $14 \text{ м} + 2 \text{ м } 8 \text{ см}$

в.  $9 \text{ м} + 2 \text{ м } 7 \text{ см}$

г.  $4 \text{ м } 9 \text{ см} - 5 \text{ см}$

д.  $22 \text{ м } 6 \text{ см} - 6 \text{ см}$

е.  $5 \text{ м } 4 \text{ см} - 2 \text{ м } 2 \text{ см}$

- 226 а. Туяа дэлгүүрээс 5 дм тууз авахаар болов. Гэтэл худалдагч түүнд 1 дм-ээр урт тууз өгөв. Туяа хэдэн сантиметр тууз авсан бэ?

б. Тэгш өнцөгт хэлбэртэй ногооны талбайн өргөн 20 м, урт нь түүнээс 20 дм-ээр илүү. Ногооны талбайн урт хэдэн метр вэ?

- 227 1 метрт хэдэн сантиметр байх вэ? 1 дециметрт хэдэн миллиметр байх вэ? Багштайгаа хамтран тооцоолоорой.


Жишээг ажиглаад, тайлбарлаарай.

3 см-ийг миллиметрээр илэрхийлье.

$$1 \text{ см} = 10 \text{ мм учир}$$

$$3 \text{ см} = 3 \times 10 \text{ мм} = 30 \text{ мм байна.}$$

- 228 Зургийн дагуу алд, өндрөө хэмжээрэй.





а. Зураг дээрх үйлдлийг дагаж хийгээрэй.

б. Чиний өндөр, гарын алдын урт ижил байна уу? Дүгнэн ярилцаарай.

- 229  -д тохирох тоог бичээрэй.  
 а. 2 дм =  см      б. 5 см =  мм      в. 6 м =  дм      г. 8 см =  мм

Үйлдлийг хэрхэн гүйцэтгэснийг ажиглаад, тайлбарлаарай.



230



**Уртыг хэмжье**


**Хэрэглэгдэхүүн:** нэхмэлийн утас, хайч, шугам

**Заавар:**

- а. 10 см урттай утас тасалж аваарай.
- б. 1 дм урттай утас тасалж аваарай.
- в. Тасалж авсан утасны уртуудыг харьцуулан ярилцаарай.

231

Дараах үндэсний уламжлалт хэмжээсүүдийг ажиглаарай.



232



**Хэмжицгээ**

**Хэрэглэгдэхүүн:** Шугам, хулдаасан метр  
**Заавар:** Өөрийн биеийн сөөм, төө, тохой, дэлэм, алд, алхмыг хэмжиж, хүснэгтэд бичээрэй.



Хэмжээ	Сурагч .....
Сөөм	
Төө	
Тохой	
Дэлэм	
Алд	

Насанд хүрсэн хүний хувьд:



Төө	18-22 см
Тохой	32-40 см
Дэлэм	70-80 см
Алд	15-18 дм
Алхам	80-100 см

## ХҮРЭЭНИЙ УРТЫГ ОЛОХ

- 233** Батын аав хашаагаа тойруулж, гэрлэн чимэглэл хийх болов. Түүнд хэдэн метр урт гэрлэн чимэглэл хэрэгтэй вэ?



- 234** Дүрсүүдийн талын уртыг хэмжээрэй. Дүрсийн бүх талын уртын нийлбэрийг олоорой.



Аливаа дүрсийн талуудын уртын нийлбэрийг түүний хүрээний урт (периметр) гэнэ.

**235**




**Хүрээний уртыг хэмжиж олъя.**

**Хэрэглэгдэхүүн:** Шугам, харандаа




**Заавар:**

- Дэвтэртээ ямар нэг дүрс зураарай.
- Дүрсийн тал бүрийн уртыг шугамаар хэмжиж бичээрэй.
- Хүрээний уртыг олоорой.
- Найзуудтайгаа ямар дүрс сонгосон, хүрээний урт хэд гарсан талаар ярилцаарай.

Зурж болох дүрсийн санаа:




- 236** Болдоод 15 см утас байв. Утсаараа дүрсийн хүрээг чимэглэх болов. Аль дүрсийн хүрээг чимэглэж болох вэ? Ярилцаарай.



**237** Бүх тал нь тэнцүү урттай дараах дүрсүүдийн хүрээний уртыг олоорой. Яаж олох нь хялбар байх вэ?


а.



б.



в.





г.



**238** Бүх тал нь тэнцүү 5 см урттай дөрвөн өнцөгт байжээ. Түүний тал бүрийн уртыг 2 дахин ихэсгэвэл хүрээний урт хэрхэн өөрчлөгдөх вэ?

**239** Дараах дүрсүүдийн хүрээний уртыг шугам ашиглахгүй тооцоолоорой.

  
1 см  
гэж  
тооцоорой.



**240** Ширээнийхээ тавцангийн хүрээний уртыг төөлж олоорой. Хэдэн төө болж байна вэ?

**241** 15 см урттай төмрийг 3 тэнцүү хуваах болов. Хэдэн удаа таслах вэ?

**242** Хүснэгтийг дэвтэртээ зураад, хоосон зайд тохирох хэмжээг бичээрэй.

Дөрвөн өнцөгт	Хүрээний урт	1 дэх тал	2 дахь тал	3 дахь тал	4 дэх тал
	100 дм	28 дм	32 дм	18 дм	?
	?	25 см	28 см	31 см	15 см
	99 м	23 м	20 м	?	28 м
	64 см	16 см	?	16 см	16 см
	80 см	?	18 см	20 см	26 см

**243** Аав 5 м талтай квадрат хэлбэртэй элсний талбайд хашлага хийх болов. 2 м урттай банз хэдэн ширхэг орох вэ?


**244** Нагац ах тэгш өнцөгт хэлбэртэй ногооны талбайг тойруулан хашаа барихаар шийджээ. Ногооны талбайн урт 10 м, өргөн нь түүнээс 3 м-ээр бага. Нагац ах хэдэн метр урттай хашаа барих вэ?

**245** Хүү эхний өдөр 59 м зам, хоёр дахь өдөр түүнээс 40 м-ээр богино зам засав. Нийт хэдэн метр урт зам зассан бэ?

**246** Ангийнхаа самбар, хананы уртыг алдалж, хаалганы уртыг төөлж хэмжээрэй. Дэвтэртээ тэмдэглээрэй.

## ХУВААХ

- 247** Билгүүнд 10 ширхэг чихэр байв. Чихрээ 2 найздаа тэнцүү хувааж өгөв. Яаж хуваасан талаар ярилцаарай.



Билгүүн нэг найздаа хэдэн чихэр өгсөн бэ?  $10 \div 2 = 5$  (чихэр)

$10 \div 2 = 5$

Нийт юмсын тоо
Хэсгийн тоо
Нэг хэсэгт ногдох юмсын тоо




2 тэнцүү хуваахад  
1, 1-ээр хуваарилж байна.  
Бас 10 ба 2-ын ногдвор  
5 гэж уншдаг.

$10 \div 2 = 5$  тэнцэтгэлийг  
10-ыг хуваах нь 2 тэнцүү 5  
гэж уншина.



- 248** 16 чихрийг 2 хайрцагт тэнцүү хувааж хийгээрэй.




- 249** 15 харандааг 5 хэсэгт тэнцүү хуваагаарай. Нэг хэсэгт хэдэн харандаа ногдох вэ?

$$\square \div \square = \square$$

- 250** Саран 60 цэцгийг 10 эгнээнд тэнцүү хувааж суулгав. Эгнээ бүрд хэдэн цэцэг суулгасан бэ?


- 251** 14 бөмбөлөг 2 хүүхэд тэнцүү хувааж авав. Нэг хүүхэдэд хэдэн бөмбөлөг ногдох вэ?

- 252** Аль зураглал нь  $20 \div 5$  илэрхийллийн утгад тохирох вэ?





**253** Хүү 10 ширхэг чихэртэй. Чихрээ найз нартаа 2, 2-оор тэнцүү хувааж өгөв.



Хүү хэдэн найздаа чихэр өгсөн бэ? 5 найздаа чихэр өгсөн.  
 Үүнийг хуваах үйлдлээр илэрхийлбэл:  $10 \div 2 = 5$  (найз)

$10 \div 2 = 5$

←
↓
→

Нийт юмсын тоо
Нэг хэсэгт ногдох юмсын тоо
Хэсгийн тоо




2-т хуваахад  
2, 2-оор багцалсан  
байна.

÷ хуваах тэмдэг



**254** 16 чихрийг 2, 2-оор хайрцагт хувааж хийгээрэй.





**255** 15 харандааг 5, 5-аар багцлаарай. Хэдэн багц болсон бэ?

÷  =

**256** Охин 60 цэцгийг 10, 10-аар эгнээнд суулгав. Хэдэн мөрөнд цэцэг суулгасан бэ?

**257** Хүүхдүүд 14 дэвтрийг 2, 2-оор хувааж авав. Хэдэн хүүхэд дэвтэр авсан бэ?

**258** Аль зураглал нь  $20 \div \square = 5$  тэнцэтгэлийн утгад тохирох вэ?  
 Учрыг тайлбарлаарай.




**259** Хуваах үйлдлээр илэрхийлээрэй.

а. 8 тарвасыг 2, 2-оор торонд хийвэл хэдэн тор хэрэгтэй вэ?




$$\square \div \square = \square$$

8 тарвасыг 2 торонд тэнцүү хувааж хийвэл нэг торонд хэдэн тарвас хийх вэ?



$$\square \div \square = \square$$

б. 15 ширхэг жүржийг 5, 5-аар сагсанд хийвэл хэдэн сагс хэрэгтэй вэ?



15 ширхэг жүржийг 5 сагсанд тэнцүү хувааж хийвэл сагс бүрд хэдэн жүрж хийх вэ?



в. 20 ширхэг гүзээлзгэнийг 10, 10-аар аяганд хувааж хийв. Хэдэн аяганд хийсэн бэ?



20 ширхэг гүзээлзгэнийг 10 аяганд тэнцүү хувааж хийвэл нэг аяганд хэдэн гүзээлзгэнэ хийх вэ?



Бодлогууд ямар ялгаатай байгааг харьцуулан ярилцаарай.



Юмсыг хэсэг бүрд тэнцүү тоогоор хуваарилахыг хуваах үйлдэл гэж ойлголоо.  $10 \div 2 = 5$

Хуваагдагч

хуваагч

ногдворын утга

гэж нэрлэдэг юм байна.

**260** Илэрхийллийг бичээд, утгыг олоорой.

- Хуваагдагч нь 16. Хуваагч нь 2.
- Хуваагдагч нь 20. Хуваагч нь 5.
- 50 ба 10-ын ногдвор.
- 18 ба 9-ийн ногдвор.

$10 \div 2$  үүнийг ногдвор гэнэ.



**261** Жишээнд тохирох зураглал хийгээрэй.

а.  $6 \div 2 = 3$ ;

б.  $6 \div 3 = 2$ ;

в.  $8 \div 2 = 4$ ;

г.  $8 \div 4 = 2$

## ТЭГШ БА СОНДГОЙ ТООГ ТАНИХ

**262** а. Эгч нь дүүгээрээ тэгш сондгой тоог ялгуулан хэлүүлэв.



1) 1, 3, 5, 7 сондгой тоо  
2, 4, 6, 8, 10 тэгш тоо

3) Би цээжилчихсэн.

2) Чи тэгш сондгой тоог  
яаж ялгасан бэ?

4) Тэгвэл эгч нь хэрхэн  
таньдаг аргыг зааж өгье.



б. Ээж тэдэнд 5 дэвтэр өгөв. Эгч, дүү хоёр хэрхэн тэнцүү хувааж авсан бэ?



Эгч ээ! Нэг дэвтэр  
үлдчихлээ. Яаж  
хуваах вэ?

Юмсыг 2 тэнцүү хуваахад  
нэг сондгойрон үлдэж  
байвал сондгой тоо болно.

Ойлголоо. Тэгвэл 2 тэнцүү хуваагдаж  
байвал тэгш тоо болох юм байна.



**263** Эгч, дүү 2-ын аргыг туршиж, 11, 12, 13, 14, 15, 16 ямар тоо болохыг олоорой.

Эгч: Миний дүү, дурын нэг тоо хэлээрэй. Би ямар тоо болохыг хэлье.

Дүү: 12

Эгч: тэгш тоо

Дүү: 15

Эгч: сондгой тоо

Дүү: Та яаж ийм хурдан олж байна аа?

Эгч: Ямар ч тооны сүүлийн орны цифр тэгш тоо бол уг тоо тэгш тоо болдог юм.

Дүү: Ямар амархан юм бэ? Баярлалаа эгч ээ.



**264** 2, 3, 4 цифр бүхий картуудыг сэлгэж, бүх боломжит 2 оронтой тоо үүсгээрэй. Үүссэн тоонуудыг тэгш, сондгойгоор ялгаарай.





265



### Тэгш, сондгой тоо бүтээх, ялгах

**Хэрэглэгдэхүүн:** хүүхэд бүрд   карт, 0-9 хүртэлх цифр бүхий тоон картууд

#### Заавар:

- 0-9 хүртэлх цифр бүхий тоон картаа доош харуулан тавина.
- Тоон картуудаас хоёрыг авч, хоёр оронтой тоо үүсгэнэ.
- Үүсгэсэн 2 оронтой тоо тэгш бол , сондгой бол  карт өргөнө.

266

23, 24, 25, 26 ширхэг савхыг хоёр тэнцүү хэсэгт хуваагаарай. Тэнцүү хувааж чадсан уу? Ямар цифрээр төгссөн тоо бүхий савхыг тэнцүү хувааж болохгүй байна вэ?

267

Бэлгэнд хийсэн тоглоомын тоог дээр нь бичжээ.



- 6 дахь бэлгэнд хэдэн ширхэг тоглоом байгаа вэ? Тэгш тоотой юу, сондгой тоотой юу?
- Тэр бэлгийг 2 хүнд тэнцүү хувааж өгч болох уу? Яагаад?
- 7 ба 8 дахь бэлэгний тоглоомын тооны нийлбэр тэгш тоо гарах уу? Тайлбарлаарай.

268

Чимгээ санасан тоогоо ангийнхаа хүүхдүүдээр таалгажээ. Чимгээ “Би цифрүүд нь ижил, 32-50 хооронд орших тоо санасан” гэв. Чимгээ ямар тоо санасан бэ?



Сондгой цифрээр төгссөн тоо сондгой тоо болдог.

Охины хэлсэн үнэн эсэхийг жишээгээр шалгаарай.

269



- Тэгш тоо бүр хэдэд хуваагддаг вэ?  
а. 2                      б. 3                      в. 4
- Ямар цифрүүдээр төгссөн тоог сондгой тоо гэдэг вэ?  
а. 0, 1, 3, 5, 7, 9                      б. 0, 2, 4, 6, 8                      в. 1, 3, 5, 7, 9
- 123 гэсэн тооны тэгш, сондгой тоо эсэхийг илэрхийлэх цифр аль вэ?  
а. 1                      б. 2                      в. 3
- 5-д хуваагдах, 2 оронтой, тэгш тоог олоорой.  
а. 45                      б. 150                      в. 30                      г. 105

## ДӨРВӨӨР ҮРЖҮҮЛЭХ, ДӨРӨВД ХУВААХ

270




### Дөрвөөр үржүүлье

**Хэрэглэгдэхүүн:** 1-10 хүртэлх тоон карт, 4 талтай дүрс, тоолох хэрэгсэл, шоо

#### Заавар:

1. Доош харуулсан картаас нэгийг сугалж авна.
2. Сугалсан картан дээрх тоогоор тоолох хэрэгсэл авна.
3. Дүрсийн өнцөг бүрд картан дээрх тоогоор тоолох хэрэгсэл тавина.
4. Дүрс дээрх тоолох хэрэгслийн нийт тоог үржвэрээр бичээд утгыг олно.
5. Карт дуустал үйлдлийг гүйцэтгэнэ.

3



$$4 \times 3 = 12$$

271

Боргоцойг 4, 4-өөр багцлаарай. Үржүүлэх ба хуваах үйлдлийн жишээ зохиож бодоорой.



Хэдэн багц болсон бэ? Нийт хэдэн боргоцой вэ?



272

Илэрхийллийн утгыг олоорой.

а.  $6 \times 4$

б.  $9 \times 4$

в.  $7 \times 4$

г.  $(17 - 9) \times 4$

д.  $12 \div 4$

е.  $28 \div 4$

ж.  $36 \div 4$

з.  $(24 + 16) \div 4$

273

Хүүхдүүд савхаар квадрат бүтээжээ.

Өсөхөө	<input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/>
Түвшин	<input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/>
Марал	<input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/>
Буянаа	<input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/>

- Хүүхэд тус бүр хэдэн савх хэрэглэсэн бэ?
- Буянаа хэнээс 2 дахин олон савх хэрэглэсэн бэ?
- Маралаас 4-өөр зөрөөтэй савх хэрэглэсэн хүүхдийг нэрлээрэй.

274

Хэсэг харандаанаас 20 ширхгийг авах болжээ.

- 4, 4-өөр багцалбал хэдэн багц харандаа авах вэ?
- 5, 5-аар багцалбал хэдэн багц харандаа авах вэ?

275

Хүснэгт дэх тоог ажиглаад, гүйцээж бичээрэй.

	4	5	6
7	8		10
11		13	
15	16		

4-д хуваагдах тоонуудыг олоод, будаарай. Бүх тоо нь тэгш байх баганыг нэрлээрэй.

**276** Цайны газар 4 ширээтэй. Ширээ бүрд 8 хүн суух боломжтой.



- Өглөө ширээ бүрд 3 хүн сууж хооллов. Өглөө нийт хэдэн хүн хооллосон бэ?
- Өдөр ширээ бүрд 5 хүн сууж хооллов. Өдөр нийт хэдэн хүн хооллосон бэ?
- Орой бүх ширээнд 8 хүн суув. Орой ширээнд нийт хэдэн хүн суусан бэ?
- Өнөөдөр нийт хэдэн хүн цайны газраар үйлчлүүлсэн бэ?

**277** Өвөөгийнх төл малын 2 хашаа барив. Хашаа бүр 4 талтай.


- Нэг хашааны тал бүр 6 метр урттай бол хэдэн метр хашаа барьсан бэ?
- Нөгөө хашааны тал бүр 8 метр урттай бол хэдэн метр хашаа барьсан бэ?
- Өвөөгийн төлийн 2 хашааны нийт уртыг олоорой.

**278** Ногдворын утга, хуваагдагч ямар зүй тогтлоор өөрчлөгдөж байгааг ярилцаад, хүснэгтийг нөхөөрэй.

Хуваагдагч	16	20	24		32	
Хуваагч			4	4	4	
Ногдворын утга		5	6	7		

**279** Булган 6 харандаа, Төгсөө Булганаас 2 дахин олон харандаа үзүүрлэв. Дүү Төгсөөгөөс 4 дахин цөөн тооны харандаа үзүүрлэжээ. Тэд нийт хэдэн харандаа үзүүрлэсэн бэ?

**280** Үйлдлийг гүйцэтгэж тоог нөхөөрэй.



1 ба 3 дугаар баганын тоонууд хэд дахин зөрөөтэй байна вэ? Ярилцаарай.



4-өөр үржүүлэх нь 2-оор 2 дахин үржүүлсэнтэй адил юм байна.

2-оор үржүүлэх хүрдийг хоёр дахин ихэсгэхэд 4-ийн хүрд үүсэж байна.



- 281** Хүүхдүүд самбар дахь илэрхийллийн утгыг олжээ. Хэний хариу зөв бэ? Ярилцаарай.  
Охин илэрхийллийн аль үйлдлийг эхэлж бодсон бэ? Бодож туршаарай.



- 282** Үйлдлийг гүйцэтгэж, тэнцэтгэл үнэн болохыг харуулаарай.  
а.  $8 + 2 \times 4 = 16$     б.  $24 - 16 \div 4 = 20$     в.  $20 \div 4 + 1 = 6$     г.  $36 \div 4 \times 2 = 18$

Илэрхийллийн утгыг олохдоо эхлээд үржүүлэх, хуваах үйлдлийн аль түрүүнд байгааг, дараа нь нэмэх, хасах үйлдлийн аль түрүүнд байгааг боддог юм байна.



- 283** Үйлдлийн дарааллаар гүйцэтгээрэй.


Жишээ нь:  $17 + 2^2 \times 9$ ,     $8 \times 6^3 + 25^2 \div 5$

- а.  $100 - 42 \div 6 - 93$     б.  $48 \div 8 \times 9 - 36$ ;    в.  $75 + 6 \times 4 - 59$

**284**



Зургийг ажиглаад, зөвийг дугуйлаарай.



- Зураг дээрх жимсний тоо аль бичлэгт тохирох вэ?  
а.  $3 \times 4$     б.  $4 \times 3$
- Зурагт тохирох өгүүлбэр аль нь вэ?  
а. 12 жимсийг 4, 4-өөр хувааж таваглажээ.  
б. 12 жимсийг 4 тэнцүү хувааж таваглажээ.
- Тавгийн тоо хуваах үйлдлийн ямар гишүүн болох вэ?  
а. хуваагдагч    б. хуваагч    в. ногдвор
- Тавагт байгаа жимсний тоо хэсгийн тоо мөн үү?  
а. тийм    б. үгүй
- Ногдвор нь хэд вэ?  
а. 3    б. 4    в. 12
- Хоёр тавагт байгаа жимсний тоо 4 тавагт байгаа жимсний тооноос хэдээр зөрөөтэй байна вэ?  
а. 2-оор    б. 4-өөр    в. 6-аар    д. 2 дахин
- Үйлдлийн дарааллыг зөв тэмдэглэсэн илэрхийлэл аль нь вэ?

а.  $7 \times 4 + 24 \div 6$

б.  $7 \times 4 + 24 \div 6$

в.  $7 \times 4 + 24 \div 6$



## НАЙМААР ҮРЖҮҮЛЭХ, НАЙМД ХУВААХ

285




### Наймаар үржүүлье

**Хэрэглэгдэхүүн:** Шатрын хөлөг, 3 өнгийн дугуй дүрс

**Заавар:**


- Эхний мөрөнд цагаан өнгийн дугуй дүрсүүдийг байрлуулна.
- Гурван мөрөнд улаан өнгийн дугуй дүрсүүдийг байрлуулна.
- Дөрвөн мөрөнд цэнхэр өнгийн дугуй дүрсүүдийг байрлуулна.
- Шатрын хөлөг дээр цагаан, улаан, цэнхэр өнгийн дугуй дүрс тус бүр хэдийг өрсөн бэ?
- Нийт хэдэн даам өрсөн бэ?



286

Лхагва гарагийн нислэгийн мэдээтэй танилцъя.

Нисэх цаг	Буух цаг	Нисэх чиглэл	Зорчигчийн тоо
		Улаанбаатар-Чойбалсан	7 эгнээ бүрд 8 хүн суусан.
		Чойбалсан-Даланзадгад	9 эгнээ бүрд 8 хүн суусан.
		Даланзадгад - Улаанбаатар	Өмнөх нислэгээс 22-оор цөөн хүн



- Чиглэл бүрд хэдэн хүн ниссэн бэ?
- Лхагва гарагт энэ онгоцоор хэдэн хүн аялсан бэ?
- Өдрийн 1:00 цагт аль чиглэлд хэдэн хүн ниссэн бэ?
- Аль чиглэлд нисэхэд хамгийн их хугацаа зарцуулсан бэ?
- Онгоц лхагва гарагт нийт хэдэн цагийн нислэг хийсэн бэ?


287

Үржвэрийг олоорой. Илэрхийлэл бүрийн 2 дугаар үржигдэхүүн баганын дагуу хэрхэн өөрчлөгдөж байгаа талаар ярилцаарай.

$1 \times 2$	$2 \times 2$	$3 \times 2$	$4 \times 2$	$5 \times 2$	$6 \times 2$	$7 \times 2$	$8 \times 2$	$9 \times 2$	$10 \times 2$
$1 \times 4$	$2 \times 4$	$3 \times 4$	$4 \times 4$	$5 \times 4$	$6 \times 4$	$7 \times 4$	$8 \times 4$	$9 \times 4$	$10 \times 4$
$1 \times 8$	$2 \times 8$	$3 \times 8$	$4 \times 8$	$5 \times 8$	$6 \times 8$	$7 \times 8$	$8 \times 8$	$9 \times 8$	$10 \times 8$



**288** Дэвсгэр бүр дээрх шагайны зурагт тохирох үржүүлэх, хуваах үйлдлийн жишээ зохиогоорой.



$$\square \times \square = \square$$

$$\square \div \square = \square$$

$$\square \times \square = \square$$




$$\square \div \square = \square$$

**289** Илэрхийллийн утгыг олоорой.

$6 \times 4 + 6 \times 4$	$7 \times 4 + 7 \times 4$	$8 \times 4 + 8 \times 4$	$4 \times 9 + 4 \times 9$
$6 \times 8$	$7 \times 8$	$8 \times 8$	$8 \times 9$

- Багана бүрийн илэрхийллүүдийн утгыг жишээрэй.
- Эхний мөрийн илэрхийллийг бодоход хэдийн хүрд ашигласан бэ?

**290** Үйлдлийг гүйцэтгээрэй.



**291** Хүү 6 тавиур тус бүрд 4 цэцэг тавьжээ. Бүх цэцгээ 8 тавиурт тэнцүү хувааж тавибал нэг тавиурт хэдэн цэцэг болох вэ?

**292** Илэрхийлэл зохиож бодоорой. Тоолох хэрэгсэл ашиглаж болно.

- Анги 3 салаатай. Салаа бүр 8 ширээтэй. Ангид нийт хэдэн ширээ байна вэ?
- 6 хүүхэд мөөг хувааж авав. Нэг хүүхдэд 8 мөөг ногдсон. Нийт хэдэн мөөг байсан бэ?
- Хэсгийн тоо 8, хэсэгт ногдох юмсын тоо 7. Нийт юмсын тоо хэд вэ?

**293**



Бодлогыг бодохдоо зураглал хийгээрэй.

32 дүрсийг нэг хэсэгт 4 дүрс байхаар хуваарилаарай. Хэдэн хэсэг болсон бэ?

$$\square \div \square = \square$$

32 дүрсийг 4 тэнцүү хэсэгт хуваагаарай. Нэг хэсэгт хэдэн дүрс ногдсон бэ?

$$\square \div \square = \square$$

294 Нийт хэдэн төгрөг байгааг олоорой.  -5 төгрөг  -10 төгрөг






$$\square \times \square = \square$$

$$\square \times \square = \square$$

295 Үйлдлийн дарааллын дагуу гүйцэтгээрэй.

а.  $93 - 8 \times 9$    б.  $56 \div 7 + 76$    в.  $36 \div 4 + 17 - 8$    г.  $7 \times 4 + 72 \div 8$

296 Амьтдын хөлийн тоог хүснэгтэд бичээрэй.

Амьтад \ Амьтдын тоо	1	2	3	4	5	6	7	8	9	10
	2									
	4									
	8									

а. - Нэг өнгөөр будсан нүднүүдийн тооны нийлбэрийг олоорой.

- 3 гөлөгний хөл нийлээд хэд вэ?

- 2 шувуу 4 аалзны хөл нийлээд хэд болох вэ?

- 4 аалзны хөл хэдэн гөлөгний хөлтэй тэнцэх вэ?

- 22 хөлтэй болгохын тулд хэдэн аалз, гөлөг, дэгдээхий байж болох вэ?

б. Хүснэгтийн 5 дугаар баганын тоонуудыг ашиглаарай.

- Шувууны хөлийн тоо аалзны хөлийн тооноос хэд дахин бага байна вэ?

- Гөлөгний хөлийн тоо хэдэн дэгдээхийний хөлийн тоотой тэнцэх вэ?

297 Болдоо 8 см урттай резинийг 16 см хүртэл сунгав.

Бадрал 4 см урттай резинийг 16 см хүртэл сунгав.


Анх байсан резин болон сунгасан резинүүдийг тус тусад нь зураарай.

Болдоо резинээ хэд дахин сунгасан бэ?

Бадрал резинээ хэд дахин сунгасан бэ?

Хэн нь резинээ илүү сунгасан бэ?

298 Ширээний хээний тоог олоорой.



299



Хэн нь хамгийн бага тоог хэлсэн бэ?

Буян: 4 ба 8-ын үржвэр

Сөрөлт: 7 багана 4 мөртэй хүснэгт

Туяа: 3-ыг үржүүлэх нь 9


Цацрал: 6-г 4 дахин ихэсгэ

**300** 100 хүртэлх тооны хүснэгтэд

- 16-аас эхлэн 8-аар нэмэгдүүлсэн 5 тоог тэмдэглээрэй.
- 36-аас эхлэн 4-өөр хорогдуулсан 4 тоог тэмдэглээрэй.

**301** Лангуун дээр 100 ширхэг өндөг байв. Үүнээс 72 өндгийг сагсанд хийв. Өндгийг 8, 8-аар сагсанд хийсэн бол хэдэн сагс хэрэглэсэн бэ? Савлаагүй хэдэн өндөг үлдсэн бэ?

**302** Зургийг ажиглан, үржүүлэх үйлдлээр бодогдох бодлого зохиогоорой.



Галт тэрэгний тоо үржүүлэх үйлдлийн ямар гишүүн болох вэ?  
Галт тэрэгний цонхны тоо үржүүлэх үйлдлийн ямар гишүүн болох вэ?

**303** Илэрхийлэл бичиж, утгыг олоорой.

- а. 96-г 4 ба 8-ын үржвэрээр хорогдуулах
- б. 56 ба 8-ын ногдворыг 2 дахин ихэсгэх
- в. Нэгдүгээр нэмэгдэхүүн 49, хоёрдугаар нэмэгдэхүүн 6 ба 4-ийн үржвэр
- г. Хасагдагч нь 32 ба 4-ийн ногдвор, хасагч нь 8.

**304**  -д тохирох тоог цээжээр олж бичээрэй. Хэрхэн олсноо бусдадаа тайлбарлаарай.

а.  $6 \times 4 = 5 \times 4 + \square$

б.  $7 \times 8 = 2 \times 8 + \square \times 8$

в.  $8 \times 9 + 9 = 8 \times \square$

г.  $\square \times 4 + 3 \times 4 = 7 \times 4$

**305** Аравтын орон нь нэгжийн орноос 4 дахин бага байх тоо зохиогоорой. Түүнийг хамгийн бага 2 оронтой сондгой тоогоор ихэсгээрэй.

**306**



### 2, 4, 8-аар багцлан хуваая

**Хэрэглэгдэхүүн:** шоо, дэвсгэр


**Заавар:** 24 шоо аваарай.

- Хэсэг бүрд 2 шоо байхаар
- Хэсэг бүрд 4 шоо байхаар
- Хэсэг бүрд 8 шоо байхаар багцлаарай
- Тэнцүү хувааж чадсан уу? Тэнцэтгэл зохиогоорой.




## ГУРВААР ҮРЖҮҮЛЭХ, ГУРАВД ХУВААХ

**307** Зураглал бүрд тохирох үржүүлэх, хуваах үйлдлийн жишээ зохиогоорой.



$$\square \times \square = \square$$

$$\square \div \square = \square$$



$$\square \times \square = \square$$

$$\square \div \square = \square$$


**308** Мод тарих өдөр манай ангийнхан 3 эгнээ тус бүрд 8 монос, 4 эгнээ тус бүрд 3 бургас тарив. Манай ангийнхан нийт хэдэн мод тарьсан бэ?

**309** Энэрэл 24 өнгийн харандаатай. Харандаагаа найз нартаа 3, 3-аар өгөв. Энэрэл хэдэн найздаа харандаа өгсөн бэ?

**310** Зургийг ажиглаад, асуултад хариулаарай.  
 а. 3 мөрөнд нийт хэдэн мөөг байна вэ?  
 б. 3 баганад нийт хэдэн мөөг байна вэ?  
 в. 1 баганад байгаа мөөгний тоо 3 баганад байгаа мөөгний тооноос хэд дахин бага байна вэ?



**311** Тоон шулууны  $\square$ -д тохирох хуваарийн тоог бичээрэй. Үржвэрээр илэрхийлээд, утгыг олоорой.



**312** Хүснэгтийг ажиглаад ярилцаарай.

x	1	2	3	4	5	6	7	8	9	10
1	1	2	3	4	5	6	7	8	9	10
2	2	4	6	8	10	12	14	16	18	20
3		6		12						

- а. 1 ба 2-ын үржүүлэх хүрдийг хэрэглэн 3-ын үржүүлэх хүрдийг яаж гаргаж болох вэ?  
 б. 1, 2, 3-ын үржүүлэх хүрдээр өөр ямар тооны үржүүлэх хүрдийг гаргаж болох вэ? Туршаарай.


**313** Хүүхдүүд биеийн тамирын хичээл дээр эгнээгээр жагссаныг зургаар үзүүлэв.

Хэдэн эгнээгээр жагссан бэ?  
Эгнээ бүрд хэдэн хүүхэд жагссан бэ?  
Нийт хэдэн хүүхэд жагссан бэ?




$$\square \times \square = \square$$



**314** Санчир 3 ширхэг цаг засав.  
Бишрэл түүнээс 3 дахин олон цаг засав.  
Бишрэл хэдэн ширхэг цаг зассан бэ?



**315** Үйлдлийг гүйцэтгээрэй. Үржвэр, ногдворын утгыг ихээс бага руу эрэмбэлээрэй.



**316** Хүүхдүүдийн савхаар хийсэн дүрсийг хүснэгтэд үзүүлэв.




Хүдэр	
Энэрэл	
Заяа	

- Хүүхэд бүр хэдэн савх хэрэглэсэн бэ?
- Хүүхдүүд нийт хэдэн савх хэрэглэсэн бэ?
- Хүдэрийн хэрэглэсэн савхаар хэдэн гурвалжин үүсгэж болох вэ?
- Энэрэлийн дүрс бүтээсэн нийт савхаар 4 гурвалжин бүтээж болох уу? Туршаарай.

**317**



Дүрс бүрийг 3 тэнцүү хувааж будаарай.



## ЗУРГААГААР ҮРЖҮҮЛЭХ, ЗУРГААД ХУВААХ

- 318** а. Хүү хүснэгтийн нүднүүдийг 3 тэнцүү хуваав. Хуваахад үүссэн хүснэгт бүрийг 2 тэнцүү хуваав.

$\square \div 3 = \square$

$\square \div 2 = \square$

- б. Охин хүснэгтийн нүднүүдийг 6 тэнцүү хуваав. Хүү ба охины хуваасан хүснэгтийн нүдний тоог хүснэгтэд бичээрэй.

$\square \div 6 = \square$

Тэд хүснэгтийг нүднүүдийг хэрхэн хуваасан бэ? Үр дүн нь ямар байсан бэ? Ярилцаарай.


- 319** Илэрхийллийн утгыг олоорой. Багана бүрийн жишээг харьцуулаарай.

а.  $2 \times 3 \times 2$   
 $2 \times 3 + 2 \times 3$   
 $2 \times 6$

б.  $5 \times 3 \times 2$   
 $5 \times 3 + 5 \times 3$   
 $5 \times 6$

в.  $8 \times 3 \times 2$   
 $8 \times 3 + 8 \times 3$   
 $8 \times 6$

- 320** Зураглал бүрд тохирох үржүүлэх, хуваах үйлдлийн жишээ зохиогоорой.



$$\square \times \square = \square$$

$$\square \div \square = \square$$

$$\square \times \square = \square$$

$$\square \div \square = \square$$

**321** Охины номын сан 54 номтой.

- а. 6 тавиурт тэнцүү хувааж өрөв. Тавиур бүрд хэдэн ном өрсөн бэ?
- б. Тавиур бүрд 6 ном өрөв. Хэдэн тавиурт ном өрсөн бэ?

**322** Жишээрэй.

- а.  $3 \times 4 \dots 24 \div 6$
- б.  $28 + 36 \dots 8 \times 6$
- в.  $5 \times 7 + 7 \dots 6 \times 7$
- г.  $92 - 84 \dots 48 \div 6$
- д.  $5 + 6 \times 5 \dots 6 \times 6$
- е.  $9 \times 4 \dots 9 \times 3 + 3$
- ж.  $35 \div 5 \times 3 \dots 21 \times 1$
- з.  $15 \times 0 \dots 15 + 0$
- и.  $36 \div 6 + 6 \dots 6 \times 7$

**323** Зураг урлалын хичээл дээр хүүхэд бүр 6 дэлбээтэй цэцэг наав.

Охид 8 цэцэг, хөвгүүд охидоос 2 дахин цөөн цэцэг наасан.

- Хөвгүүд хэдэн цэцэг наасан бэ? Нийт хэдэн дэлбээ урласан бэ?
- Охид хэдэн цэцгийн дэлбээ урласан бэ?
- Хөвгүүдийн нийт урласан дэлбээгээр 8 дэлбээтэй цэцэг хэдийг нааж болох вэ?

**324** Хоёр хүүхдийн хэрхэн ярилцсаныг ажиглаарай. Хэний зөв бэ?



Зогсоол дээр  
3 эгнээ бүрд  
6 машин  
зогсож байна.



Зогсоол дээр 3  
эгнээ бүрд  
3-аас  
2 дахин олон  
машин зогсож  
байна



**325** Хүснэгт дэх тоог гүйцээж бичээрэй.

Хуваагдагч	18	24		36		
Хуваагч	6		6	6	6	
Ногдворын утга		4	5			8

- Хуваагдагч 6-аар ихсэхэд ногдворын утга хэрхэн өөрчлөгдсөн бэ?
- Ногдвор 2-оор ихсэхэд үйлдлийн ямар гишүүн хэрхэн өөрчлөгдсөнийг ярилцаарай.

**326** Охин: 3-ын хүрдийг 2 дахин ихэсгэхэд 6-ийн хүрд үүсэж байна гэжээ. Охины хэлснийг тайлбарлаарай.

## ЕСӨӨР ҮРЖҮҮЛЭХ, ЕСӨД ХУВААХ

**327** Аав, хүү, охин гурав ногооны талбайд ургасан байцайг тоолох болов.



Аав хурдан тоолжээ.  
Охин удаан тоолсон.  
Хэн, хэрхэн тоолсныг ажиглаад,  
ярилцаарай.

Аав ○

6 мөрөнд 9, 9  
гэхээр зургаан  
есийн тавин  
дөрөв

6, 12, 18, 24...

○ ○ Хүү

1, 2, 3, 4... ○ ○ Охин

- Байцайны тоог хэрхэн хурдан олох вэ?
- Чи байцайны тоог хэрхэн олсноо тайлбарлаарай. Өөр хялбар арга байна уу?


**328** Цэцэрлэгч 5 мөрөнд цэцэг тарив. Мөр бүрд 9 цэцэг тарьсан. Цэцэрлэгч нийт хэдэн цэцэг тарьсан бэ?

**329** Хүү 63 мөөгийг 9, 9-өөр нь хэлхэж хатаав. Хэдэн хэлхээ мөөг хатаасан бэ?

**330** Бат есөөр үржүүлэх хүрдийг бичээд “Тоог есөөр үржүүлэхэд үржвэрийн утгын сүүлийн цифр нэгээр буурч байна” гэж хэлжээ. Батын хэлсэн үнэн эсэхийг хүснэгт гүйцээж, шалгаарай.

Үржигдэхүүн		2	3		5	6			9	10	0
Үржигдэхүүн	9			9			9	9	9	9	9
Үржвэрийн утга	9	18		36		54			81		

**331** Тоон хэлхээг гүйцээгээрэй.







**332** Барилгачин 72 тоосгоор 9 тэнцүү багана өрөв. Багана бүрд хэдэн тоосго өрсөн бэ?

**333** Нэг тоосго 2 килограмм жинтэй. 9 тоосго хэдэн килограмм болох вэ?



**334** Хүснэгт бүр хэдэн нүдтэй байна вэ? Чи хэрхэн олсноо бусадтай ярилцаарай. Өөр хялбар арга байж болох уу?



Хүснэгт бүрийг 9 тэнцүү хэсэг болгон будаарай.

**335** Ногдворуудыг зургаар илэрхийлээрэй. Ялгаа байна уу?  
 $18 \div 2$        $18 \div 9$

**336** Тохирох тоог нөхөөрэй.


× 9	
7	63
4	
	72
9	

÷ 9	
81	9
63	
	5
27	

**337** 8 ба 9-ийн үржвэрийн утга аль аравтад ойр вэ? Хуваарьтай хэрчим дээр тэмдэглээрэй.

**338** Худалдагч 9 нүдтэй тавиурт тоглоом өрөв. Тавиурын нүд бүрд 3 бамбарууш, 4 онгоц, 5 бөмбөг өрөв.

Худалдагч тоглоом бүрээс хэдийг тавиурт өрсөн бэ?  
 Худалдагч тавиурт нийт хэдэн тоглоом өрсөн бэ?



**339** Хүснэгт дэх үржүүлэхийн хүрдийг гүйцээгээрэй. 4 ба 5-ын хүрдтэй 9-ийн хүрд ямар холбоотойг ажиглан, ярилцаарай.

×	1	2	3	4	5	6	7	8	9	10
4	4	8	12		20					
5	5	10	15	20						
9	9	18								

**340** 3 ба 6, 10 ба 1-ийн хүрд ашиглан 9-ийн хүрд бүтээж, туршаарай.

## БАТАТГАЛ

**341** Дугуй дээрх тоог гүйцээгээрэй.



- Тоо тус бүр хэдэд хуваагдах вэ? Бүх тоо ижил тоонд хуваагдаж чадах уу?
- Сондгой тоонуудыг түүж бичээрэй. Нэмэх үйлдлээр 2 дахин ихэсгээрэй.
- 2-т хуваагдах тоонуудыг ялгаж бичээрэй.
- Аравтын орны цифр нь нэгжийн орноос 2 дахин бага байх тоо аль нь вэ?

**342** Бөмбөлгүүдийг 3, 3-аар багцлаарай.

Нэг багц бөмбөлгөө 1 мөрөнд байрлуулаарай.

Хэдэн мөр болсон бэ?

Бөмбөлгүүдийг 6, 9-өөр багцлаад, дээрх үйлдлийг хийгээрэй.



**343** Тоон тэнцэтгэл үнэн байхаар  $\square$  -д тохирох үйлдлийн тэмдгийг бичээрэй.

$$10 \square 5 = 15$$

$$5 \square 6 = 30$$

$$40 \square 5 = 35$$

$$42 \square 7 = 6$$

$$3 \square 3 = 9$$

$$90 \square 10 = 9$$

$$27 \square 9 = 3$$

$$81 \square 11 = 70$$

**344** Илэрхийллийг бичээд, утгыг олоорой.

- Дөрвийг 6 дахин ихэсгээд 10-аар хорогдуулах
- 3 ба 9-ийн үржвэрийг 5-аар багасгах
- 36-г 4 дахин багасгаад 100-аар ихэсгэх
- 81 ба 9-ийн ногдворыг 9-өөр нэмэгдүүлэх


**345** Хүү энэ сард 8 оньсого, түүнээс 3 дахин их зүйр үг, оньсого ба зүйр үгийн нийт тооноос 6 дахин цөөн шүлэг цээжлэв. Хүү энэ сард нийт хэдэн оньсого, зүйр үг, шүлэг цээжилсэн бэ?

**346** Хүүхдүүд гар урлалын тэмцээнд оролцох бүтээл хийв.

- Гурван хөвгүүн тус бүр 4 онгоц хийв. Нийт хэдэн онгоц хийсэн бэ?
- Зургаан хөвгүүн тус бүр 3 завь хийв. Нийт хэдэн завь хийсэн бэ?
- Есөн хөвгүүн тус бүр 2 машин хийв. Нийт хэдэн машин хийсэн бэ?
- Хөвгүүд тэмцээнд нийт хэдэн бүтээлээр оролцсон бэ?
- Охид тэмцээнд оролцсон хөвгүүдийн нийт бүтээлийн тооноос 6 дахин цөөн хатгамал хийж оролцсон. Охид хэдэн хатгамал хийж гар урлалын тэмцээнд оролцсон бэ?

**347** Бат багшаасаа: Та хэдэн настай вэ? гэтэл багш: Би 29 -өөс 40 хооронд орших 6-д хуваагддаг тоотой тэнцүү настай гэжээ. Батын багш хэдэн настай вэ?

348 Диаграммыг ашиглан бодоорой.  $\square = 6$  ширхэг жимс.



- Жимс тус бүрийн тоог олоорой.
- Жүрж алимнаас хэдээр олон бэ?
- Гадил, киви нийлээд хэд байна вэ?
- Алим, гадилын зөрөөг олоорой.
- Хамгийн их тоотой жимснээс хамгийн бага тоотой жимс хэдээр цөөн бэ?

349 Хүснэгтийн будсан нүдэн дэх тоог олоорой.

1	2	3	4	5	6	7	8	9	10
11	12	13	14	15	16	17	18	19	20

- Олсон аргаа тайлбарлаарай.
- Хэний арга хялбар байсныг ярилцаарай.
- Будагдсан бүх тооны хуваагч болох тоо байх уу?

- 350 а. Тэмцээнд оролцохоор найман баг хүрэлцэн ирэв. Баг бүр 6 тоглогчтой. Нийт хэдэн тоглогч ирсэн бэ?
- б. Нэг бүр нь 9 төгрөгийн үнэтэй дөрвөн ширхэг өнгийн цаас худалдан авав. Бас 50 төгрөгийн үнэтэй дугтуй авав. Нийт хэдэн төгрөг төлсөн бэ?
- в. Уутандаа есөн ширхгээр савласан ил захидлаас 8 уут авав. Нийт хэдэн ил захидал авсан бэ

351



**Хэсгүүдэд тэнцүү хуваая.**

**Хэрэглэгдэхүүн:** 30 ширхэг тоолох хэрэгсэл, таваг орлох 10 хайрцаг

**Заавар:** Зоогийн газар 10 тавагтай. Тогооч 30 бууз хийв.

- Буузнуудыг тэнцүү хувааж таваглаарай.



- 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9 тавагт тэнцүү хувааж таваглаж болох уу?

## ДОЛООГООР ҮРЖҮҮЛЭХ, ДОЛООД ХУВААХ

**352** Таваг бүрд 7 жигнэмэг байна. Долоон тавагт нийт хэдэн жигнэмэг байна вэ? Хүрдийг гүйцээгээрэй.

Багцын тоо	Багц дахь юмсын тоо	Нийт юмсын тоо
1	7	7
2	7	14
3	7	21
4	7	
5	7	
6	7	
	7	

**353** Зургаар илэрхийлэл зохиож, бодоорой.



**354** 70 мм урттай хэрчим зураарай. 10 мм бүрийг өөр өнгөөр будаарай. Хэдэн өнгийн харандаа хэрэглэсэн бэ?

**355** Сугар 5 ба 2-ын хүрдээ ашиглан, 7-ийн үржвэрийг хурдан олжээ. Дутуу бичиглэлийг гүйцээгээрэй.

$2 \times 2 = 4$   
 $2 \times 5 = 10$   
 $2 \times 7 = 4 + 10 = 14$

$3 \times 2 = 6$   
 $3 \times 5 = 15$   
 $3 \times 7 = \square + \square = \square$

$6 \times 2 = \square$   
 $\square \times \square = \square$   
 $\square \times \square = \square + \square = \square$

Тав ба хоёрын үржүүлэхийн хүрд ашиглан:

- Тав ба долоогийн үржвэрийн утга
- Зургаа ба долоогийн үржвэрийн утга
- Ес ба долоогийн үржвэрийн утгыг олж болох уу? Туршаарай.

356



Гуравдугаар сарын цаг тооны бичиг зохиогоорой.

- Гуравдугаар сарын 1 бямба гараг байсан бол гуравдугаар сарын 2 ямар гараг байх вэ?
- Гуравдугаар сар хэдэн хоногтой вэ?
- Сарын сүүлийн хоног ямар гарагт байна вэ?
- Энэ сард бүтэн 7 хоног хэд байна вэ?



357 Илэрхийллийн утгыг олоорой.

- а.  $3 \times 7$       б.  $7 \times 6$       в.  $8 \times 7$       г.  $7 \times 9$       д.  $4 \times 7$   
 е.  $52 + 14 \div 7$     ж.  $71 - 5 \times 7$     з.  $7 \times 4 \div 7$     и.  $72 \div 8 \times 7 + 7$

358 Дүрсийг багцалж, тэнцэтгэлийг гүйцээгээрэй.




$$\square \div 5 = 7$$

$$\square \div 7 = \square$$

359 а. Бүжгийн дугуйлангийн сурагчид 7 өдрийн турш тэмцээнд бэлтгэв. Өдөрт 3 цаг чөлөөт бүжиг, 2 цаг цэнгээнт бүжгийн бэлтгэл хийсэн. Дугуйлангийн сурагчид нийт хэдэн цагийн бэлтгэл хийсэн бэ?

б. Хүүхэд бүрд 7 дм урттай тууз хэрэгтэй. 4 хүүхэд нийт хэдэн дециметр тууз хэрэгтэй вэ?



360 Номын дэлгүүрийн худалдагч 28 номыг тавиур бүрд тэнцүү тоотойгоор өрөв. Худалдагч хэрхэн тэнцүү хувааж өрсөн байж болох вэ?

- Хамгийн багадаа хэдэн тавиурт өрсөн бэ?
- Хамгийн ихдээ хэдэн тавиурт өрсөн бэ?

361



1. Илэрхийллийн утгыг олоорой.

- $84 - 4 \times 7$     б.  $52 + 28 \div 7$     в.  $37 + 15 - 6 \times 7$     г.  $100 - 63 \div 9 - 31$
- Өнөөдөр 27-ны өдөр. Аав Архангай аймгаас 2 долоо хоногийн өмнө ирсэн. Аав хэдний өдөр Архангай аймгаас ирсэн бэ?
- 50, 60-д хоёуланд нь ойр орших 7-д хуваагдах тоог олж, тоон шулуун дээр тэмдэглээрэй.

## БАТАТГАЛ

**362** Илэрхийллийн утгыг олоорой.

а.  $40 - 24 \div 8 + 19$     б.  $56 + 14 - 4 \times 8$     в.  $6 \times 7 + 8 \times 8$ ;    г.  $7 \times 9 - 54 \div 6$

**363** 4 мөр 14 баганатай хүснэгт зураарай. Түүнийг 7 тэнцүү хэсэгт хувааж, өөр өнгөөр будаарай.

**364** Загварт байгаа жишээнд тохирох бодлого зохиогоорой.



$$\begin{array}{l} \boxed{4} \times \boxed{\phantom{00}} = \boxed{36} \qquad \boxed{42} \div \boxed{7} = \boxed{\phantom{00}} \\ \boxed{\phantom{00}} \times \boxed{4} = \boxed{36} \qquad \boxed{42} \div \boxed{\phantom{00}} = \boxed{7} \end{array}$$

**365** Бямба гарагийн 3 цагт Сэргэлэн ээжтэйгээ дэлгүүрт иржээ. Гэтэл дэлгүүр хаалттай байв. Яагаад хаалттай байсан гэж чи бодож байна вэ?



- Хэдэн цагийн өмнө ирсэн бол тэд дэлгүүрээр үйлчлүүлэх байсан бэ? Яагаад?
- Өнөөдөр дэлгүүр хэдэн цаг ажилласан бэ?
- Хэрэв өнөөдөр пүрэв гараг байсан бол тэд дэлгүүр хаахаас хэдэн цагийн өмнө ирсэн бэ?
- Дэлгүүр бямба гарагт бусад гарагаас хэдэн цагаар дутуу ажилладаг вэ?
- Дэлгүүр 7 хоногт нийт хэдэн цаг ажилладаг вэ?


**366** Дүрс дээрх тоог олж бичээрэй.



**367** Загварт тохирох жишээ зохиогоорой.

а.  $\text{yellow circle} \times \text{blue triangle} \div \text{blue triangle} = \text{yellow circle}$     б.  $\text{green square} \div \text{green square} \times \text{blue triangle} = \text{blue triangle}$     в.  $\text{yellow circle} \times \text{yellow circle} \times \text{blue triangle} = \text{blue triangle}$

- 368** Таван хүүхэд дардас шидэх тэмцээнд оролцжээ. Хэн хэдэн оноо авсныг зургаас харж, олоорой. Шар өнгөтэй хэсэг дэх тоог 4 дахин ихэсгэж, цэнхэр өнгөтэй хэсэг дэх тоог 7 дахин ихэсгэж, оноог тооцно.



**Оноо ба хожил**  
 30-аас 49 оноо: бамбарууш  
 50-аас 69 оноо: даам  
 70-аас дээш оноо: гар утас

- Хэн бамбарууш хожсон бэ?
- Хэн даам хожсон бэ?
- Хэн хамгийн их оноог авсан бэ?
- Хожил аваагүй хүүхэд байна уу?
- Хүүхдүүдийн авсан оноог ихээс багоруу эрэмбэлж, бичээрэй.

- 369** 2 дугаар ангийн сурагчдын тоог дүрсээр төлөөлүүлж үзүүлэв.

2а анги	
2б анги	
2в анги	
2г анги	

= 6    = 7    = 8    = 9

- 2 дугаар ангийн бүлэг бүр хэдэн сурагчтай вэ?
- Бүлгүүдийг сурагчдын тоогоор буурах эрэмбээр байрлуулаарай.
- 2б, 2г бүлгийн сурагчдын тооны зөрөөг олоорой.
- 2а ангиас 7 сурагч өөр сургууль руу шилжиж, 2б ангид 17 сурагч шилжиж ирсэн. 2 дугаар ангийн сурагчдын нийт тоо хэрхэн өөрчлөгдөх вэ?


**370**



**Тоонуудыг үржүүлье.**

**Хэрэглэгдэхүүн:** 1-9 хүртэлх тоонууд бүхий карт.


Тоон картуудаар үржүүлэх үйлдэлтэй илэрхийлэл үүсгээрэй.





## ХУГАЦААГ ХЭМЖИХ


**371** Хүү, охин хоёр нэгэн зэрэг гэрийн хананд байдаг цагаа харав. Ялгаа байна уу?



Дижитал цагийн заасан хугацааг аналого цагийн загвар хэрэглэн үзүүлээрэй.



**372** Дараах цагуудыг уншаад, дэвтэртээ тэмдэглээрэй.




1 цагт  
60 минут  
байдаг.



2 цаг 15 мин  
болж байна.



**373** Дараах дижитал цагуудыг уншаад, дэвтэртээ бичээрэй.



Жишээ нь: 6 цагаас 15 минут өнгөрч байна.

**374** Хүү 3 найзаасаа цаг хэд болж байгааг асуужээ. Хэн нь цагийг зөв уншсан бэ?



Цаг хэд болж  
байна вэ?

Ану: 11 цаг 25 минут болж байна.

Анар: 11 цагаас 25 минут өнгөрч байна.

Наран: 12 цагт 35 минут дутуу байна гэж хариулав.




**375** Аналоги цагийг уншаад, тохирох үйл явдалтай холбоорой. Аль цагт, ямар үйлийг хийж болох вэ?



**376** Цагийг уншаад, хоосон зайг дэвтэртээ бичээрэй.

10 цагаас ... минут өнгөрч байна.	3 цагаас ... минут өнгөрч байна.	1 цагаас ... минут өнгөрч байна.	8 цагаас ... минут өнгөрч байна.
11 цаг болоход ... минут дутуу байна.	4 цаг болоход ... минут дутуу байна.	2 цаг болоход ... минут дутуу байна.	9 цаг болоход ... минут дутуу байна.

**377** Хэдэн цаг болж байгааг бичээрэй.



Жишээ нь: 2 цагт 20 минут дутуу. Эсвэл 1 цагаас 40 минут өнгөрч байна.

**378** Дижитал цагуудыг уншаад, 30 минутын дараа хэдэн цаг болохыг дэвтэртээ бичээрэй.

3:15
4:30
2:00
9:25
12:45
1:55

**379** Охин ээжтэйгээ дэлгүүрт 10 цаг 25 минутад ороод, 10 цаг 45 минутад гарч ирэв. Хэдий хугацаанд дэлгүүрт байсан бэ?



Хариу:  минутын турш дэлгүүрт байсан.

**380** Хэдэн минут үргэлжилж байна вэ?

**381** Хүү цагт даалгавраа хийж эхлэв. Тэр даалгавраа 30 минутын хугацаанд хийсэн бол хэдэн цагт дууссан бэ?

**382** Охин 4 цаг 25 минутад гэрээсээ гарав. Гэр, сургуулийн хооронд 20 минут алхдаг бол сургууль дээрээ хэдэн цагт очих вэ?

**383** Цаг тооны бичигтэй ажиллая.

2014 оны 12 дугаар сар						
Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня
1	2	3	4	5	6	7
8	9	10	11	12	13	14
15	16	17	18	19	20	21
22	23	24	25	26	27	28
29	30	31				



Цаг тооны бичгийг заримдаа хуанли гэж ярьдаг.

- 2014 оны 12 дугаар сард даваа гараг 5 удаа болжээ. Бямба гараг хэдэн удаа тохиосон бэ?
- 12 дугаар сард хэдэн амралтын өдөр байна вэ?
- Танай ангийн сурагчдаас 12 дугаар сард төрсөн хэдэн сурагч байна вэ?
- Тэдний төрсөн өдөр ямар гарагт болж байна вэ?
- Өнгөөр ялган тэмдэглэсэн өдрийн талаар ярилцаарай

**384**



### Өдрийг олъё.

#### Хэрэглэгдэхүүн:

12 дугаар сарын цаг тооны бичиг, карт

Гарагууд:	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням
Долоо хоног:	Нэгдүгээр 7 хоног	Хоёрдугаар 7 хоног	Гуравдугаар 7 хоног	Дөрөвдүгээр 7 хоног			

#### Заавар:

- Багшийн ширээн дээр байгаа 2 хайрцгаас нэг, нэг карт сугалж, найзууддаа харуулна.
- Ангийн сурагчид цаг тооны бичгээ ашиглан, хэдний өдөр болохыг таана.



Пүрэв  
Гуравдугаар 7 хоног

16? 17? 18?  
аль нь вэ?



12 дугаар сарын гуравдугаар долоо хоногийн пүрэв гараг 18-ны өдөр байна.

**385** Улаанбаатараас өглөө 8 цагт гарсан зорчигч тээврийн автобус Дорнод аймагт орой 22 цагт хүрэв. Хэдэн цагийн турш явсныг тооцоолоорой.

**386** Саран гэрээсээ автобусны буудал явахдаа 15 минут зарцуулна. 9 цаг 10 минутад ирэх автобусанд амжиж суухын тулд хэдэн цагт гэрээсээ гарах вэ?

**387** Өнгөөр ялган тэмдэглэсэн өдрүүдэд ямар үйл болдог вэ? Багштайгаа хамтран ярилцаарай.

2015 оны 3 дугаар сар						
Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня
						1
2	3	4	5	6	7	8
9	10	11	12	13	14	15
16	17	18	19	20	21	22
23	24	25	26	27	28	29
30	31					

а. Танай ангийн сурагчдаас 3 дугаар сард төрсөн сурагч хэд байна вэ? Цаг тооны бичгийг дэвтэртээ зураад, тэмдэглээрэй.

б. Гуравдугаар сард нийт хэдэн амралтын өдөр байна вэ? Ажлын өдөр, амралтын өдрөөс хэдээр олон байна вэ?

**388** Цагийн хуваарьтай ажиллая. Тамир, Уянга нарын өдрийн дэглэмийг харуулжээ.



08:00-08:40	Өглөөний дасгал
08:40-09:10	Өглөөний цай
09:10-12:45	Хичээлдээ явах
12:45-01:10	Найзуудтайгаа тоглох
01:10-03:00	Дугуйланд явах
03:00-04:20	Дүүгээ асрах
04:20-06:00	Гэрээ цэвэрлэх
06:00-07:45	Гэрийн даалгавраа хийх
07:45-08:00	Амрах

08:30-08:45	Өглөөний дасгал
08:45-09:10	Өглөөний цай
09:10-12:45	Хичээлдээ явах
12:45-02:00	Дугуйланд явах
02:00-03:00	Гэрээ цэвэрлэх
03:00-04:00	Дүүгээ асрах
04:00-05:30	Гэрийн даалгавраа хийх
05:30-07:00	Найзуудтайгаа тоглох
07:00-08:30	Амрах



- Тамир, Уянга хоёрын хэн нь хичээлдээ их цаг суусан бэ?
- 2 найзын хэн нь богино хугацаанд гэрийн даалгавраа хийсэн бэ?
- 2 найзын цагийн хуваарийг ашиглан, бодлого зохиож бодоорой.

**389** Өөрийнхөө нэг өдрийн цагийн хуваарийг зохиогоорой. Өдрийн хэдэн цагийг ч хичээл хийхэд зарцуулж байна вэ?

**390** 2в ангийн хичээлийн хуваарьтай танилцъя.

Гараг	Хичээлүүд			
Даваа	Монгол хэл	Биеийн тамир	Дүрслэх урлаг	Математик
Мягмар	Иргэний боловсрол	Математик	Монгол хэл	Хүн орчин
Лхагва	Математик	Хүн орчин	Монгол хэл	Хөгжим
Пүрэв	Биеийн тамир	Монгол хэл	Хөгжим	Математик
Баасан	Математик	Дүрслэх урлаг	Монгол хэл	Иргэний боловсрол

- 2в ангид нийт хэдэн хичээл ордог вэ?
- Өдөр бүр ордог ямар, ямар хичээл байна вэ?
- Даваа болон баасан гарагт давхцан ордог хичээлүүд байна уу? Нэрлээрэй.
- Ангийнхаа хичээлийн хуваарийг дээрх хуваарьтай харьцуулж, ярилцаарай.
- Чи хичээлийн хуваариа хэрхэн зохиох байсан бэ?

**391** Хүү цагаа харахад 9 цаг 15 минут болж байв. Тэр 20 минутын дараа гэрээсээ гарах ёстой. Хүү хэдэн цагт гэрээсээ гарах вэ? 10 цагт эхлэх номын нээлтэд очих тул түүнд хэдэн минут үлдсэн байна вэ?

**392** Телевизийн нэг өдрийн хөтөлбөрийг хүснэгтээр харуулав.

Нэвтрүүлэг	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа
Хүүхэлдэйн кино-1	10:35	11:00
“Би чадна” нэвтрүүлэг	11:00	12:10
Хөл бөмбөгийн хичээл	12:10	12:50
“Шинэ дуугаа сураарай” нэвтрүүлэг	12:50	01:05
Хүүхэлдэйн кино-2	01:05	01:30

- а. Хүүхэлдэйн кино хэдэн минут үргэлжилсэн бэ?
- б. Хамгийн богино хугацаанд үргэлжилсэн нэвтрүүлэг аль нь вэ?
- в. Хүснэгт дэх нэвтрүүлэг нийт хэдэн цаг үргэлжлэх вэ?

**393**




Санасан гарагийг хэрхэн олох вэ?

- а. Долоо хоногийн аль нэг гарагийн дугаарыг сана. *Жишээ нь: Пүрэв гараг-4 гэх мэт*
- б. Түүнийг 5-аар үржүүлж гарсан тоон дээр 9-ийг нэмээд, 8-ыг хас. Гарсан дүнг хэлээрэй.
- в. Энэ дүнгээр гарагийн дугаарыг хэрхэн олох вэ?



## МЯНГА ХҮРТЭЛХ ТООГ ТАНИХ

### МЯНГА ХҮРТЭЛХ ТООГ УНШИХ, БИЧИХ




**394** Охин цуглуулсан мөнгөө тоолжээ. Түүнд хэдэн төгрөг байна вэ?

1 төгрөгийг  -ээр төлөөлүүлж, мөнгөний тоог орон ангийн хүснэгтэд дүрсэлье.



10 ширхэг  нийлээд  1 аравт

10 ширхэг  нийлээд  1 зуут.

Зуут (з)	Аравт (а)	Нэгж (н)
		

$$\begin{aligned} 10 \text{ н} &= 1 \text{ а} \\ 10 \text{ а} &= 1 \text{ з} \\ 10 \text{ з} &= 1 \text{ мян} \end{aligned}$$

Зуут (з)	Аравт (а)	Нэгж (н)
4	3	8
↓	↓	↓
400	30	8




$438 = 4 \text{ зуут } 3 \text{ аравт } 8 \text{ нэгж}$   
 $438 = 400 + 30 + 8 \text{ орны нэмэгдэхүүний нийлбэр}$

Дөрвөн зуун гучин найм




**395** Орны утгын карт хэрэглэн 438-ыг бүтээе. Бүтээсэн тоонуудаа:



- Цифрүүдийн байрлах орон, утгыг бичээрэй.
- Орны нэмэгдэхүүний нийлбэрээр задлан бичээрэй.
- Үгээр бичээрэй.

Орны утгын карт хэрэглэн 438 гэсэн тоо хэдэн аравт, зуутыг агуулж байна вэ?




**396** Тоонуудыг орны нэмэгдэхүүний нийлбэрт задлан бичээрэй.  
 234, 503, 729, 561, 835, 620, 422

**397** Зургийг ажиглаад, ярилцаарай. Охинд нийт хэдэн шоо байна вэ?




**398** а. Өгсөн тооноос эхлэн нэгээр нэмэгдүүлэн тоолоорой.



353, 354, 355, ..... 361 хүртэл.

б. Өгсөн тооноос эхлэн нэгээр хорогдуулан тоолоорой.



247, 246, 245, ..... 239 хүртэл.

**399** Даалгаврыг гүйцэтгээрэй.

а. 123-аас 193 хүртэл арваар нэмэгдүүлэн тоолоорой.

$$\begin{array}{ccccccc}
 123 & 133 & 143 & \dots & 193 \\
 \curvearrowright & \curvearrowright & & & \\
 +10 & +10 & & & 
 \end{array}$$

в. 217-оос 817 хүртэл зуугаар нэмэгдүүлэн тоолоорой.

$$\begin{array}{ccccccc}
 217 & 317 & 417 & \dots & 817 \\
 \curvearrowright & \curvearrowright & & & \\
 +100 & +100 & & & 
 \end{array}$$

б. 399-өөс 319 хүртэл арваар хорогдуулан тоолоорой.

$$\begin{array}{ccccccc}
 399 & 389 & 379 & \dots & 319 \\
 \curvearrowleft & \curvearrowleft & & & \\
 -10 & -10 & & & 
 \end{array}$$

г. 956-аас 156 хүртэл зуугаар хорогдуулан тоолоорой.

$$\begin{array}{ccccccc}
 956 & 856 & 756 & \dots & 156 \\
 \curvearrowleft & \curvearrowleft & & & \\
 -100 & -100 & & & 
 \end{array}$$

**400**



Нуусан тоог олоорой. Хосоороо ажиллана. Нэг нь хүснэгтийн зарим тоон дээр цаас тавин нууж, нөгөө нь нуусан тоог хэлнэ.

81	82	83	84	85	86	87	88	89	90
91	92	93	94	95				99	100
101	102	103	104	105		107		109	110
111	112	113	114	115				119	120
			124	125	126	127	128	129	130
	132		134	135	136	137	138	139	140
			144	145	146	147	148	149	150
151	152	153	154	155	156				160
161	162	163	164	165	166		168		170
171	172	173	174	175	176				180

**401** Мөнгөн дэвсгэртүүдийг дүрсээр төлөөлүүлж, 2 дахь хүснэгтийг гүйцээгээрэй.



	300₮		500₮
	50₮		30₮
	4₮		2₮

**402** Хүснэгтийг ажиглаад мөр, баганын огтлолцолд үүссэн тоог хүснэгтэд бичээрэй. Жишээ нь: 2 з 5 н = 205, 9 з 1 а 7 н = 917

	2 а	3 а	5 н	6 н	8 а
2 з			205		
	420			406	
5 з		530			
	920				

	1 н	2 н	4 н	7 н	8 н
1 з		102			108
			584		
9 з 1 а				917	
	641				648


**403** Хүснэгтийг гүйцээж бичээрэй.

Зуут	Аравт	Нэгж	Бичих	Унших
1	2	7	127	Нэг зуун хорин долоо
3	0	8		Гурван зуун найм
			496	
				Найман зуун арван гурав

**404** Тоон картуудыг ашиглан:  
 а. Бүх цифр нь тэгш 3 оронтой тоо зохиогоорой.  
 б. Нэгжийн орон нь 6 байх 2 оронтой тоо зохиогоорой.  
 в. 70-аас их 2 оронтой тоо зохиогоорой.



**405** Өгсөн картуудаар боломжтой бүх 3 оронтой тоо зохиогоорой. Зохиосон тоонуудаа орны нэмэгдэхүүний нийлбэрээр бичээрэй. Тоонуудаас 1, 10, 100-аар их, бага тоог олоорой.





## 1000 ХҮРТЭЛХ ТООГ ЖИШИХ, ЭРЭМБЭЛЭХ

406



Сургууль 1 дүгээр ангийн 158, 2 дугаар ангийн 152 сурагчтай. Хэддүгээр анги нь их сурагчтай байна вэ?


Зуут (з)	Аравт (а)	Нэгж (н)

$1 = 1$

$5 = 5$

$8 > 2$  тул  $158 > 152$  байна.

- а. Орны тоог харна. Олон оронтой тоо нь их байна.
- б. Зуутын орны утгыг жишнэ. Зуутын орны их утгатай тоо нь их байна.
- в. Зуутын орны утгууд тэнцүү байвал аравтын орны утгыг жишнэ. Аравтын орны их утгатай тоо нь их байна.
- г. Аравтын орны утга нь тэнцүү байвал нэгжийн орны утгыг жишнэ. Нэгжийн орны их утгатай тоо нь их байна.



Тоон шулуун дээр 158 нь 152-ын баруун гар талд байрлаж байна. Тоон шулуун дээрх хоёр тооны баруун гар талд байрлах тоо нь их, зүүн гар талд байрлах тоо нь бага байна. Иймд  $158 > 152$  байна.



407 Дээрх тоон шулууныг ашиглан өгсөн тоонуудыг жишээрэй.

а. 101 ба 120

б. 130 ба 133

в. 172 ба 170

г. 149 ба 140

д. 153 ба 143

е. 180 ба 178

408 Жишээрэй.

а. 121 ... 13

б. 256 ... 310

в. 419 ... 297

г. 709 ... 714

д. 520 ... 532

е. 342 ... 345

409 Өгсөн тоонуудын хооронд орших зуутуудыг олоорой.

а. 168 ба 561

б. 657 ба 901

в. 230 ба 735

г. 241 ба 812


410 Тоонуудыг жишээрэй.


- а. 248 ба 271    б. 459 ба 419    в. 920 ба 902    г. 712 ба 812  
д. 517 ба 437    е. 154 ба 171    ж. 452 ба 552    з. 703 ба 730

411



Хэн нь хол зам аялсан бэ?

25 дм ,      20 дм 



412 Өгүүлбэрүүд үнэн эсэхийг ярилцаарай.

- а. 10 см нь 1 дм-ээс урт.  
б. 7 дм нь 2 м-ээс богино.  
в. 10 см нь 42 мм-ээс богино.

413 Эхний хайрцагт 3 килограммаар савласан 8 уут алим, хоёр дахь хайрцагт 4 килограммаар савласан 6 уут жүрж байв. Хоёр хайрцгийн аль нь хүнд болохыг тооцоолоорой.

414 3-ын цифрийг 84 гэсэн хоёр оронтой тооны баруун гар талд болон зүүн гар талд тус, тус байрлуулаарай. Үүсэх гурван оронтой тоонуудыг жишээрэй.

415 1 алим 5 чавгатай тэнцүү жинтэй бол

- а. 2 алим хэчнээн чавганы жинтэй тэнцэх вэ?  
б. 2 алим 1 чавга хэчнээн чавганы жинтэй тэнцэх вэ?  
в. 3 алим 4 чавга хэчнээн чавганы жинтэй тэнцэх вэ?



416



а. Нэг бамбаруушийн байрлалыг сольж гурван оронтой тоо үүсгэнэ.

- Хамгийн их тоо үүсгэхийн тулд аль бамбаруушийн байрлалыг солих хэрэгтэй вэ?
  - Хамгийн бага тоо үүсгэхийн тулд аль бамбаруушийн байрлалыг солих хэрэгтэй вэ?
- б. Тэдний байрлалыг өөрчлөн 3 оронтой тоо хэдийг зохиож болох вэ?

## 1000 ХҮРТЭЛХ ТООГ ТОЙМЛОХ

417


Зургийн уралдаанд оролцсон сурагчдын тоо:  
Нэгдүгээр анги: 152 сурагч  
Хоёрдугаар анги: 274 сурагч

Сурагчдын тоог аравт, зуутаар тоймлоорой.




Хоёрдугаар ангийн сурагчдын тоог аравт, зуутаар хамтдаа тоймлоё.

1. 274-ийг аравтаар тоймлоё. 274 нь 270 ба 280-ын алинд ойр вэ?



274 нь 270-д илүү ойр. Иймд 274-ийг аравтаар тоймлоход 270 болно.

2. 274-ийг зуутаар тоймлоё. 274 нь 200 ба 300-ийн алинд ойр вэ?



274 нь 300-д илүү ойр. Иймд 274-ийг зуутаар тоймлоход 300 болно.

418

131, 132, 133, 134, 135, 136, 137, 138, 139 тоонуудыг аравтаар тоймлоорой.

Ямар тоонуудыг аравтаар тоймлоход 130 гарсан бэ?

Ямар тоонуудыг аравтаар тоймлоход 140 гарсан бэ? Ялгаж бичээрэй.

Тоонуудын нэгжийн орны цифрийг ажиглаарай. Ямар дүгнэлт хэлж болох вэ?

Ямар тоог тоймлоход хэцүү байсан бэ? Яагаад?



Дээрх тоонуудын нэгжийн орны цифр 1, 2, 3, 4-ийн аль нэг тул аравтын орны нэгж хэвээр 130 байна.

Дээрх тоонуудын нэгжийн орны цифр 5, 6, 7, 8, 9-ийн аль нэг тул аравтын орны нэгж 1-ээр нэмэгдэж 140 болсон.



419

105, 116, 127, 131, 146, 151, 168, 179, 184, 196 тоонуудыг зуутаар тоймлоорой.

Ямар тоонуудыг зуутаар тоймлоход 100 гарсан бэ?

Ямар тоонуудыг зуутаар тоймлоход 200 гарсан бэ? Ялгаж бичээрэй.

Тоонуудын аравтын орны цифрийг ажиглаарай. Ямар дүгнэлт хэлж болох вэ?



Тоог түүнд хамгийн ойр байх аравтаар, зуутаар сольж бичихийг тоог аравтаар, зуутаар тоймлож байна гэдэг.

Тоймлох орны доод орны нэгж 5, 6, 7, 8, 9-ийн аль нэг бол тоймлох орны нэгж 1-ээр нэмэгдэж байна.



- 420** а. 18, 73, 85, 62 тоонууд аль аравтад ойр байна вэ?  
б. 283, 452, 761, 183 тоонууд аль зуутадад ойр байна вэ?

**421** Тоонуудыг аравт, зуутаар тоймлоорой.

а. 618,                      453,                      719,                      862,  
б. 555,                      802,                      329,                      895,

- 422** Хоёр хотын хооронд 95 километр зайтай. Жуулчид энэ замаар дугуйгаар 37 километр, машинаар 49 километр явав. Жуулчид очих газраа хүрч чадсан уу? Хэрвээ үгүй бол тэд хаана байрлаж байгааг хэрчим дээр барагцаалан тэмдэглээрэй.




- 423** 157, 385, 261, 408, 320 тоонууд өгөв.

- а. Дээрх тоонуудыг үгээр бичээрэй.  
б. Тоонуудыг ихээс бага руу буурах эрэмбээр бичээрэй.  
в. Аль тоог аравтаар тоймловол 260 гарах вэ?  
г. Улаан өнгөөр бичсэн цифр ямар оронд байна вэ?  
Ямар утгыг илэрхийлэх вэ?  
д. Аравтын орон нь 5 байх тоог нэрлээрэй.  
е. Нэгжийн орон нь 0 байх тоог нэрлээрэй.

- 424** Хуваарьтай хэрчим дээр тоонуудыг цэгээр тэмдэглээрэй.

410, 730, 570, 815, 235, 680, 750



**425**



### Тоог тоймлоё



Би зуутын  
орон

Би аравтын  
орон



Би нэгжийн  
орон



**Хэрэглэгдэхүүн:** 1-9 хүртэл дугаарлагдсан тоон карт

Гурван тоглогч нэгэн зэрэг тоон картаас сугална.

Нэгж: Өөрийн сугалсан картуудыг дээш өргөн харуулна.

Аравт: Өөрийн сугалсан картыг харуулахгүйгээр хоёр оронтой тоо үүсгээд тоймлож хэлнэ.

Нэгж: Аравтын сугалсан тоог тааж хэлнэ.

Зуут: Өөрийн сугалсан картыг харуулахгүйгээр гурван оронтой тоо үүсгээд тоймлож хэлнэ.

Аравт: Зуутын сугалсан тоог тааж хэлнэ.

426 □ -д тохирох тоог бичээрэй.

а. 87, 88, □, □, 91, 92, □

б. □, 148, 149, □, □

в. □, 401, 402, □

г. □, 153, 152, □, □

427 а. Тоонуудыг багаас их рүү жагсаан бичээрэй.

17, 2, 18, 9, 34, 45, 1, 29

б. Тоонуудыг ихээс бага руу жагсаан бичээрэй.


102, 12, 207, 243, 780, 18, 27, 300

428 Зургийг ажиглаад, тохирох тоог олоорой. Ижил дүрс нь ижил тоо байна.

а.



б.



429



### Тоог жишье

**Хэрэглэгдэхүүн:** 3 өнгийн шоо, дүгнэх хуудас

#### Заавар:

а. Хоёр тоглогч ээлжээр 3 шоог зэрэг орхино.

б. Буусан нүдний тоогоор боломжит хамгийн их 3 оронтой тоог үүсгэж, хүснэгтэд бичнэ.

в. Үүссэн 3 оронтой 2 тоогоо жишнэ.

д. Их тоо үүсгэсэн тоглогч 1 оноо авна. Хамгийн их оноо авсан сурагч хожно.

	1	2	3	4	Ялагч
1 дүгээр тоглогч					
2 дугаар тоглогч					
Оноо					

430



Тоон картуудыг ашиглан загварт тохирох тоог олоорой.

0 1 2 3 4 5 6 7 8 9

$$\begin{array}{r} \square \square \square \\ + \square \square \square \\ \hline \square \square \square \end{array}$$

$$\begin{array}{r} \square \square \square \\ + \square \square \square \\ \hline \square \square \square \end{array}$$

$$\begin{array}{r} \square \square \square \\ + \square \square \square \\ \hline \square \square \square \end{array}$$


$$\begin{array}{r} \square \square \square \\ - \square \square \square \\ \hline \square \square \square \end{array}$$


$$\begin{array}{r} \square \square \square \\ - \square \square \square \\ \hline \square \square \square \end{array}$$


$$\begin{array}{r} \square \square \square \\ - \square \square \square \\ \hline \square \square \square \end{array}$$


## 1000 ДОТОР НЭМЭХ, ХАСАХ

- 431** Эгч дүү хоёр хамтарч мөнгөн хадгаламжтай болохоор шийдэв. Эхний удаа эгч 700, дүү 200 төгрөг хадгаламждаа хийв.  
а. Тэд нийт хэдэн төгрөгтэй болсон бэ?

Эгчийн мөнгө  ?

Дүүгийн мөнгө  ?

Эгчийн мөнгө  ?

Дүүгийн мөнгө  ?

илэрхийлэл  $700 + 200$


Нийлбэрийн утгыг яаж олох вэ?





$$7 \text{ зуу} + 2 \text{ зуу} = \square \text{ зуу}$$


$$700 + 200 = \square$$

- б. Эгч нь дүүгээс хэдээр илүү төгрөг хадгаламждаа хийсэн бэ?

Эгчийн мөнгө  ?

Дүүгийн мөнгө  ?

Эгчийн мөнгө  ?

Дүүгийн мөнгө  ?

илэрхийлэл  $700 - 200$

Хүүхдүүдийн мөнгөний зөрөөг олохын тулд ялгаврын утгыг олно.



$$7 \text{ зуу} - 2 \text{ зуу} = \square \text{ зуу}$$

$$700 - 200 = \square$$

- 432** Тооцоолоорой

а.  $2 + 3$

$20 + 30$

$200 + 300$

б.  $5 + 3$

$50 + 30$

$500 + 300$

в.  $8 - 3$

$80 - 30$

$800 - 300$

г.  $9 - 4$

$90 - 40$

$900 - 400$

433




Тулга 800 төгрөгийн үнэтэй ном худалдан авахын тулд өөрт байсан 200 төгрөгөө хадгалав. Тэр өдөр бүр 100 төгрөг нэмж хадгална гэвэл 5 хоногийн дараа номоо худалдан авч чадах уу?

434

Орхисон тоонуудыг гүйцээж бичээрэй.



435



Чихэр, зайрмаг тус бүр нэгийг авахад хэдэн төгрөг төлөх вэ?

илэрхийлэл  $240 + 730$



Шоколад хэдэн төгрөгөөр хямдарсан бэ?

илэрхийлэл  $980 - 550$



Тоонуудыг орны нэмэгдэхүүний нийлбэрт задалж бодвол:

$200 + 40 + 700 + 30 = 900 + 70 = \square$

$980 - 500 - 50 = 480 - 50 = \square$

Тоонуудыг орон ангийн хүснэгтэд байрлуулбал:

	Зуут (з)	Аравт (а)	Нэгж (н)
+	2	4	0
	7	3	0
	↓	↓	↓
	$2з + 7з$	$4а + 3а$	$0н + 0н$

Хариу:  $\square$  төгрөг төлнө.

	Зуут (з)	Аравт (а)	Нэгж (н)
-	9	8	0
	5	5	0
	↓	↓	↓
	$9з - 5з$	$8а - 5а$	$0н - 0н$

Хариу:  $\square$  төгрөгөөр хямдарсан.

436

Үйлдлийг гүйцэтгээрэй.

а.  $250 + 230$

б.  $710 + 120$

в.  $480 + 510$

г.  $350 + 610$

д.  $110 + 370$

е.  $230 + 370$

ж.  $840 + 150$

з.  $760 + 220$

437

Үйлдлийг гүйцэтгээрэй.

а.  $750 - 230$

б.  $710 - 130$

в.  $480 - 310$

г.  $950 - 610$

д.  $670 - 370$

е.  $830 - 370$

ж.  $840 - 450$

з.  $760 - 250$

**438** Бодолтыг ажиглаад ярилцаарай.

$$36 + 10 = 46; \quad (30 + 6) + 10 = (30 + 10) + 6 = 40 + 6 = 46$$

$$36 - 10 = 26; \quad (30 + 6) - 10 = (30 - 10) + 6 = 20 + 6 = 26$$

$$536 + 100 = 636; \quad (500 + 30 + 6) + 100 = (500 + 100) + 30 + 6 = 600 + 30 + 6 = 636$$

$$536 - 100 = 436; \quad (500 + 30 + 6) - 100 = (500 - 100) + 30 + 6 = 400 + 30 + 6 = 436$$



Тоон дээр 10-ыг нэмэхэд (хасахад) аравтын орон нь 1 нэгжээр нэмэгддэг (хасагддаг) юм байна.

Харин 100-г нэмэхэд (хасахад) зуутын орон нь 1 нэгжээр нэмэгддэг (хасагддаг) гэж ойлголоо.



**439** Үйлдлийг гүйцэтгээрэй.

а.  $41 + 10$

б.  $41 - 10$

в.  $627 + 10$

г.  $627 - 10$

$41 + 20$

$41 - 20$

$627 + 20$

$627 - 20$

$41 + 30$

$41 - 30$

$627 + 30$

$627 - 30$

**440** Самбарт хэн зөв бодсон байна вэ?  
Хэн ямар алдаа гаргасан бэ?

$$375 + 200 = ?$$

Амар:  $375 + 200 = 395$

Хулан:  $375 + 200 = 575$

Тулга:  $375 + 200 = 595$

**441** Цээжээр бодоорой.

а.  $142 + 100$

б.  $243 - 100$

в.  $328 + 200$

г.  $510 - 200$

д.  $385 + 400$

е.  $504 - 400$

ж.  $163 + 300$

з.  $274 - 100$

**442**



Барааны үнэ тус бүрийг ажиглаад, асуултад хариулаарай.

- Бараа тус бүрийг худалдан авахын тулд хэдэн зуун төгрөг хэрэгтэй вэ?
- Бараа тус бүрийг худалдан авахын тулд хэдэн арван төгрөг хэрэгтэй вэ?
- Бараа тус бүрийг худалдан авахын тулд хэдэн нэг төгрөг хэрэгтэй вэ?
- Барааны үнийн аравтын орны цифрийг 5-аар солиход бараа тус бүрийн үнэ хэдэн төгрөгөөр өөрчлөгдөх вэ?
- Барааны үнийн зуутын орны цифрийг 4-өөр солиход бараа тус бүрийн үнэ хэдэн төгрөгөөр өөрчлөгдөх вэ?

730₮



850₮



570₮



200₮




960₮







- 443** Сурагчид голын эргийн дагуух цэвэрлэгээнд оролцов. Үдээс өмнө 67 ширхэг, үдээс хойш 52 ширхэг хуванцар сав түүв. Нийт хэдэн ширхэг хуванцар сав түүсэн бэ?



илэрхийлэл

$$67+52$$

Нийлбэрийн утгыг олох юм байна.



$$\begin{array}{r} 67 \dots 60 + 7 \\ 52 \dots 50 + 2 \end{array}$$

$$67 + 52 = 119$$

110 ба 9 нийлээд 119



		6	7
+		5	2
			9

1. Нэгж дээр нэгжийг нэмнэ.  
 $7 \text{ н} + 2 \text{ н} = 9 \text{ н}$

		6	7
+		5	2
	1	1	9

2. Аравт дээр аравтыг нэмнэ.  
 $6 \text{ а} + 5 \text{ а} = 11 \text{ а}$   
 $11 \text{ а} = 1 \text{ з} 1 \text{ а}$

Хариу: 1 з 1 а 9 н нийлээд 119

- 444** Нэмэх үйлдлийг гүйцэтгээрэй.

а.  $59 + 42$

б.  $86 + 53$

в.  $56 + 48$

г.  $95 + 35$

д.  $76 + 65$

е.  $68 + 49$

ж.  $84 + 37$

з.  $74 + 41$

- 445** Илэрхийллийг бичээд, утгыг олоорой.


а. 65-ыг 4 ба 7-ийн үржвэрээр нэмэгдүүлэх

б. 57-г 48 ба 8-ийн ногдвороор нэмэгдүүлэх

в. 4 ба 8-ын үржвэрийг 93-аар нэмэгдүүлэх

- 446** Жуулчид хоёр өдрийн турш аялжээ. Эхний өдөр 75 километр, дараагийн өдөр 58 километр зам туулсан бол жуулчид нийт хэдэн километр зам аялсан бэ?

- 447** Хоёрдугаар ангийн сурагчид 125 ширхэг, нэгдүгээр ангийн сурагчид 57 ширхэг хуванцар сав цуглуулав. Хоёрдугаар ангийн сурагчид нэгдүгээр ангийнхнаас хэдээр олон хуванцар сав цуглуулсан бэ?



$$125 - 57 = 68$$



$$\begin{array}{r} 125 \dots 110 + 15 \\ 57 \dots 50 + 7 \\ \hline 60 \text{ ба } 8 \text{ нийлээд } 68 \end{array}$$

Эхлээд нэгжүүдээ хасна: 5-аас 7-г хасаж болохгүй. Иймд 1 аравтаар бутаргая.

$$1 \text{ а } 5 \text{ н} = 15 \text{ н}, \\ 15 \text{ н} - 7 \text{ н} = 8 \text{ н}$$

	1	2	5
-		5	7
			8

Аравтуудаа хасна:

1 аравт үлдсэн.

1 аравтаас 5 аравтыг хасаж болохгүй. Иймд 1 зуутаа бутаргая.

$$1 \text{ з } 1 \text{ а} = 11 \text{ а} \\ 11 \text{ а} - 5 \text{ а} = 6 \text{ а}$$

	1	2	5
-		5	7
		6	8

Хариу: 6 а 8 н нийлээд 68

- 448** Хасах үйлдлийг гүйцэтгээрэй.

а.  $132 - 41$

б.  $117 - 59$

в.  $142 - 67$

г.  $124 - 36$

д.  $156 - 74$

е.  $163 - 83$

ж.  $120 - 54$





з.  $144 - 68$

- 449** а. 196-аас 56 хүртэл арваар хорогдуулан тоолоорой.

б. 34-өөс 164 хүртэл арваар нэмэгдүүлэн тоолоорой.

в. 187-оос 97 хүртэл арваар хорогдуулан тоолоорой.

- 450** Нийлбэр нь 100 байх аравтуудыг гурвалжны орой дээр байрлуулаарай.



- 451** Хашаанд 113 бог мал байв. Тэдгээрийн 48 нь ямаа бол хашаанд хэдэн хонь байсан бэ?

452 Хулан 975 төгрөгтэй, Маргад 895 төгрөгтэй.



Хулан, Маргадын сонгосон зүйлийг хүснэгтэд үзүүлэв.  
Тэд хүнсний дэлгүүрээс сонгосон зүйлээ худалдан авч чадах уу?

а.	Зайрмаг	Чихэр	Бохь	Нийт үнэ
Хулан				?
Маргад				?

Хулан:  $300 + 400 + 150 = 3 з + 4 з + 1 з 5 а = 8 з 5 а = 800 + 50 = 850$

Маргад:  $500 + 200 + 90 = 5 з + 2 з + 9 а = 7 з 9 а = 700 + 90 = 790$

б. Хэрвээ Маргад сонгосон бол хэдэн төгрөгөөр худалдаж авахыг тооцоолъё.

Зуут (з)	Аравт (а)	Нэгж (н)

+	5	3	5
	1	4	0
			5

1. Нэгж дээр нэгжийг нэмнэ.  
 $5 н + 0 н = 5 н$

+	5	3	5
	1	4	0
		7	5

2. Аравт дээр аравтыг нэмнэ.  
 $3 а + 4 а = 7 а$

+	5	3	5
	1	4	0
	6	7	5

3. Зуут дээр зуутыг нэмнэ.  
 $5 з + 1 з = 6 з$

в. Хулан хамгийн хямд 3 өөр бүтээгдэхүүнээс нь сонговол түүнд хэдэн төгрөг үлдэх вэ?

Зайрмаг: 300 төгрөг, чихэр: 200 төгрөг, бохь 60 төгрөг байна.

$300 + 200 + 60 = 560$ ₮ . Үлдсэн мөнгөний хэмжээг олъё.  $975 - 560 = ?$

Зуут (з)	Аравт (а)	Нэгж (н)

-	9	7	5
	5	6	0
			5

1. Нэгжээс нэгжийг хасна  
 $5н + 0н = 5н$

-	9	7	5
	5	6	0
		1	5

2. Аравтаас аравтыг хасна  
 $7а + 6а = 1а$

-	9	7	5
	5	6	0
	4	1	5

3. Зуутаас зуутыг хасна  
 $9з + 5з = 4з$

г. Маргад



худалдан авбал түүнд хэдэн төгрөг үлдэх вэ?

**453** Илэрхийллийн утгыг олоорой.

а.  $372 + 120$

б.  $426 + 230$

в.  $513 + 160$

г.  $205 + 560$

д.  $714 + 35$

е.  $428 + 51$

ж.  $653 + 245$

з.  $426 + 312$

**454** Илэрхийллийн утгыг олоорой.

а.  $468 - 140$

б.  $719 - 610$

в.  $846 - 510$

г.  $790 - 280$

д.  $894 - 32$

е.  $547 - 44$

ж.  $729 - 316$

з.  $477 - 153$

**455** Илэрхийллийг бичээд, утгыг олоорой.

а. 216 ба 361-ийн нийлбэрийг 200-аар нэмэгдүүлэх

б. 527 ба 452-ын нийлбэрийг 350-аар хорогдуулах

в. 846 ба 514-ийн ялгаврыг 217-оор нэмэгдүүлэх

г. 675 ба 243-ын ялгаврыг 421-ээр багасгах

**456** Тус бүрд нь 121 ширхэг цэг тэмдэглэсэн 4 цаас бэлтгэв. Цаас тус бүрээс 10 цэгийг нь арилгасан. Тэгвэл 4 ширхэг цаасан дээр нийт хэдэн цэг үлдэх вэ?

**457** Илэрхийлэлд тохирох бодлого зохиогоорой.


а.  $400 + 231 - 510$

б.  $314 + 120 + 461$


в.  $647 - 321 + 453$

**458** Солонго 10 см урт туузтай, Бат 40 см урт туузтай. Тэдний туузын нийт урт хэдэн дециметр вэ?

**459** Сургуулиас гэр хүртэлх зайг ол.



**460** Үйлдлийг хэрхэн гүйцэтгэснийг ажиглаад, тайлбарлаарай.



**461** Дараах уртын хэмжээнүүдийг ихээс нь бага руу эрэмбэлж, дэвтэртээ бичээрэй  
15 дм; 125 см; 3 м; 78 мм; 65 м; 600 см; 35 дм; 100 мм;





**462** Жишээрэй.
























а. 25 дм ... 250 мм   б. 300 см ... 3м   в. 45 см ... 5дм   г. 10 м ... 110 дм

**463** Саруулд 350 төгрөг байв. Тэр дэлгүүрээс юу худалдан авч чадах вэ?

200₮	300₮	50₮	100₮	
				

**464** Хэдэн төгрөг байгааг тооцоолж, жишээрэй.

 -100₮   
  -50₮   
  -20₮   
  -10₮

    	ба	     		     	ба	     
--	----	---	--	---	----	---

**465** Илэрхийллийн утгыг олоорой.

а.  $231 - 256 + 48$

б.  $92 + 12 \times 6$

в.  $198 - 15 \times 4$

г.  $52 \times 2 - 100$

д.  $106 \div 2 + 81$

е.  $632 - 562 + 158$

**466** Тэмүүлэн найздаа төрсөн өдрөөр нь бэлэг авч өгөх болов. Түүнд



төгрөг байв. Тэр дараах зүйлсээс алийг нь худалдан авч чадах вэ?



650₮



500₮




350₮




450₮



**467** Цэцгүүдийг вааранд хийхээр болов. Нэг вааранд 5 цэцэг хийх бол нийт хэдэн ваар хэрэгтэй вэ?




**468** 1000 төгрөгөөр хичээлийн хэрэгслээс юу, юу худалдан авч болох вэ?



**469** Дүрс бүрийг худалдах үнийг дор үзүүлэв.



Дараах зохиомжийг бүтээх дүрсүүдийг хэдэн төгрөгөөр худалдаж авах вэ?



## АНГИЛАХ

470



Дээрх зурагт юу юу байна вэ? Нэрлээрэй. Аль нь толоом, аль нь хичээлийн хэрэгсэл вэ? Эдгээрийг ангилж, дараах хүснэгтэд харгалзах тоог тэмдэглээрэй.

Хичээлийн хэрэгсэл	Тоглоом
1, ...	3, ...


471

Амьтдыг хоёр хэсэгт ямар шинжээр ангилсан байна вэ? Ангилсан шинжийг хүснэгтийн харгалзах нүдэнд асуултыг тэмдгийн оронд нөхөж бичээрэй.




Зүүн гар талд таван хошуу мал байна.

Баруун гар талд байгаа амьтад таван хошуу мал биш байна.



472

Дараах хүснэгтийг дэвтэртээ зураарай. Дүрсүүдийг ангилж, харгалзах тоог хүснэгтэд бичээрэй.





Дөрвөн талтай	Дөрвөн талбай биш


**473** Дараах тоон карт өгөгджээ. Дараах хүснэгтэд ямар шинжээр нь ангилах боломжтойг ширээнийхээ найзтай ярилцан, байрлуулаарай.

Жишээ нь: 50-аас их тоо, 50-аас их биш тоо гэж ангилж болох юм.

1	8	36	12	23	34	45	56
67	25	78	14	89	69	58	47

50-аас бага	50-аас их
1 ...	56 ...

**474** Ээжийн худалдан авсан товчнуудыг хэрхэн ангилж болох вэ?




Өнгөөр нь хоёр хэсэгт ангилж болох юм байна.


Товчнууд нь зарим нь 2 нүхтэй, зарим нь 4 нүдтэй байна. Иймд товчийг нүхнийх нь тоогоор ангилж болох юм байна.



	Цэнхэр өнгөтэй	Улаан өнгөтэй
хоёр нүхтэй	...	...
дөрвөн нүхтэй	...	...

**475** Дараах дүрсүүд өгөгджээ. Хүснэгтэд өгсөн шинжээр ангилж, байрлуулаарай.



	4 ба 4-өөс доош тооны талтай дүрс	4-өөс дээш тооны талтай дүрс
цэнхэр биш	 .....	 .....
цэнхэр өнгөтэй	 .....	 .....

**476** Дараах хүснэгтэд аяга, тавгийг ангилж, байрлуулсан байна. Асуултын тэмдгийн оронд байх утгыг нөхөөрэй.

	?	?
?		
?		

**477** Охин өгсөн тоон картыг хүснэгтэд ангилж, байрлуулжээ. Зөв байрлуулсан эсэхийг шалгаарай.

	нэг оронтой тоо	хоёр оронтой тоо
тэгш тоо	2, 6, 10, 8	86, 74, 48, 32
сондгой тоо	5, 11, 9, 3	95, 29, 67, 53, 7

## ӨГӨГДӨЛТЭЙ АЖИЛЛАХ

**478** Багш хоёрдугаар ангийн сурагчдаас тоглох туртай тоглоомын талаар асуужээ. Сурагчид дуртай тоглоомынхоо ард өөрийн нэрийг байрлуулжээ.



би дугуй унах дуртай

Харин би бөмбөгөөр тоглох дуртай



### Сурагчдын тоглох дуртай тоглоом


	Ану	Туул	Болор						
	Тамир	Дорж	Сонор	Болд	Мичид	Заяа			
	Сүлд	Энхээ	Бат	Анар					
	Цэцэг	Чимэг	Гэрэл	Ананд	Тэнгис	Тэргэд	Амар		
	Алтай	Хүрэл	Цогт	Отгон	Сүрэн	Билэг	Баяр	Ганаа	Хишиг

Тоглоом бүрийг хэдэн сурагч сонгосон байна вэ? Дараах хүснэгтэд бичээрэй. Сурагчдын тоглох дуртай тоглоом.

Сурагчдын тоглох дуртай тоглоом					
Тоглоом					
Тоо	3				




Тоглоом бүрийг сонгосон хүүхдүүдийг дугуй дүрсээр төлөөлүүлэн зурган диаграмм байгуулаарай.



Хүснэгт болон зурган диаграммыг ажиглаарай. Ямар тоглоомыг хамгийн их сурагч сонгосныг хүснэгт ба зурган диаграммын аль нь тодорхой харуулсан байна вэ? Ярилцаарай.

**479** Зурагт үзүүлсэн цэцгийг өнгөөр нь бүртгэж, хүснэгтэд тэмдэглээрэй.



Цэцэг	Бүртгэл	Тоо
улаан		2
хөх		
ягаан		
шар		
цагаан		

**480** Сурагчид сургуульдаа хэрхэн ирдэг талаараа ярилцаж, хүснэгтэд тэмдэглэв. Дараах асуултад хариулаарай.

Автобусаар	😊	😊	😊	😊	😊	😊	😊		
Машинаар	😊	😊	😊	😊	😊	😊	😊	😊	
Явганаар	😊	😊	😊	😊	😊	😊	😊	😊	😊
Дугуйгаар	😊	😊	😊	😊	😊	😊	😊		

- Дугуйгаар хичээлдээ ирдэг сурагчид явган ирдэг сурагчдаас хэдээр цөөн байна вэ?
- Машинаар ирдэг сурагчид автобусаар ирдэг сурагчдаас хэдээр олон байна вэ?
- Анги нийт хэдэн сурагчтай вэ?



**481** 2г ангийн сурагчид дуртай жимсний ард таван хошуу наажээ.

	★	★	★	★	★	★	★	★	★
	★	★	★	★	★	★	★		
	★	★	★	★					
	★	★	★	★	★	★	★	★	★

- Лийр болон гүзээлзгэнэд дуртай сурагчдын тоог тарвас болон алимд дуртай сурагчдын тоотой жишээрэй.
- Анги нийт хэдэн сурагчтай вэ?
- Зургийг ашиглан, бодлого зохиогоорой.


## ТЭНЦҮҮ ХУВААХ

- 482** Хүүхдүүд тэгш өнцөгт хэлбэртэй цаасыг 2 тэнцүү хэсэгт нугалав. Хүүхдүүдийн нугалсныг ажиглаарай. Хэн зөв нугалсан бэ?




Зөв нугалсан эсэхээ шалгацгаая.

- Цаасыг нугалсан хэсгээр нь хайчлаарай.
- Хайчилсан хэсгүүдээ давхарлан тавиарай.
- Хоорондоо тэнцүү эсэхийг шалгаарай.



Тэгш өнцөгтийн 2 тэнцүү хуваасны нэг хэсэг буюу хагасыг будсан байна.





Тэгш өнцөгтийн 4 тэнцүү хуваасны нэг хэсэг буюу хагасын хагасыг будсан байна.



- 483** Зургийг ажиглаад, асуултад хариулаарай.


- а. Ямар дүрсийн хагасыг будсан бэ?  
 б. Ямар дүрсийн хагасын хагасыг будсан бэ?



**484**




**Шалгаж үзье.**



Тэнцүү хэсэг нь будагдсан байна уу?

- 485** Охин 1 метр урттай туузын хагасаар чимэглэл хийв. Тэр хэдэн метр туузаар чимэглэл хийснийг олъё.




Туузын хагасыг хэрэглэсэн учир 1 метр туузаа 2 тэнцүү нугалъя.



1 м-ийг 2 тэнцүү хуваасныг нэг хэсэг нь  $\frac{1}{2}$  м - тэй тэнцүү байна. Үүнийг “хоёрны нэг метр” гэж уншина.




- 486** Туузыг хэрхэн хуваасныг ажиглаарай.



1 м-ийг 4 тэнцүү хуваасныг нэг хэсэг нь  $\frac{1}{4}$  м - тэй тэнцүү байна. Үүнийг “хоёрны нэг метр” гэж уншина.



- 487**




-ийн оронд байх тоог нөхөөрэй.

Дүрсийн  хэсгийг цэнхэр өнгөөр


хэсгийг ягаан өнгөөр

хэсгийг ногоон өнгөөр тус, тус будав.

488 Дүрсийн хагасыг будаарай.




489 Дүрсийн хагасын хагасыг будаарай.




490  -д тохирох тоог бичээрэй.

а. 8 чихрийн хагас нь  чихэр.

б. 6 чихрийн хагас нь  чихэр.



491 а. 12 чихрийн хагасын хагас нь 3 чихэр. б. 8 чихрийн хагасын хагас нь



492 Хулан 20 хуудастай номын хагасын хагасыг уншив. Тэр номын хэдэн хуудсыг уншсан бэ?

493 Болдоо өөртөө байгаа 8 ширхэг алимны хагасыг дүүдээ өгөв. Болдоод хэдэн алим үлдсэн бэ?

494 Эмээ 12 ширхэг лийрийн хагасын хагасыг эгчид өгчээ. Эгчид хэдэн лийр өгсөн бэ?

495


Алим


Жүрж

Гадил

- Алим, жүрж, гадил тус бүр хэдэн ширхэг байна вэ?
- Нийт алимны хагас нь хэдтэй тэнцэх вэ?
- Нийт жүржийн хагас нь хэдтэй тэнцэх вэ?
- Нийт гадилын хагас нь хэдтэй тэнцэх вэ?
- Нийт жүржийн хагас нь гадилны хагасын хагасаас олон байж чадах уу?


## ТЭГШ ХЭМТЭЙ ДҮРСИЙГ ТАНИХ

496 Зургийг ажиглаад, дагаад хийгээрэй.



Шулуун шугамаар нугалахад давхацдаг дүрсийг тэгш хэмтэй дүрс гэх юм болов уу?

Чиний нугалсан дүрс давхацсан уу?




Тасархай шугамаар дүрсэлсэн шулууны дагуу нугалахад уг дүрс давхцах болов уу?



497 Дээрх зургийг ажиглаад, дуурайлгаж нугалаарай.






498 Дүрсээс тэгш хэмтэй дүрсийг ялгаж, нэрлээрэй. Дэвтэртээ зурж, шалгаарай.






499 Тэгш хэмтэй дүрсийг дэвтэртээ гүйцээж, зураарай.



500 Тэгш хэмтэй үсэг хэд байна вэ? Тоолоорой.  
Тэгш хэмтэй эсэхийг хэрхэн мэдэх вэ?  
Ярилцаарай.




# МОНГОЛ

501 Дүрс тус бүрийн ямар хэсэг будагдсан байна вэ?



502 Өгөгдсөн үсэг, тоо, дүрсүүдээс тэгш хэмтэйг нь олоорой.

**Н П Р И У**      **9 5 8 4**



503 Дүрсийн оронд тохирох тоонуудыг бичээрэй.

$20 + 20 < \square < 47$        $\square$  : .....

$70 - 40 > \star > 20 + 5$        $\star$  : .....

$10 + 70 < \triangle < 30 + 60$        $\triangle$  : .....

504 Зүй тогтлыг ажиглаад, дараагийн тоог бичээрэй.

а. 14, 18, 22,  $\square$       б. 36, 51, 66,  $\square$       в. 81, 64, 47,  $\square$       г. 92, 82, 72,  $\square$

## ХҮНДИЙГ ХЭМЖИХ

505

**Туршилт:** Баг бүр ширээн дээрээ 1 ширхэг төмс, 1 ширхэг ном, 1 ширхэг шугам, 1 ширхэг самар бэлтгээрэй. Багийн гишүүн бүр бэлтгэсэн зүйлсээ нэг, нэгээр өргөж, хүнд хөнгөнийг баримжаалан, харьцуулаарай.



Аль нь хүнд гэдгийг хэрхэн мэдэх вэ?

Бас хэмжиж болно.



Өргөж үзээд мэдэж болно. Мөн жинлэж болно







506

Хүндийг хэмждэг ямар багажууд байдаг вэ? Зурагт үзүүлсэн багажуудаас мэдэхгүй багаж байна уу? Ярилцаарай.



507

Тавган жинлүүрийн заалтыг ажиглаад, ярилцаарай.



Хүндийг хэмжих үндсэн нэгж нь килограмм юм.  
Килограммыг товчлон "кг" гэж бичдэг.



508 Зургийг ажиглаад, 1 кг хэмжээг баримжаалаарай.



1 кг гадил



1 кг элсэн чихэр



1 кг хөвөн



1 кг чулуу




1 кг алим

509 1 кг гурил 6 ширхэг алимтай тэнцэж байв. 5 кг гурил хэдэн ширхэг алимтай тэнцэх вэ?

510 Хэдэн килограммыг зааж байна вэ?



511 Зурагт Бат, Нарангийн гэр бүлийн гишүүдийн жинг үзүүлжээ.



- Батын аав, ээж болон Нарангийн аав, ээжийн жингийн нийлбэрийг олж, жишээрэй.
- Бат, Наран хоёрын гэр бүлийн нийт жинг олж, жишээрэй.
- Зургийг ашиглан, бодлого зохиогоорой.

512 Охин 25 кг жинтэй. Тэр жин дээр сууж, зогсож, нэг хөлөө өргөж үзжээ. Түүний жин өөрчлөгдөх үү? Ярилцаарай.



513



### Хүндийг хэмжье


**Хэрэглэгдэхүүн:** Цахилгаан жин, жингийн бүртгэл хийх цаас

**Заавар:** а. Ангийн сурагчид 5 багт хуваагдана.

б. Баг бүр 1 ширхэг ном, 1 ширхэг үзэг, 1 ширхэг цүнх сонгож тэдгээрийг жинлэнэ. Үр дүнг ярилцаарай.


## ШИНГЭНИЙГ ХЭМЖИХ

**514** Хоёр хүүхэд цэцэг услахаар усны сав худалдан авчээ. Тэд эдгээр савныхаа багтаамжийг мэдэхийн тулд аягаар ус хийж, дүүргэв. Хэний сав илүү багтаамжтай вэ?



Би аягаараа 4 удаа ус хийхэд сав дүүрсэн.

Би аягаараа 5 удаа ус хийхэд сав дүүрсэн. Хэний сав илүү багтаамжтай вэ?



Хүүхдүүдийн ус хийсэн аяганы багтаамж өөр тул бид усны савны багтаамжийг харьцуулж чадахгүй юм байна.


Шингэний хэмжээг мэдэхийн тулд 1 литрийн багтаамжтай хэмжих сав хэрэглэдэг. Шингэнийг **литр** гэдэг нэгжээр хэмждэг бөгөөд "л" гэж тэмдэглэдэг.




Харин охины сав хэдэн литр багтаамжтай байна вэ?



**515** Зурагт үзүүлсэн сав тус бүр хэдэн литрийн багтаамжтай байна вэ?



**516** Хүү 5 саванд ус хэмжиж хийжээ. Сав тус бүрийн усны хэмжээг тодорхойлоорой.



**517** 1 литрийн багтаамжтай сав ашиглан гэртээ байгаа янз бүрийн савны багтаамжийг олоорой

**518** Янз бүрийн савны багтаамжийг баримжаалан хэлээрэй. Дараа нь 1 литрийн сав ашиглан баримжаалан хэлсэнтэйгээ тохирч байгаа эсэхийг шалгаарай.

Сав	Баримжаалсан хэмжээ	Хэмжсэн сав	Шалгасан хэмжээ
	8 л		6 литр
...			
...			

**519** Ээж, охин хоёр үнээ саав. Ээж 15 литр сүү, охин түүнээс 6 литрээр бага сүү саажээ. Тэд нийт хэдэн литр сүү саасан бэ?

**520** Жишээрэй

а.  $100 \text{ л} - 65 \text{ л} \dots 81 \text{ л} - 49 \text{ л}$       б.  $18 \text{ л} + 33 \text{ л} \dots 91 \text{ л} - 42 \text{ л}$

**521** Хүү эхний өдөр 10 литр айраг, дараагийн өдөр өмнөхөөс 2 дахин их айраг худалдаж авав. Тэр нийт хэдэн литр айраг худалдаж авсан бэ?

**522** Саран 11 литрийн багтаамжтай савыг сүүгээр дүүргэх болов. Саранд 3 литрийн багтаамжтай хувин байсан бол тэр хэдэн удаа зөөж, дүүргэх вэ?

## 2 ОРОНТОЙ ТООГ 2 ДАХИН ИХЭСГЭХ

**523** а. Үржвэрийг ажиглаад, гүйцээгээрэй.

$$2 \times 1 = 2; \quad 2 \times 3 = 6; \quad 2 \times 4 = 8; \quad 2 \times 2; \quad 2 \times 5; \quad 2 \times 6;$$

$$2 \times 10 = 20; \quad 2 \times 30 = 60; \quad 2 \times 40 = 80; \quad 2 \times 20; \quad 2 \times 50; \quad 2 \times 60$$

1 дүгээр мөрийн тэнцэтгэл 2 дугаар мөрийн тэнцэтгэлээс ямар ялгаатай байна вэ? Ярилцаарай.

б. Дээрх аргаар үржвэрийн утгыг олоорой.

$$2 \times 80 \qquad 2 \times 90$$

в. Аравтыг нэг оронтой тоогоор үржүүлэхэд ямар хялбар аргатай болсноо ярилцаарай.



Тоог бүтэн аравтаар үржүүлэхэд тэгийг орхиж үржүүлээд, гарсан утгын хойно тэгийг нэмж бичиж, болох юм байна.

*Жишээ нь:*  $60 \times 2 = 120$   
 $6 \times 2 = 12$

Тоог бүтэн аравтаар үржүүлэхэд үржвэрийн утга тэгээр төгсдөг юм байна.





**524**



### Тоог 2 дахин ихэсгэе

а. Тэгш хэмтэй дүрсийн дугаарыг дэвтэртээ бичээрэй.



б. Дугаарыг бичсэн дүрсээс нэгийг сонгон зурж, хайчлаарай.

в. Тэгш хэмтэй эсэхийг нугалж үзээрэй.

г. Нугалсан дүрсээ дэлгээд, нугалаасны зураасны нэг тал дээр 12 цэг штрихээр тэмдэглээд, нугалаарай.

д. Анх байсан цэгийн тоо дүрсийг нугалахад хэрхэн өөрчлөгдсөн бэ? Үйлдлийг бичээрэй.

**525**

Ижил жинтэй 2 шуудай алим байв. Шуудай бүр 23 кг алимтай. 2 шуудай алим хэдэн килограмм жинтэй вэ? Хэрхэн олох вэ?

Хулан доорх аргаар 2 шуудай алимны нийт жинг олжээ.

$$2 \times 23 \begin{cases} \rightarrow 2 \times 20 = 40 \\ \rightarrow 2 \times 3 = 6 \end{cases} 46$$



Дээрх аргаас өөр хялбар олох арга байх уу? Ярилцаарай.

**526**

Долгион, Дөлгөөн 2 дэлгүүрээс жимс бүрээс ижил тоогоор авчээ. Долгион, Дөлгөөн 2 жимс бүрээс нийт хэдийг авсан бэ? Хулангийн бодсон аргыг ашиглан, авсан жимсний тоог олоорой.


	Гадил	Алим	Лийр	Жүрж
Долгион	12	30	24	25

527 а. Тохирох тоог гүйцээж бичээрэй.



б. Тооны машинд  $20 \times 2 =$  хийгээрэй.

= дарах бүрд гарах тоог дээрх дүрсний тоотой харьцуулаарай.



• Дээрх 2 үйлдэл ямар ялгаатай байсан бэ? Тайлбарлаарай.

528 Хүү  $2 \times 22 = 44$

$2 \times 4 = 8$  гэдгийг мэддэг. Энэ мэдлэгээ ашиглан

$2 \times 26 = \dots$  -г хэрхэн олох вэ?

Дээрх аргаар багана бүрд байгаа үржвэрийн утгыг олоорой.

$2 \times 31$	$2 \times 44$	$2 \times 45$	$2 \times 54$
$2 \times 37$	$2 \times 48$	$2 \times 49$	$2 \times 56$

529 Саруул минутад 46 үг уншсан.

Тэлмэн түүнээс 2 дахин олон үг уншсан.

Тэлмэн минутад хэдэн үг уншсан бэ?



530



Нэг майхан оёход 27 м даавуу ордог. Эгч 1 майхан оёв. Харин оёдолчин эгчээс 2 дахин олон майхан оёв. Тэд тус бүрдээ хэдэн метр даавуу хэрэглэсэн бэ?

531 Загварт тохирох илэрхийлэл зохиогоорой. Ижил үсэг ижил тоог илэрхийлнэ.

а.  $A + A = B$

б.  $A \times C = B$

в.  $A \times A = A$




## ХУГАЦААГ ХЭМЖИХ

532

Дараах үйлийг тус бүр нэг удаа хийхэд алинд нь хамгийн богино хугацаа зарцуулах бол? Ярилцаарай.



1 цагт 60 минут байдаг гэдгийг бид өмнө мэдсэн. Тэгвэл 2 цагт хэдэн минут байх вэ? Хэрхэн олох вэ?



1 цаг = 60 минут учир  
2 цаг = 60 минут + 60 минут = 120 минут байх юм болов уу?



1 цаг = 60 минут  
1 хоног = 24 цаг  
1 сар = 30 (31)  
1 жил = 12 сар

Хугацааны нэгж хоорондын хамаарлыг танья.



Хоёр жилд хэдэн сар байх вэ? 1 жил = 12 сар учир  
2 жил = 12 сар + 12 сар = 12 сар  $\times$  2 = 24 сар байна.

533

-нд тохирох тоог олоорой.

а. 2 сар =  хоног      б. 2 хоног =  цаг      в. 2 жил =  сар

534

Жишээрэй.

а. 3 цаг ... 30 минут

б. 50 цаг ... 50 минут

в. 7 өдөр ... 7 цаг

г. 12 сар ... 1 жил

535

-д тохирох тоог олоорой.

а. 20 минут +  минут = 60 минут

б. 1 сар + 23 сар =  сар

в. 5 хоног +  хоног = 28 хоног

г. 60 минут + 25 минут =  минут



**536** Наран: Би гэрийн даалгавраа хийхэд 2 цаг зарцуулсан гэв. Цэлмэг: Харин би 50 минут зарцуулсан гэв. Хэн нь богино хугацаанд даалгавраа хийсэн бэ?

**537** “12 жилийн амьтад” бодлого бодож тогложээ. Морь жил 99 гэсэн тоо санасан. Түүнээс эхлэн амьтад үйлдлийг гүйцэтгэв.



**538** Хүү морь болон машинаар аялжээ. Тэр 48 цаг мориор, 3 хоног машинаар аялжээ. Тэр хэдэн хоног аялсан бэ?

**539**  -д тохирох тоог олоорой.

а. 1 хоног + 12 цаг =  цаг

б. 2 жил – 13 сар =  сар

в. 45 мин + 75 мин =  цаг

г. 18 сар – 6 сар =  жил


**540** Хүснэгтийг дэвтэртээ зураад, тохирох нүдэнд дүрсүүдийг байрлуулаарай.

4				
3				
2				
1				
	А	Б	В	Г

А1 нүдэнд-гурвалжин  
 В4 нүдэнд-квадрат  
 Г2 нүдэнд-дугуй  
 Б3 нүдэнд-таван өнцөгт

## ҮЛДЭГДЭЛТЭЙ ХУВААХ

**541** а. 17 шоог ширээний найзтайгаа тэнцүү хувааж аваарай.



- Нэг хүүхдэд хэдэн шоо ногдсон бэ?
- Шоо үлдсэн үү? Хэдэн шоо үлдсэн бэ?

б. 20 харандааг 3, 3-аар багцлаарай.  
 - Хэдэн багц болсон бэ?  
 - Багцад ороогүй харандаа үлдсэн үү?  
 - Хэдэн харандаа үлдсэн бэ?




9 харандааг 2 хүүхэд тэнцүү хувааж авчээ.



Нэг хүүхдэд 4 харандаа ногдсон.  
 1 харандаа үлдсэн.  
 Бичихдээ:  $9 \div 2 = 4$  үлд 1  
 Үлдэгдлийг товчоор “үлд” гэж бичнэ.  
 Уншихдаа: 9-ийг 2 тэнцүү хуваахад  
 4 ногдож 1 үлдэнэ.

**542** Зураглалд тохирсон бичиглэл хийгээрэй.



$$\boxed{\phantom{00}} \times \boxed{\phantom{00}} + \boxed{\phantom{00}} = \boxed{\phantom{00}}$$

$$\boxed{\phantom{00}} \times \boxed{\phantom{00}} + \boxed{\phantom{00}} = \boxed{\phantom{00}}$$

$$\boxed{\phantom{00}} \div \boxed{\phantom{00}} = \boxed{\phantom{00}} \text{ үлд } \boxed{\phantom{00}}$$

$$\boxed{\phantom{00}} \div \boxed{\phantom{00}} = \boxed{\phantom{00}} \text{ үлд } \boxed{\phantom{00}}$$



$$\boxed{\phantom{00}} \div \boxed{\phantom{00}} = \boxed{\phantom{00}} \text{ үлд } \boxed{\phantom{00}}$$

$$\boxed{\phantom{00}} \div \boxed{\phantom{00}} = \boxed{\phantom{00}} \text{ үлд } \boxed{\phantom{00}}$$


**543** Илэрхийллийн утгыг олоорой. Жишээ:  $9 \div 4 = 2$  үлд 1

а.  $7 \div 2$    б.  $11 \div 3$    в.  $13 \div 4$    г.  $18 \div 4$    д.  $8 \div 5$    е.  $23 \div 3$    ж.  $19 \div 5$

**544** 15 алимьг 2 тавагт тэнцүү хувааж хийх болов.

Нэг тавганд хэдэн алим тавьсан бэ?

Хэдэн алим үлдсэн бэ?



15 алимьг таваг бүрд 2, 2-оор тавив.


Хэдэн тавагт алим тавьсан бэ?

Таваглаагүй алим үлдсэн үү?

11 гадилыг 5 сагсанд тэнцүү хувааж хийв.

Нэг сагсанд хэдэн гадил хийсэн бэ?

Хэдэн гадил үлдсэн бэ?



11 гадилыг 5, 5-аар сагсанд хийв.

Сагс бүрд хэдэн гадил ногдсон бэ?

Хэдэн гадил үлдсэн бэ?

**545** Зурагт тохирох бичиглэлүүдийг олоорой? Хамтран ярилцаарай.



а.  $10 \times 3 + 3$

$33 \div 10 = 3$  үлд 3

б.  $3 \times 10 + 3$

$33 \div 3 = 10$  үлд 3

в.  $3 \times 4 + 10$

$23 \div 3 = 7$  үлд 2

**546** Бичиглэлд тохирох зураглал хийгээрэй.


а.  $4 \times 5 + 4$

б.  $17 \div 3 = 5$  үлд 2

в.  $6 \times 8 + 2$

г.  $23 \div 5 = 4$  үлд 3

**547** Талбайн будсан  бүрд хэсэгт мод суулгажээ.



- Мөр бүрд хэдэн мод суулгасан бэ?

- Тэнцүү тооны модтой хэдэн мөр байсан бэ?

- Нийт хэдэн мод суулгасан бэ?

$\times$   +  =

Бодлогыг энэ загвараар бодож болох уу?

**548** Үйлдлийг гүйцээгээрэй.

$17 \div 2 = 8$  үлд 1

$2 > 1$

а. Жишсэн тоонууд хуваах үйлдлийн ямар гишүүд вэ?

$17 \div 3 = 5$  үлд 2

$3 > 2$

б. Жишсэн тоонуудын ямар гишүүн нь бага байна вэ?

$17 \div 4 = 4 \dots$

$4 > \dots$

Хариултаа ашиглан, өгүүлбэрийг гүйцээгээрэй.

$17 \div 5 = \dots$

$5 ? \dots$

$17 \div 7 = \dots$

$17 \div 8 = \dots$


$17 \div 9 = \dots$

$17 \div 10 = \dots$

Үлдэгдэл нь  $\dots$ -аас ямагт бага байдаг.

## БАТАТГАХ

- 1** Зүй тогтлыг ажиглаад, дараагийн 3 тоог бичээрэй.
- а. 10, 25, 40, , ,
- б. 16, 40, 64, , ,
- в. 91, 75, 59, , ,
- 2** Илэрхийллийг бичээд, утгыг олоорой.
- а. 245 ба 314-ийн нийлбэрийг 438-аар хорогдуулах
- б. 412 ба 125-ын нийлбэрийг 211-ээр нэмэгдүүлэх
- в. 768 ба 325-ын ялгаврыг 526-аар нэмэгдүүлэх
- г. 987 ба 621-ийн ялгаврыг 145-аар хорогдуулах
- 3** Туухайгүй жинлүүрээр жинлэхэд 1 ширхэг дэвтэр, 5 ширхэг балтай тэнцүү жинтэй байжээ. Тэгвэл 8 дэвтэр хэдэн балтай тэнцүү жинтэй вэ?
- 4** 3, 3-аар багцлахад 2 үлдэх 20-оос бага тоо хэд байх вэ? Туршиж үзээрэй.
- 5** Гурвалжны тал бүр дээрх дугуй дүрсэд бичсэн тооны нийлбэр 20 гарч байхаар 1-9 хүртэлх тоог байрлуулна уу?



- 6** Дэвтэртээ зураад, гүйцээж бичээрэй.



22	1	20	3	...	17	...	...	...	...	...	...
	21	2	19	4	...	...	...	...	...	...	...

- 7** Тэгш хэмтэй зургийг нэрлэнэ үү.



- 8** Булган 18 кг нэрс түүжээ. Түдэв, Булганаас 2 дахин их тошлой түүсэн. Харин Санчир, Булганаас 2 дахин бага гүзээлзгэнэ түүсэн бол Түдэв, Санчир хоёрын түүсэн жимсний зөрөөг олоорой.

9 Зургаар бодлого зохиож, бодоорой.




$$\square \times \square = \square$$

$$\square \div \square = \square$$


$$\square \times \square = \square$$

$$\square \div \square = \square$$

10 Бичиглэлд тохирох бодлого зохиож бодоорой.




11 Асуултын тэмдгийн оронд тохирох тоог олоорой.




12 Эхний цүнхэнд 10 ном хийв. Хоёр дахь цүнхэнд түүнээс 2 дахин их ном хийв. Хоёр цүнхэнд нийт хэдэн ном хийсэн бэ?

13 Гэрэл, Наран, Сүлд гурав тэгш өнцөгтийн дөрөвний нэгийг будав. Тэдний хэн нь зөв хийснийг олоорой.


Гэрлээ



Наран



Сүлдээ



14 Орхигдсон тоо болон дүрсийг дэвтэртээ нөхөөрэй.



15 Илэрхийллүүдийг ажиглаад:

A.  $19 + 54$


Б.  $35 + 19$

В.  $54 + 35$

- а. 54 нь дээрх илэрхийлэлд ямар гишүүн болох вэ?
- б. Үйлдлийг гүйцэтгэхгүйгээр А, Б илэрхийллүүдийн нийлбэрийн утгыг жишээд, учрыг тайлбарлаарай.
- в. Үйлдлийг гүйцэтгэхгүйгээр Б, В илэрхийллүүдийн нийлбэрийн утгыг жишээд, учрыг тайлбарлаарай.

16 Охин даваа гарагт 9 кг алим, мягмар гарагт түүнээс 6 дахин их алим худалдаж авсан бол нийт хэдэн килограмм алим худалдаж авсан бэ?

17 Хүүд 15 бөмбөг, 5 машин байв. Тэр 5 найздаа тоглоомуудыг тэнцүү хувааж өгөхөөр болов. Хэрхэн хуваах вэ?



18



Хэн хожих вэ?



**Хэрэглэгдэхүүн:** Хоёр өнгийн шоо,  $10 \times 10$  хүснэгт

**Заавар:** Хоёр тоглогч хүснэгтэд байрласан дүрснээс сонгоно. Хоёр тоглогч ээлжлэн улаан, цэнхэр өнгийн 2 шоог зэрэг орхино.

**Улаан өнгийн шоо:** Баруун эсвэл зүүн тийш буусан нүдний тоогоор шилжинэ.

**Цэнхэр өнгийн шоо:** доош эсвэл дээш буусан нүдний тоогоор шилжинэ.

Хамгийн түрүүнд ногоон өнгийн нүдэнд очсон тоглогч хожно.



19  -д тохирох тоог бичээрэй.

а.   $\xleftarrow{-6}$  56  $\xrightarrow{+6}$

в.   $\xleftarrow{-9}$  81  $\xrightarrow{+9}$

б.   $\xleftarrow{-8}$  72  $\xrightarrow{+8}$

г.   $\xleftarrow{-7}$  93  $\xrightarrow{+7}$

20 Илэрхийллийг бичээд, утгыг олоорой.

- а. 726 ба 613-ын ялгаврыг 90-ээр хорогдуулах
- б. 71 ба 18-ын ялгаврыг 7 ба 5-ын үржвэрээр нэмэгдүүлэх
- в. 19 ба 28-ын нийлбэрийг 6 ба 8-ын үржвэрээр нэмэгдүүлэх
- г. 8 ба 9-ийн үржвэрийг 37-оор хорогдуулах
- д. 64 ба 8-ын ногдворыг 400 ба 120-ын нийлбэрээр нэмэгдүүлэх

21 Хүүхдүүд ширээн дээр хоорондоо 1 төө зайтай байхаар тоглоом өрөв. 15 төө урттай зайд хэдэн тоглоом өрсөн бэ?

22 Шугамын дагуу нугалахад давхцах нүдэнд ижил тоо байдаг.

- Хүснэгтийг шугамын дагуу нугалахад давхцах нүдэнд ямар тоо байхыг бичээрэй.
- Цэнхэр мөрөнд байгаа тоотой адил зүй тогтолтой баганыг олоод, цэнхэр өнгөөр будаарай.
- Шараар будсан мөрөнд тохирох тоог бичээрэй. Тоонууд хэдээр ихсэж байна вэ?

	1	2	3	4	5	6	7	8	9
1		2			5				9
2				8			14		
3									
4	4	8	12	16	20	24	28	32	36
5				20					
6								48	
7									
8									
9									

23



Гурван найзын нэрийг Болд, Тамир, Ананд гэдэг. Тамир малгай өмсөөгүй. Болд өмд өмссөн. Ананд цүнх үүрсэн бол гурван найзын нэрийг олоорой.



24 Нийлбэрийн утгыг хялбар аргаар тооцоолоорой.





- а.  $29 + 41 + 59 + 71$   
 б.  $99 + 85 + 101 + 15 + 100$   
 в.  $151 + 19 + 49 + 81 + 50$

25 Хүснэгтийг дэвтэртээ зураад, тохирох тоог олоорой.

	86	69		62	81		69
		52	25		29	75	
 + 	102		71	98		96	100

26 Наранд аав нь 26 чихэр өгөв. Дүүд нь 13 чихэр өгөв. Нарангийн аавд нийт хэдэн чихэр байсан бэ?

27 Үргэлжлэх хугацааг тооцоорой.



28



- Дараах тоонуудаас 6-д хуваагддаг хамгийн их тоог олоорой.  
 а. 16                      б. 24                      в. 86                      г. 84
- Дараах тоонуудаас 5-д хуваахад 1 үлдэгдэл гардаг, 3-д хуваагддаг тоог олоорой.  
 а. 15                      б. 34                      в. 36                      г. 46
- 16 ба 5-ын үржвэрийн утгыг 4 дахин багасгахад хэд гарах вэ?  
 а. 25                      б. 30                      в. 20                      г. 17
- 60 ба 4-ийн ногдворын утгыг 2 дахин ихэсгэхэд хэд гарах вэ?  
 а. 40                      б. 15                      в. 30                      г. 20





29 Нийлбэрийг хялбар аргаар тооцоолоорой.




а.  $9 + 11 + 13 + 15 + 17 + 19 + 21 + 30$

б.  $32 + 33 + 34 + 35 + 36 + 37 + 38 + 39$

30 Орхисон тоог дэвтэртээ гүйцээж бичээрэй.



31 Тэгш хэмтэй дүрсийг дэвтэртээ гүйцээж, зураарай. Дүрсүүдийг гүйцээж, зурахад хэдэн талтай болох вэ?



32 Цэцэрлэгт 4 эгнээнд 489 цэцэг тарьжээ. Эхний эгнээ 134 цэцэгтэй. Дараагийн эгнээ түүнээс 121-ээр олон цэцэгтэй. Үлдсэн эгнээний цэцгүүд тэнцүү байж болох уу?

33



**Хүрдээ бататгая**

**Хэрэглэгдэхүүн:** 2 хайрцаг тус бүрд 1-9 хүртэл дугаарлагдсан тоон картууд

**Заавар:**

а. 2 сурагч хайрцаг бүрээс нэг, нэг карт сугална.

б. Ангийн сурагчид тэдгээр тоонуудыг үржүүлээд, үр дүнг хэлнэ.

$7 \times 9 = ?$



63 зөв үү?


34 Илэрхийллийн утгыг олоорой.

- а.  $46 + 27$ ;  $54 + 37$ ;  $63 + 29$ ;  $17 + 65$ ;  $33 + 48$   
б.  $83 - 56$ ;  $72 - 27$ ;  $91 - 43$ ;  $57 - 48$ ;  $64 - 35$   
в.  $233 + 156$ ;  $457 + 511$ ;  $608 + 261$ ;  $384 + 515$ ;  $714 + 173$   
г.  $756 - 243$ ;  $593 - 271$ ;  $859 - 568$ ;  $647 - 346$ ;  $839 - 216$

35  -д тохирох тоог бичээрэй.

- а.  $12 \times 6 < \square < 99 - 19$   
б.  $125 + 652 < \square < 900 - 120$   
в.  $25 \times 2 < \square < 11 \times 2$

36 Цэцгүүдийг сагсанд тэнцүү тоогоор багцалж хийв. Нэг сагсанд хэдэн цэцэг ногдох вэ?



37 Тулгад 16 дэвтэр, түүнээс 4 дахин бага бал байв. Түүнд нийт хэдэн хичээлийн хэрэгсэл байна вэ?

38 Дэлгүүр барааны үнийг дараах байдлаар өөрчлөв. Анхны үнээс хэрхэн өөрчлөгдсөнийг тооцоолоорой.

- Сүүний үнэ эхлээд 300 төгрөгөөр хямдарч, дараа нь 200 төгрөгөөр нэмэгдэв.
- Талхны үнэ эхлээд 50 төгрөгөөр, дараа нь 10 төгрөгөөр нэмэгдэв.
- Жигнэмгийн үнэ эхлээд 30 төгрөгөөр нэмэгдэж, дараа нь 50 төгрөгөөр хямдрав.
- Зайрмагийн үнэ эхлээд 30 төгрөгөөр, дараа нь 20 төгрөгөөр хямдрав.



39 4-ийн цифр нь өгсөн тоонуудад ямар орны утгыг илэрхийлж байна вэ?  
341; 804; 294; 471; 540; 401




40 Орхисон тоог дэвтэртээ гүйцээж, бичээрэй.

а. 283, , , 286, ,  288, ,

б. , 481, 491, , , 521, ,

в. 206, , 406, , ,  806,

41 Дараах тахир шугамын уртыг хэмжээрэй.



42 Тэмүүлэнд 36 чихэр байв. Тэр 5 найздаа чихрээ тэнцүү хувааж өгөв. Тэмүүлэнд чихэр үлдэх үү? Ярилцаарай.

43 Сурагч бүр хэдэн цэцэгтэй байна вэ? Бодлого зохиогоорой.

Бат									
Намуун									
Саруул									

44 Тэнцүү хариу гарсан уу?

- Ямар нэг тоо санаарай.
- Санасан тоон дээрээ 20-ийг нэмээрэй.
- Дараа нь дахиад төчнөөнийг нэмээрэй.
- Тэгээд санасан тоогоо хасаарай.
- Хариу хэд гарсан бэ?
- Хариуг шууд хэлэх боломжтой юу?
- Хэд хэдэн удаа туршаад, хариуг ажиглаарай. Бүгд тэнцүү байж чадсан уу? Учрыг ярилцаарай.




- 45 Нийлбэрийн утгыг олоод, үгээр бичээрэй.  
 Жишээ:  $300 + 80 + 7 = 387$ ; Гурван зуун наян долоо  
 а.  $400 + 60 + 1 = \square$ ; .....  
 б.  $100 + 20 = \square$ ; .....  
 в.  $900 + 4 = \square$ ; .....  
 г.  $500 + 30 + 6 = \square$ ; .....

- 46 Илэрхийллийн утгыг олж, жишээрэй.  
 а.  $103 + 96 \dots 326 - 126$  б.  $27 + 6 \times 8 \dots 36 \div 4 + 65$   
 в.  $120 + 24 \div 4 \dots 10 \times 9 + 4 \times 9$  г.  $516 + 231 - 325 \dots 876 - 453 + 64$

- 47 Хамгийн их тоо үүсгэхийн тулд карт дээр байгаа цифрийг 2 оронтой тооны хаана байрлуулбал зохих вэ?  
 Жишээ нь:  $\begin{array}{|c|} \hline 6 \\ \hline \end{array}$  хамгийн их тоо үүсгэхийн тулд 6-г урд нь буюу 617 болгож байна.  $\begin{array}{|c|c|} \hline 1 & 7 \\ \hline \end{array}$


- а.  $\begin{array}{|c|} \hline 8 \\ \hline \end{array}$  б.  $\begin{array}{|c|} \hline 4 \\ \hline \end{array}$  в.  $\begin{array}{|c|} \hline 0 \\ \hline \end{array}$   
 $\begin{array}{|c|c|} \hline 9 & 2 \\ \hline \end{array}$   $\begin{array}{|c|c|} \hline 5 & 6 \\ \hline \end{array}$   $\begin{array}{|c|c|} \hline 6 & 8 \\ \hline \end{array}$

- 48 Найзууд  цагт хөл бөмбөг тоглож эхлэв.  
 Тэд 3 цаг 30 минутын турш тоглосон бол хэдэн цагт тоглож дууссан бэ?



- 49 Хүү 25 см урттай лаа асаав. Лаа цаг тутамд 2 см-ээр багсаж байгааг ажиглав.  
 • Лаа 5 цагийн дараа хэдэн сантиметр урттай болох вэ?  
 • Лаа 8 цагийн дараа асаалттай байж чадах уу? Яагаад?




50  Багш 10 сурагчид ижил хэмжээтэй квадрат хэлбэртэй цаас тарааж өгөв. 6 сурагч нь цаасны  $\frac{1}{2}$ -ийг хайчлан, ногоон өнгөөр будав. Үлдсэн сурагчид цаасны  $\frac{1}{4}$ -ийг хайчлан улаан өнгөөр будав. Сурагчид будсан цаасаа эвлүүлж, анхны бүтэн квадраттай адил дүрс үүсгэв.

- Ногоон, улаан өнгийн бүтэн квадрат хэд үүссэн бэ?
- Квадрат үүсэж чадаагүй будагдсан дүрс үлдсэн үү?

51  $\square$ -д тохирох тоог олоорой.  
 $2 \times 12 = 4 \times \square$ ;  $2 \times 16 = \square \times 8$ ;  $36 \times 2 = 9 \times \square$

52 Цагт 50 км замыг туулдаг суудлын машин өглөөний 8 цагт А цэгээс гарчээ.




- а. Суудлын тэрэг Б цэгт ирэхэд хэдэн цаг болж байх вэ?
- б. Суудлын тэрэг Б цэг хүртлээ хэдэн километр зам туулсан бэ?
- в. Суудлын тэрэг В цэгт ирэхэд хэдэн цаг болж байх вэ?
- г. Суудлын тэрэг В цэг хүртлээ хэдэн километр зам туулсан бэ?
- д. Оройн 5 цагт суудлын тэрэг В цэгт хүрч чадах уу?
- е. Б цэгээс В цэг хүртэл хэдэн километр зам туулсан бэ?


53 Тоогоор бичээрэй.

- |                           |                            |
|---------------------------|----------------------------|
| а. Хоёр зуун гучин тав    | г. Нэг зуун тавин ес       |
| б. Найман зуун хорин нэг  | д. Гурван зуун хоёр        |
| в. Дөрвөн зуун наян долоо | е. Дөрвөн зуун дөчин гурав |

54 Асуултын тэмдгийн оронд тохирох тоог бичээрэй.



55 Мөнхөөгийн аялсан нийт замын уртыг олоорой.



56 Дорж гуайн 17 хонь хургалжээ. Тэдгээрээс 4 нь ихэрлэсэн бол Дорж гуайнх хэдэн хургатай болсон бэ?

57 Тоон картуудыг ашиглан, дараах бодлогуудыг бодоорой.



- Хамгийн их 2 оронтой тоо, хамгийн бага 3 оронтой тоог үүсгээд, ялгаврын утгыг олоорой.
- Бүх цифр нь тэгш хамгийн их 2 оронтой тоо үүсгээд, цифрүүдийн нийлбэрийн утгыг олоорой.
- Хамгийн их 3 оронтой тоо болон хамгийн бага 2 оронтой тоог олж, нийлбэрийн утгыг олоорой.
- 60-аас их 2 оронтой тоо бичээрэй.
- 60-аас бага бүх цифр нь сондгой 2 оронтой тоонуудыг бичээрэй.

58 Хуваарьтай шугам дээр байгаа тоо бүрээс 40-өөр их болон бага тоог олж, тэмдэглээрэй.



59 Үржүүлэхийн хүрдийн хүснэгтээ ашиглан, бодоорой.

×	1	2	3	4	5	6	7	8	9	10
1	1	2	3	4	5	6	7	8	9	10
2	2	4	6	8	10	12	14	16	18	20
3	3	6								
4	4	8	12	16	20	24	28	32	36	40
5										
6										
7										
8	8	16	24							
9	9	18	27							
10	10	20								
11										
12										
13										

- 2 ба 4-ийн хүрдээр хэдийн хүрдийг бүтээж болох вэ?
- 4 ба 3-ын хүрдийг ашиглан, 7-ийн хүрдийг бүтээгээрэй. Өөр хэдийн хүрдийг ашиглан, зохиож болох вэ?
- 13-ын хүрдийг 6 ба 7, 10 ба 3, 8 ба 5-ын хүрднүүдийг ашиглан, бүтээгээрэй. Хэдийн хүрд ашиглан бүтээх нь хялбар байсан бэ? Яагаад?
- 1-10-ын хүрд ашиглан, 20 хүртэлх тооны хүрдийг гаргаж чадах уу? ×адах бол дурын 3 тооны хүрдийг сонгон зохиогоорой.

60 Өгсөн тоонуудыг орны нэмэгдэхүүний нийлбэрээр задлан бичээрэй.  
157, 528, 304, 119, 830, 758

61 Охин тоо санав. Санасан тооноосоо 19-ийг хасахад 81 гарав. Санасан тоог олоорой.

62 265, 370, 615, 185, 565, 825 гэсэн тоонуудыг шугам дээр барагцаалан, тэмдэглээрэй.



63 528, 104, 218, 639, 710, 140, 208, 716 гэсэн тоонуудыг:  
а. Өсөх эрэмбээр байрлуулж, бичээрэй.  
б. Тоо бүрийн их хөрш, бага хөрш тоонуудыг нэрлээрэй.

64 Үйлдлийг гүйцэтгээрэй.  
а. 16 мм, 9 мм, 24 мм, 68 мм, 91 мм ойролцоогоор хэчнээн сантиметр вэ?  
б. 24 см, 32 см, 65 см, 81 см, 27 см ойролцоогоор хэчнээн дециметр вэ?  
в. 687 см, 410 см, 754 см, 808 см, 349 см ойролцоогоор хэчнээн метр вэ?

65 Дэвтэр 350 төгрөгийн үнэтэй бол 100, 50-тын дэвсгэртийг ашиглан, хэдэн янзаар тооцоо хийж болох вэ?



66 Унадаг дугуй ба машины нийт дугуйны тоог олоорой.







$$\square \times \square = \square \quad \square \div \square = \square$$

67 Хөхүүртэй айрагнаас 40 л-ийн саваар 1 удаа, 8 л-ийн хувингаар 5 удаа авахад айраг дуусав. Хөхүүрт хэдэн литр айраг байсан бэ?




68 Сагсанд байсан жимсийг ангилж, зургаар харуулав.

Алим	
Тарвас	
Жүрж	
Гадил	

- а. Ямар жимс хамгийн олон байна вэ?
- б. Ямар жимс хамгийн цөөн байна вэ?
- в. Алим гадилаас хэдээр олон байна вэ?
- г. Нийт хэдэн ширхэг жимс байна вэ?

69 Зүй тогтлыг ажиглаад, дараагийн 3 цагийг дэвтэртээ тэмдэглээрэй.





70 Уут бүрд 8 кг гурил хийвэл дүүрнэ. Эдгээр уутыг дүүргэхэд хэдэн килограмм гурил хэрэгтэй вэ?



71 1985 онд Бат дэлгүүрээс 2 дахин хямдарсан үнээр бараа авчээ. Авсан барааны тооцоог хүснэгтээр үзүүлэв. Хүснэгтийн арилсан тоонуудыг гүйцээж олоорой

Барааны төрөл	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
	4 ш		36 төгрөг
		2 төгрөг	12 төгрөг
	10 кг	5 төгрөг	
	8 кг		63 төгрөг

72 Үйлдлийг гүйцэтгээрэй.



Барааны үнэ 2 дахин хямдраагүй байсан бол Бат нийт хэдэн төгрөгөөр бараа авах байсан бэ?



73 Дараах тоонуудыг орны нэмэгдэхүүний нийлбэрээр задалж, бичээрэй.  
582, 939, 185, 614, 645, 471, 528

74



Тооны машин хэрэглэн  $208 + 100$  үйлдлийг хийж, = тэмдгийг 4 удаа дараалан гүйцэтгэвэл ямар үр дүн ажиглагдаж байгааг тайлбарлаарай.


75 Төмөр 16 настай. Дүү нь Төмөрөөс 2 дахин бага настай. Ээж нь тэдний насны нийлбэрээс 2 дахин их настай. Ээж хэдэн настай вэ?

76 Тулгын өндөр 150 см байв. Тэр 3 жилийн өмнө 50 см-ээр намхан байжээ. Тэр 3 жилийн өмнө хэдэн сантиметр өндөртэй байсан бэ?

77 5, 8, 11, 16, 29, 32, 45 тоонууд өгчээ. Сондгой тоо бүрийг 12-оор, тэгш тоо бүрийг 11-ээр нэмэгдүүлээрэй. Нийлбэр тэгш тоо гарсан уу?, Сондгой тоо гарсан уу? Ярилцаарай.

78 Сурагчдад байгаа чихрийг дүрсээр үзүүлэв.

 6 ширхэг чихэр



а. Хүүхэд бүрд хэдэн чихэр байна вэ?

б. Хулан, Ганаагаас хэдээр олон чихэртэй байна вэ?

в. Ганаа, Тамираас хэдээр цөөн чихэртэй байна вэ?

79



Хамгийн урт, богино тахир шугамыг дэвтэртээ зурж, хэмжье.

Хэрэглэгдэхүүн:

7 см

13 см

5 см

10 мм

1 дм

**Заавар:**

- Дурын 3 картыг сугалаарай.
- Сугалсан 3 картад өгсөн хэмжээний хэрчмүүдээс тогтох тахир шугам зураарай.
- Тахир шугамын нийт уртыг хэмжээрэй.

80 Илэрхийллийн утгыг олоорой.

- а.  $126 + 63$ ;  $350 + 45$ ;  $257 - 25$ ;  $758 + 41$ ;  $647 - 33$   
 б.  $256 + 123$ ;  $747 - 326$ ;  $861 + 107$ ;  $598 - 235$ ;  $654 - 231$

81 Хүснэгтэд орхигдсон тоог гүйцээж бичээрэй. Тэдгээрийг бичихэд нийт хэдэн цифр орсон бэ?

	92		94			97	98		100
101		103			106		108		110

82 Зурагт 1 дм урттай АБ хэрчмийг дүрслэв.



АБ хэрчмийн  $\frac{1}{2}$  хэсгийг олж тэмдэглээрэй. Хэсгийн уртыг сантиметрээр илэхийлээрэй.

83 Наран гэрээсээ сургууль хүртэл 90 минут явдаг. Харин сургуулиасаа гэр хүртлээ 1 цаг 30 минут явдаг бол алинд нь их урт хугацаа зарцуулдаг вэ?

84 а. Хүснэгтийг ажиглаад, нэг бүрийн үнийг олоорой.

= ?	= ?



б. Нийлбэр нь 100 байх хос тоог холбоорой.

- 20, 65, 56, 43, 81  
 19, 44, 80, 35, 57

в. Нийлбэр нь 1000 байх хос тоог холбоорой.

- 800, 450, 100, 370, 500  
 550, 630, 900, 200, 530

85 Дүрс тус бүрд хэдэн гурвалжин, хэдэн дөрвөн өнцөгт байна вэ? Тоолоорой.




86 Зүй тогтлыг ажиглаад, тоог дэвтэртээ гүйцээж бичээрэй.



87 Дурын 2 оронтой тоо зохиогоорой. Тэр тоог 2 дахин ихэсгээрэй.  
 - Чи ямар тоо зохиосон бэ? Тэгш тоо юу? Сондгой тоо юу?  
 - 2 дахин ихэсгэсний дараа үржвэрийн утга ямар цифрээр төгсөж байна вэ?  
 Тэгш үү?, Сондгой юу?

88 а. Аль нь урт вэ?



б. □-д тохирох олоорой

$$10 \text{ см} + 90 \text{ см} = \square \text{ м};$$


$$35 \text{ дм} + 65 \text{ дм} = \square \text{ м};$$



$$30 \text{ см} - 10 \text{ см} = \square \text{ дм}$$

$$100 \text{ мм} - 50 \text{ мм} = \square \text{ см}$$

89 Номин 2 оронтой тоо санав. Уг тоог 5-д хуваахад 4 үлдэгдэл, 6-д хуваахад 1 үлдэгдэл гардаг бол санасан тоог ол.

90 Нийт хэдэн куб байна вэ?



91  Цаг өглөөний  болж байна. Туулайн бүжин 1 цаг тутам 2 ширхэг лууван иддэг бол:  
 а. Бүжин 6 ширхэг лууван идсэний дараа цаг хэд болж байх вэ?  
 б. Өдрийн 1 цаг хүртэл 9 ширхэг лууванг идэж чадах уу? Яагаад вэ?

92 Дараах тоонуудыг аравт, зуутаар тоймлоорой.  
152, 962, 18, 204, 851, 498, 745, 349

93 Хүүхдүүд сагсанд байгаа 36 ширхэг алимьг тэнцүү тоогоор хэд хэдээр нь савлаж болох вэ?


94 Миний санасан тоог олоорой.

- Гурван оронтой тэгш тоо
- Аравтын орны цифр нь нэгжийн орны цифрээс 3-аар их, зуутын орны цифр нь аравтын орны цифрээс 3-аар их байна.

95




Зурагт үзүүлсэн зүйлс хайрцаг дотор байна.

Би ягаан хайрцагнаас нийт 150₮-ийн үнэтэй зүйлс авсан.



Харин би хөх хайрцагнаас 350₮-ийн үнэтэй зүйлс авсан.

Тэд юу, юу худалдаж авсан бэ?

96 Болдоо тус бүр нь 50 төгрөгийн үнэтэй  , 200 төгрөгөөр  авав. Болдоо нийт хэдэн төгрөг төлсөн бэ?

97 Дараах хүснэгтийг нөхөөрэй.

5		2		?
9	x	6	=	?
3		10		?

98



Хулан найзынхаа гар утасны дугаарыг тэмдэглэсэн цаасыг хайж олоход 3 хэсэг болсон байв. Хулангийн найзын утасны дугаар хэд байж болох вэ? Түүнийг найзтайгаа ярихад нь туслаарай.

127

60




980

99  -д тохирох тоог олоорой.

а.  $254 + \square = 367$  ;  $\square + 253 = 875$  ;  $\square - 136 = 541$  ;

а.  $250 - \square = 130$  ;  $218 + \square = 879$  ;  $694 - \square = 272$  ;

100 Номинд 1 м урттай тууз байна. Тэр доорх дүрсүүдээс алийг нь туузаар хүрээлж чадах вэ?




101 Баясгалан төрсөн өдрөөрөө найздаа бэлэг бэлджээ. Түүнд эвлүүлдэг тоглоом, ном, бөмбөр байв. Бэлгэнд 2 зүйл хийх бол хэдэн янзын бэлэг боож болох вэ?

- Хамгийн үнэтэй бэлэг хэдэн төгрөг болсон бэ? Юу юу орсон бэ?
- Үнэ нь хамгийн их зөрөөтэй бэлгүүдийг нэрлээрэй.



102 Болор цагт 5 хуудас ном уншдаг. Өглөөний 10 цагаас өдрийн 2 цаг хүртэл номын хэдэн хуудсыг унших вэ?

103 АБ, БГ хэрчмүүд хоорондоо тэнцүү бол  тохирох тоог бичээрэй.



- АБ нь АГ хэрчмийн
- БГ нь АГ хэрчмийн
- БВ нь АГ хэрчмийн

- ВГ нь АГ хэрчмийн
- ВГ нь БГ хэрчмийн
- БВ нь БГ хэрчмийн

104 Ах, дүү хоёрын насны нийлбэр 20. Гурван жилийн дараа ах 15 нас хүрнэ. Тэд одоо хэдэн настай вэ?

105 1000 кг ачаа даах чадалтай өргөгч шатаар ачааг хэрхэн зөөж болох вэ?



Жишээ:  $900 \text{ кг} + 100 \text{ кг} = 1000 \text{ кг}$   
 $100 \text{ кг} + 200 \text{ кг} + 700 \text{ кг} = 1000 \text{ кг}$



106 Ногоон бөмбөг цагаан бөмбөгнөөс хүнд, цагаан бөмбөг ягаан бөмбөгнөөс хүнд бол аль нь хамгийн хөнгөн бэ?

107 Таван давхар орон сууцны давхар бүр 6 айлтай. Эдгээр айлын хаалгыг 1-ээс эхлэн дугаарлахад хэдэн цифр орох вэ?

108 Зурагт хэдэн тэгш өнцөг байгааг олоорой.  
 а. б.



109 Зургийн дугуйлангийн сурагч харандаагаа 5 өдөр дараалан хэмжихэд дараах үр дүн ажиглагдав. Түүний хийсэн туршилтын үр дүнг сантиметрээр ойролцоолон илэрхийлээрэй.

Жишээ нь: Даваа гарагт: 12 см 8 мм (энэ нь ойролцоогоор 13 см болно.)



даваа гарагт: 12 см 8 мм,  
 мягмар гарагт: 10 см 4 мм,  
 лхагва гарагт: 9 см 5 мм,  
 пүрэв гарагт: 7 см 2 мм,  
 баасан гарагт: 5 см 7 мм,

110 Ямар тоо дүрсэлснийг бичээрэй.


З	А	Н
	●	
	●	
●	●	●
●	●	●
●	●	●
●	●	●

З	А	Н
●		
●		
●		
●	●	●
●	●	●
●	●	●

З	А	Н
		●
		●
		●
		●
●		●
●		●
●		●

З	А	Н
	●	
	●	
	●	●
	●	●
	●	●
	●	●
●	●	●


- Нийлбэрийн утга нь хамгийн их гарах 2 тоо аль нь вэ?
- Ялгаврын утга нь хамгийн их гарах 2 тоо аль нь вэ?
- Үйлдэл гүйцэтгэлгүй дээрх 2 асуултад хариулж чадах уу? Хэрхэн олсноо тайлбарлаарай.
- Хариултаа үйлдлээр шалгаарай.


111 Дулмаа 10:00 цагт гэрээсээ гараад,  цагт эргэж ирэв. Хэдэн цагийн дараа ирсэн бэ?

112 Тамир 21 бууз чимхэв. Дөлгөөн түүнээс 19-өөр олон бууз чимхсэн бол тэд нийт хэдэн бууз чимхсэн бэ?

113 Гурван найз байв. Амар Нарангаас өндөр, Наран Солонгоос өндөр бол хэн нь хамгийн өндөр вэ?

114 Цагийн нүүрийг 2 хэсэгт шулуун шугамаар хуваахад хэсэг тус бүрийн тоонуудын нийлбэрийн утга тэнцүү байх боломжтой юу? Ярилцаарай.



115  Номын санч шинээр ирсэн сурах бичгүүдийг дугаарлажээ. Гэтэл түүний компьютерийн нэг товчлуур байхгүйг анзааралгүй бичжээ. Ямар цифр орхигдсоныг олоод, засварыг хийгээрэй.



97	98	99	00	0	02	03	04	05	06	07	08	09	0		2	3
----	----	----	----	---	----	----	----	----	----	----	----	----	---	--	---	---

116 Илэрхийллийн утгыг олоорой.


а.  $87 - 29$ ;  $91 + 19$ ;  $84 - 78$ ;  $69 - 29$ ;  $67 + 39$   
б.  $121 - 19$ ;  $342 + 118$ ;  $187 + 98$ ;  $365 + 116$ ;  $963 - 486$

117 Цээжээр гүйцэтгээрэй.

а.  $9 \times 10$       б.  $8 \times 7$       в.  $9 \times 6$       г.  $5 \times 4$       д.  $7 \times 6$

118 Маргад, Дөлгөөн хоёр мод тарьжээ. Маргад 19 мод, Дөлгөөн түүнээс 2 дахин олон мод тарьсан бол тэд бүгд хэдэн мод тарьсан бэ?

119 Амьтдын нийт хөлийн тоог олоорой.



120 Өгсөн 3 цифрийг ашиглан 3 оронтой тоог хэдэн янзаар зохиож болох вэ? Карт ашиглан туршаарай.


а. 

1	9	8
---	---	---

      б. 

0	3	5
---	---	---

121 Галт тэрэг дээр зорчигчдын тоог бичжээ.



- Тоонуудын зүй тогтлыг ажиглан 4, 5 дугаар галт тэргэнд тус бүр хэчнээн зорчигч сууж байгааг олоорой.
- 3, 4 дүгээр галт тэргэнд нийт хэдэн зорчигч сууж байна вэ?
- 2 дугаар галт тэрэгнээс 40 зорчигч бууж, 1 дүгээр галт тэргэнд 30 зорчигч нэмж суусан бол галт тэргэн дэх зорчигчийн тоо өөрчлөгдөх үү? Яагаад вэ?
- 1 дүгээр галт тэрэгний зорчигчийн тоо 5 дугаар галт тэргэнд суусан зорчигчийн тооноос хэдээр цөөн байна вэ?



122 Илэрхийллийн утгыг олоорой.

$2 \times 42$ ;  $2 \times 19$ ;  $2 \times 28$ ;  $120 - 2 \times 44$ ;  $7 \times 9 + 2 \times 48$

123



Цифрүүд болон үйлдлийн тэмдгийг ашиглан, даалгаврыг гүйцэтгээрэй.

- Дээрх 4 цифр болон хасах үйлдлийн тэмдгийг ашиглан тоон илэрхийлэл зохиож, ялгаврыг олоорой. *Жишээ нь:*  $123 - 4$ ;  $43 - 12$  гэх мэт
- Ялгавар нь хамгийн бага тоо байх илэрхийллийг хэн зохиосон бэ?
- Дээрх 4 цифр болон нэмэх үйлдлийн тэмдгийг ашиглан тоон илэрхийлэл зохиож, нийлбэрийг олоорой. *Жишээ нь:*  $12 + 34$ ;  $413 + 2$  гэх мэт
- Нийлбэр нь хамгийн их тоо байх илэрхийллийг хэн зохиосон бэ?
- Дээрх 4 цифрийг ашиглан, хоёр оронтой тэгш тоо үүсгээрэй.
- Дээрх 4 цифрийг ашиглан, хоёр оронтой сондгой тоо үүсгээрэй.

124 1 дүгээр нэмэгдэхүүнийг 5-аар, 2 дугаар нэмэгдэхүүнийг 3-аар нэмэгдүүлбэл нийлбэр хэрхэн өөрчлөгдөх вэ?

125 2 хүү, 2 аав 3 алимыг нэг, нэгээр идэв. Тэд яаж идсэн бэ?

126



Туулай А1, В4 байршилд очиж, хэдэн лууван нөөцөлж болохыг олъя. А1-д 40 лууван, В4-т 10 лууван. Нийт:  $40 + 10 = 50$  (лууван).

а. Туулай өгсөн нүднүүд дээр очиж хэчнээн лууван нөөцөлсөн бэ?

1. А3, В5; 2. Б1, Д1;
3. А5, В3, Д4; 4. Б1, Д1, Г3;

б. 100 ширхэг лууван нөөцлөхийн тулд ямар, ямар байршилд очих вэ?

200		300	50	100	5
	26	10	53	40	4
700	60	30	500		3
	600		70		2
40	80		800	20	1
А	Б	В	Г	Д	

127 Илэрхийллийн утгыг олоорой.

а.  $91 - 7 \times 6$

б.  $82 + 9 \times 2$

в.  $36 + 8 \times 8$

г.  $10 \times 7 - 12$

д.  $5 \times 8 + 6 \times 10$






е.  $8 \times 3 + 46$

128 Зүй тогтлыг ажиглаад, хүснэгтийг гүйцээгээрэй.

а.

1	5	3
		1
3		

б.

129 Өвөөгийнх тахиа тэжээдэг. Өнөөдөр 47 тахиа өндөглөв. Өндгийг 6 тэнцүү хувааж савлав. Сагс бүрд хэдэн өндөг савласан бэ? Савлаагүй өндөг үлдсэн үү?

130 Саруул өөрийн төлөвлөгөөгөө зургаар харуулжээ.

Эхлэх цаг	Дуусах цаг	Үйл ажиллагаа
		
		
		

а. Саруулын дууны дугуйлан хэдэн минут үргэлжлэх вэ?

б. Тэр хичээлдээ хэдэн цагийн турш суух вэ?

в. Найзуудтайгаа тоглохдоо хэдэн минут зарцуулах вэ?

г. Тэр нийт хэдэн цагийн үйл ажиллагаа төлөвлөсөн байна вэ?

131 Илэрхийллийн утгыг олоорой.

а.  $547 - (86 + 29) - 402$

б.  $230 + (51 - 32) - 138$

в.  $600 - 5 \times 8 + 40$

г.  $63 \div 9 \times 7 + 230$

132 Илэрхийллийг бичээд, утгыг олоорой.

а. 16 ба 79-ийн нийлбэрийг 36-аар хорогдуулах

б. 69 ба 96-ийн нийлбэрийг 81-ээр хорогдуулах


в. 9 ба 10-ын үржвэрийг 96-аар нэмэгдүүлэх

133




Бүжин, хэрэм хоёр гараанаас зэрэг гарав. Өгсөн дүрсүүдээр дайрч, нэгэн зэрэг хоёр чиглэлд явав. Бүжин замыг туулахдаа дүрсийн гадуур, хэрэм дотуур явсан.

- Бүжин хэдэн метр зам туулсан бэ?
- Хэрэм хэдэн метр зам туулсан бэ?
- Хэрэм, бүжин хоёрын хэн нь илүү зам туулсан бэ? Яагаад вэ?
- Хэрвээ бүжин гараанаас гарч, дүрс бүрийг бүтэн тойрч, анхны газартаа ирвэл хэчнээн метр зам туулах вэ?



(Дүрс бүрийн хоорондох зай 3 м байна.)

- 134 Солонго, Хасар хоёрын биеийн жин Халиун, Тулга хоёрын жинтэй тэнцүү. Хасар 36 кг, Тулга 42 кг жинтэй бол Солонго, Халиун хоёрын хэн нь хүнд вэ?
- 135 Цэцэрлэгчид гурван өдөр 92 мод тарив. Эхний өдөр 34 мод, хоёр дахь өдөр 27 мод тус тус тарьсан бол гурав дахь өдөр хэдэн мод тарьсан бэ?
- 136 Тус бүр нь 5 ш, 10 ш, 15 ш, 20 ш, 25 ш, 30 ш, 35 ш, ... ,85 ш, 90 ш, 95 ш-ээр савлагдсан зөөлөн чихрээс 100 ш чихрийг хэчнээн янзаар авах вэ?  
Жишээ:  $5 + 95 = 100$ ;  $5 + 10 + 85 = 100$ ;
- 137 Үйл явдлууд аль улиралд болдог вэ? Ярилцаарай.




- 138 Хоёрдугаар ангид сурсан зүйлсээ улам бататгаж, гуравдугаар ангидаа амжилттай сураарай.

## ӨӨРИЙГӨӨ СОРИОРОЙ

1. Ялгаврын утга нь 34 гарахгүй илэрхийллийн доогуур зураарай.

$18 + 16;$      $51 - 17;$      $71 - 16;$      $27 + 7;$      $93 - 59$

2. Бүх дөрвөлжин дүрсийн тоог нийлбэр хэлбэрээр бичээд, утгыг олоорой.



$\square + \square = ?$

3. Хүүхдүүд мөөг хэлхэв.



Хэлхсэн мөөгний утгад тохирох үржвэр аль нь вэ?

а.  $8 + 8 + 8$     б.  $3 + 3 + 3 + 3 + 3 + 3 + 3 + 3$     в.  $3 \times 8$     г.  $8 \times 3$

4. Харилцан яриаг уншаад, асуултад хариулаарай.



Цаг хэд болж байна вэ?

Урт зүү 7 дээр, богино зүү 2 өнгөрч байна.



Хэдэн цаг болж байсан бэ?

а. 7 цаг 2 мин    б. 2 цаг 7 мин    в. 2 цаг 35 мин    г. 7 цаг 10 мин

5. Гурван талтай, тэгш өнцөгтэй дүрсийг олж, дугаарыг дугуйлаарай.



а



б



в




г



д

6. Дөрвөн тэнцүү хуваасан дүрсийг олж,  $\frac{1}{4}$  бичлэгт тохируулан будаарай.



7. а. Үржвэрийн утгыг олоорой.

$26 \times 2$

б. Өмнөх үржвэрийн утгыг ашиглан бодоорой.

$56 \times 2$